

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 2

— Газрын тухай Монгол Улсын хууль

— Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай Монгол Улсын хууль

— Эрдэнэсийн сангийн тухай Монгол Улсын хууль

— Газрын хэвлийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР

1995 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

(ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ, ШИЙДВЭР, ХУУЛИЙН ТАЙЛБАР)

Монгол Улсын Их Хурлын Тамгын Газар

№ 1995 оны 2 сар № 2 (33)

ГАРЧИГ

1. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1. Газрын тухай 213
2. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай 243
3. Эрдэнэсийн сангийн тухай 262
4. Газрын хэвлийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 269

2. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

5. Газрын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай № 78 282
6. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай № 81 283
7. Дүрэм батлах тухай № 92 284
8. Үнэт цаасны хорооны зарим гишүүнийг томилох тухай № 93 288
9. Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай № 94 289
10. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай № 94 289
11. Газрын хэвлийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай № 96 290
12. Хуучин Югославын Бүгд Найрамдах Македон Улсын түсгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх тухай № 01 291
13. Монголбанкны 1995 оны орлого, зарлагын төсвийг батлах тухай № 02 291
14. Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай № 04 292
15. «Хүүхэд-хөгжил-хамгаалал» сэдэвт үндэсний чуулган байгуулах тухай № 05 292
16. Ажлын хэсэг байгуулах тухай № 06 293

17. Төсвийн хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг шийдвэрлүүлэх тухай № 08 294
18. Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны бүрэлдэхүүнийг тогтоох тухай № 10 295

3. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

19. Самбуугийн Ишбалжирт Монгол Улсын гавьяат багш цол олгох тухай № 158 298
20. Мягмарын Хажидмаад Монгол Улсын гавьяат механик-жуулагч цол олгох тухай № 159 298
21. Дамбын Лхагвасүрэнд Монгол Улсын Хүний гавьяат эмч цол олгох тухай № 160 299
22. Балжирын Хэнмэдэхэвт Монгол Улсын Хүний гавьяат эмч цол олгох тухай № 161 300
23. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай № 162 300
24. Сүрэнгийн Цэрэндолгорт Монгол Улсын гавьяат жүжигчин цол олгох тухай № 163 302

4. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ

25. Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн тухай № 01 303

5. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

26. Журам батлах тухай № 201 320
27. Хууль, зарлигийн хэрэгжилтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай № 204 323
28. Тэтгэвэр авагчдын нэмэгдэл нөхвөрийн тухай № 205 326
29. Тогтоолын заалт хүчингүй болгох тухай № 213 327
30. Мал эмнэлэг, үржлийн албанаас үзүүлэх ажил, үйлчилгээг төлбөртэй явуулах журам, төлбөрийн хэмжээг батлах тухай № 217 327

6. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

31. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай № 206 343
32. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай № 207 343

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

ГАЗРЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах болон түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Газрын тухай хууль тогтоомж

1. Газрын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Газрын хэвлий, ой, ус, хийн мандлын агаар, ургамал, амьтны аймаг болон байгалийн бусад баялгийг ашиглах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохих хууль тогтоомжийн актаар зохицуулна.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1) «газар» гэж газрын гадаргуу, түүний хөрс, ой, ус, ургамал бүхий зохих орон зайн давхаргыг хэлнэ;

2) «газар өмчлөх» гэж тухайн газрыг захиран зарцуулах эрхтэйгээр хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг хэлнэ;

3) «газар эзэмших» гэж тухайн газрыг захиран зарцуулах эрхгүйгээр хуулиар зөвшөөрсөн хүрээнд болон гэрээнд заасны дагуу өөрийн мэдэлд байлгахыг хэлнэ;

4) «газар ашиглах» гэж тухайн газрыг захиран зарцуулах эрхгүйгээр хуулиар зөвшөөрсөн хүрээнд болон гэрээнд заасны дагуу газрын аль нэг шинж чанарыг ашиглах тодорхой үйл ажиллагааг хэлнэ;

5) «газрыг чөлөөлөх» гэж тухайн газрыг эзэмших, ашиглах эрх дуусгавар болоход уг газар дээрх барилга байгуу-

ламж, бусад эд хөрөнгийг шилжүүлэх, газрыг засаж тохижуулах зэргээр хууль болон газар эзэмших, ашиглах гэрээнд зааснаар газрыг өмчлөгчид нь эргүүлэн өгөхөд саадгүй болгохыг хэлнэ;

4 дүгээр зүйл. Газрын талаар төрөөс баримтлах зарчим

Газрын талаар төрөөс дараахь зарчмыг баримтална:

1) газар төрийн хяналт, хамгаалалтад байх;

2) газрын сан нэгдмэл байх;

3) газар өмчлөх, эзэмших, ашиглахад шударга ёс, тэгш байдлыг хангах;

4) газрыг хуульд заасан нөхцөл, журмын дагуу үндсэн зориулалтаар нь үр ашигтай, зохистой ашиглах;

5) хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдалд харшлах, байгаль орчны тэнцвэрт байдлыг алдагдуулах аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх.

5 дугаар зүйл. Газар өмчлөх

1. Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар төрийн өмч мөн.

2. Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно.

3. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэхтэй холбогдсон харилцааг зохих хуулиар зохицуулна.

6 дугаар зүйл. Газар эзэмшигч, ашиглагч

1. Газрыг Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэн (цаашид «иргэн» гэх), аж ахуйн нэгж, байгууллага энэ хуульд заасны дагуу эзэмшиж, ашиглана.

2. Гадаад улсын хуулийн этгээд, иргэн, харьяалалгүй хүнд газрыг төлбөр, хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол, журмаар ашиглуулж болно.

7 дугаар зүйл. Газрын төлбөр

1. Газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага зохих хууль тогтоомж, гэрээний дагуу газрын төлбөр төлнө.

2. Газрын төлбөрийн дээд, доод хэмжээ, газрын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх, түүнээс чөлөөлөх журмыг хуулиар тогтооно.

3. Газрын төлбөрийн орлогыг орон нутгийн төсөвт оруулна. Уг орлогын зохих хэсгийг газар хамгаалах, нөхөн сэргээхэд зориулан зарцуулна.

8 дугаар зүйл. Хилийн цэсийн, газар усны нэрийн болон газрын сангийн зураг, газар усны нэр

1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж бүр хилийн цэсийн, газар усны нэрийн болон газрын сангийн зураттай байна.

2. 1:25000-гаас багагүй масштабтай хилийн цэсийн газар усны нэрийн зургийг Улсын Их Хурал, газрын сангийн зургийг Засгийн газрын эрх бүхий байгууллага тус тус батална.

3. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн, газар усны нэрийн болон газрын сангийн зургийн улсын хэмжээний иж бүрэн хувийг Засгийн газрын эрх бүхий байгууллага; аймаг, нийслэлийн болон сум, дүүргийн зургийг тухайн шатны Засаг дарга тус тус хадгална.

4. Хилийн цэсийн, газар усны нэрийн болон газрын сангийн зургийг хадгалах, ашиглах, тэдгээрт орсон өөрчлөлтийг тусгах журмыг Засгийн газрын эрх бүхий байгууллага тогтооно.

5. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн ба газар усны нэрийн зургийг Улсын Их Хурал батлснаар уг газар усны уламжлалт нэр албан ёсны болсонд тооцогдоно. Газар усны албан ёсны нэрийг зөвхөн Улсын Их Хурал өөрчилнө.

6. Албан ёсны баримт бичигт болон арга хэмжээнд газар усны давхар нэр хэрэглэх, газар усны албан ёсны нэрийг монгол хэлнээс бусад хэлээр орчуулах, бусад хэлний дуудлагаар галиглан бичихийг хориглоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Монгол Улсын газрын нэгдмэл сан, түүний үндсэн ангилал

9 дүгээр зүйл. Газрын нэгдмэл сан

1. Монгол Улсын хил доторх бүх газар нь өмчийн төрлөөс үл хамааран газрын нэгдмэл сан мөн.

2. Газрын нэгдмэл санг газар ашиглалтын үндсэн орчулалт, хэрэгцээг харгалзан ангилна.

10 дугаар зүйл. Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал

Монгол Улсын газрын нэгдмэл санг дараахь байдлаар нгилна:

1) хөдөө аж ахуйн газар;
2) хот, тосгон, бусад суурины газар;
3) зам, шугам сүлжээний газар;
4) ойн сан бүхий газар;
5) усны сан бүхий газар;
6) нөөц газар.

11 дүгээр зүйл. Хөдөө аж ахуйн газар

Хөдөө аж ахуйн газарт бэлчээр, хадлан тариалан, тариалал ургамлын талбай, атаршсан газар, хөдөө аж ахуйн арилга байгууламжийн дэвсгэр, хөдөө аж ахуйн үйлдвэрэлийн хэрэгцээнд зориулсан бусад газар хамаарна.

12 дугаар зүйл. Хот, тосгон, бусад суурины газар

1. Хот, тосгон, бусад суурины газарт хот, тосгон, бусад уурины барилга байгууламж, үйлдвэр, уурхайн дэвсгэр олон нийтийн эдэлбэрийн газар хамаарна.

2. Нийтийн эдэлбэрийн газарт хот, тосгон, бусад суурины гудамж, талбай, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын зэмшлийн бус амралт, зугаалга, биеийн тамирын зориуалттай газар, цэцэрлэг, оршуулгын газар, хог хаягдлын эг, цэвэршүүлэх талбай зэрэг газар хамаарна.

13 дугаар зүйл. Зам, шугам сүлжээний газар

Зам, шугам сүлжээний газарт эрчим хүч, дулаан, усан ангамж, холбоо, мэдээлэл, зам тээврийн зориулалтаар от, тосгон, бусад суурины гадна олгогдсон газар хамаарна.

14 дүгээр зүйл. Ойн сан бүхий газар

Ойн сан бүхий газарт ой мод, загтай газар, модыг нь гтолсон талбай, ойн цоорхой, зурвас болон ойг өсгөн ржүүлэхэд зориулсан газар, мөн ой тэлэн ургах боломжийг ангахуйц ойн захын тодорхой хэсэг газар хамаарна.

15. дугаар зүйл. Усны сан бүхий газар

Усны сан бүхий газарт нуур, цөөрөм, тойром, мөрөн, гол, горхи, булаг, шанд, мөнх цас, мөсөн голын эзэлж байгаа болон усны эрэг орчмын газар хамаарна.

16 дугаар зүйл. Нөөц газар

Нөөц газарт энэ хуулийн 10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5-д заасан газарт хамаараагүй бүх газар хамаарна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Тусгай хэрэгцээний газар

17 дугаар зүйл. Тусгай хэрэгцээний газар

1. Монгол Улс тусгай хэрэгцээний газартай байна.

2. Аймаг, нийслэл, сум, дүүрэг тусгай хэрэгцээний газартай байж болно.

3. Газрын нэгдмэл сангийн аль ч ангиллын газраас улсын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн тусгай хэрэгцээнд авч болно.

18 дугаар зүйл. Тусгай хэрэгцээнд авах газрын зориулалт

1. Улсын тусгай хэрэгцээний газарт дараахь газар хамаарна:

1) улсын тусгай хамгаалалттай газар;

2) хилийн зурвас газар;

3) улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар;

4) гадаад улсын дипломат төлөөлөгчдийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар;

5) мал тууврын улсын чанартай замын газар;

6) аймаг дундын отрын бэлчээр;

7) улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай;

8) улсын хэмжээний аялал, жуулчлал, рашаан, сувиллын газар;

9) шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай.

2. Аймаг, нийслэл, сум, дүүрэг энэ зүйлийн 1 дэх хэс-

гийн 1, 5, 6, 7, 8-д заасан зориулалтаар өөрийн эрх хэмжээнд нийцүүлэн газрыг тусгай хэрэгцээнд авч болно.

19 дүгээр зүйл. Газрыг тусгай хэрэгцээнд авах

1. Газрыг энэ хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 4-т заасан зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг Улсын Их Хурал, үүнээс бусад зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг Засгийн газар тус тус шийдвэрлэнэ.

2. Газрыг аймаг, нийслэлийн тусгай хэрэгцээнд авах асуудлыг тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, сум, дүүргийн тусгай хэрэгцээнд авах асуудлыг тухайн нэгжийн Засаг даргын өргөн мэдүүлснээр сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тус тус шийдвэрлэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Газрын харилцааны талаарх төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын бүрэн эрх

20 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

Улсын Их Хурал газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) газрын талаар төрөөс явуулах нэгдсэн бодлогыг тодорхойлох;

2) газрын төлбөрийн дээд, доод хэмжээг тогтоох;

3) энэ хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 4-т заасан газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, түүний хэмжээ, зааглийг тогтоох;

4) бүс нутгийг хамарсан олон улсын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх болон эдийн засгийн тусгай бүс байгуулах зорилгоор гадаад улсын хуулийн этгээд болон олон улсын байгууллагад ашиглуулах газрын хэмжээ, байршлыг тогтоох.

21 дүгээр зүйл. Засгийн газрын бүрэн эрх

1. Засгийн газар газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) газрын талаар төрөөс явуулах нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж, газрын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулж хангах;

2) газрын суурь үнэлгээ болон Улсын Их Хурлаас тогтоосон хэмжээнд газрын төлбөр тогтоох;

3) энэ хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 4-т зааснаас бусад газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, эрх бүхий байгууллагынхаа мэдэлд шилжүүлэх, эдгээр газрын хэмжээ, зааг, ашиглах журмыг тогтоох;

4) энэ хуулийн 20 дугаар зүйлийн 4-т заасан газрын зааг, ашиглах журмыг тогтоох;

5) Улсын Их Хуралтай зөвшилцөн гадаад улсын хуулийн этгээдэд газар ашиглуулах тухай шийдвэр гаргах;

6) улсын тусгай хэрэгцээнд авсантай холбогдуулан газрыг солих буюу эргүүлэн авах тохиолдолд нөхөх олговор олгох;

7) газрын нэгдмэл сангийн данс бүртгэл, тайлан хөтлөх журам, газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журмыг тогтоох;

8) улсын хил орчмын нутаг дэвсгэрт газрыг гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллагад бэлчээр, хадлангийн зориулалтаар түр хугацаагаар ашиглуулах асуудлыг шийдвэрлэх.

2. Засгийн газрын эрх бүхий байгууллага газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) газрын тухай хууль тогтоомж, газрын харилцааны талаарх Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

2) газрын үндсэн ангилалд хамаарах газрыг тогтоох, газрыг нэг ангиллаас нөгөөд шилжүүлэх;

3) газар зохион байгуулалтын улсын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, газар зохион байгуулалтын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн хоорондын газар зохион байгуулалтыг эрхлэх;

4) энэ хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т зааснаас бусад улсын тусгай хэрэгцээний газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах асуудлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;

5) газрын нэгдмэл сангийн данс бүртгэл, газрын хуваа-

рилалт, ашиглалт, хамгаалалт, тэдгээрийн хөдөлгөөний тайланг жил бүр нэгтгэн Засгийн газарт танилцуулах.

22 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх

1. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) газрын тухай хууль тогтоомж, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих, шаардлагатай гэж үзвэл энэ талаарх Засаг даргын тайланг хэлэлцэх;

2) Засаг даргын өргөн мэдүүлснээр нутаг дэвсгэртээ тухайн жилд газар эзэмшүүлэх, ашиглуулах, хамгаалах хөтөлбөрийг хэлэлцэн батлах;

3) Засаг даргын өргөн мэдүүлснээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшилд байгаагаас бусад газрыг аймаг, нийслэлийн тусгай хэрэгцээнд авах, түүний хэмжээ, зааг, ашиглах журмыг тогтоох.

2. Аймаг, нийслэлийн Засаг дарга газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) газрын талаар төрөөс явуулах нэгдсэн бодлогыг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлж газрын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулж хангах;

2) аймаг, нийслэлд тухайн жилд газар эзэмшүүлэх, ашиглуулах, хамгаалах хөтөлбөрийн төслийг Засгийн газрын эрх бүхий байгууллагатай зөвшилцөн боловсруулж, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;

3) иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшилд байгаагаас бусад газрыг аймаг, нийслэлийн тусгай хэрэгцээнд авах тухай асуудлыг холбогдох сум, дүүргийн Засаг даргатай тохиролцсоны дагуу аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;

4) сум, дүүргийн Засаг даргын саналыг харгалзан аймаг, нийслэлийн хөгжилд чухал ач холбогдол бүхий ажил, үйлдвэрлэл эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглуулах талаар шийдвэр гаргах;

5) аймаг, нийслэлийн тусгай хэрэгцээний газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах тухай шийдвэр гаргах;

6) нутаг дэвсгэрийнхээ газрын нэгдмэл сангийн сум, дүүргийн данс бүртгэл, газрын хуваарилалт, ашиглалт, хамгаалалт, тэдгээрийн хөдөлгөөний тайланг жил бүр хянан нэгтгэж, Засгийн газрын эрх бүхий байгууллагад гаргаж өгөх.

23 дугаар зүйл. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх

1. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) газрын тухай хууль тогтоомж, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих, шаардлагатай гэж үзвэл энэ талаарх Засаг даргын тайланг хэлэлцэх;

2) Засаг даргын өргөн мэдүүлснээр нутаг дэвсгэрийнхээ газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлах;

3) Засаг даргын өргөн мэдүүлснээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшилд байгаагаас бусад газрыг сум, дүүргийн тусгай хэрэгцээнд авах, түүний хэмжээ, зааг, ашиглах журмыг тогтоох.

2. Сум, дүүргийн Засаг дарга газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) нутаг дэвсгэртээ газрын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулж хангах;

2) нутаг дэвсгэртээ газар эзэмшигч, ашиглагчдаас газар, түүний баялгийг хууль тогтоомж болон гэрээнд нийцүүлэн үр ашигтай, зохистой ашиглаж, хамгаалж байгаад хяналт тавих;

3) аймаг, нийслэлд тухайн жилд газар эзэмшүүлэх, ашиглуулах, хамгаалах хөтөлбөрийн төсөл боловсруулахад саналаа өгөх, батлагдсан хөтөлбөрийн дагуу сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөл боловсруулж сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;

4) иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшилд байгаагаас бусад газрыг сум, дүүргийн тусгай хэрэгцээнд авах тухай асуудлыг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;

5) иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах тухай шийдвэр гаргах;

6) сум, дүүргийн тусгай хэрэгцээний газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах тухай шийдвэр гаргах;

7) хууль тогтоомжоор тогтоосон журам, хувь хэмжээг баримтлан газар эзэмшигч, ашиглагчдад газрын төлбөр ногдуулах, авах ажлыг зохион байгуулах;

8) газрын нэгдмэл сангийн сум, дүүргийн данс бүртгэл, газрын хуваарилалт, ашиглалт, хамгаалалт, тэдгээрийн хөдөлгөөний тайланг дээд шатны Засаг даргад гаргаж өгөх.

24 дүгээр зүйл. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх

1. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) бусдын эзэмшил, ашиглалтад олгоогүй газрын нийтийн ашиглалтыг зохицуулах;

2) бусдын эзэмшил, ашиглалтад олгоогүй бэлчээрийн улирлын хуваарь тогтоох, хадлангийн талбайг хуваарилах;

3) баг, хорооны нутаг дэвсгэр дэх нийтийн ашиглалтын газрын эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангуулах;

4) бусдын эзэмшил, ашиглалтад олгоогүй өвөлжөө, хаваржаа Засаг даргын өргөн мэдүүлснээр иргэдэд хуваарилах;

5) газар эзэмшигч, ашиглагчийн газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах шаардлагын биелэлтэд тавих хяналтын талаар Засаг даргын тайланг сонсох.

2. Баг, хорооны Засаг дарга газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) газрын тухай хууль тогтоомж, газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах талаарх нийтлэг шаардлагын биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг нь хангах;

2) дээд шатны байгууллага болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас газрын ашиглалт, хамгаалалтын асуудлаар гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах;

3) нутаг дэвсгэртээ нийтийн ашиглалтын газрын ашиглалт, хамгаалалт, эрүүл ахуй, ариун цэврийн асуудлыг хариуцах.

ТАВДУГААР БҮЛЭГ

Газар зохион байгуулалт, газрын нэгдмэл сангийн данс бүртгэл, тайлан

25 дугаар зүйл. Газар зохион байгуулалт, түүний санхүүжилт

1. Газар зохион байгуулалт нь газрын тухай хууль тогтоомж хэрэгжүүлэх, газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, газрын эдийн засгийн чадавхи нөөцийг нэмэгдүүлэх, газар зүйн таатай орчин бүрдүүлэх зорилго бүхий цогцолбор арга хэмжээ мөн.

2. Газар зохион байгуулалтын арга хэмжээг Засгийн газар, түүний эрх бүхий байгууллага, бүх шатны Засаг даргын шийдвэр, газар эзэмшигч, ашиглагчийн захиалгыг үндэслэн Засгийн газрын эрх бүхий байгууллагаас эрх олгосон мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

3. Газар зохион байгуулалтын журмыг Засгийн газар тогтооно.

4. Газар зохион байгуулалт хийх тухай Засгийн газар, түүний эрх бүхий байгууллага, бүх шатны Засаг даргын шийдвэрийг холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллага биелүүлэх үүрэгтэй.

5. Газар зохион байгуулалтыг дараахь байдлаар санхүүжүүлнэ:

1) засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг тогтоох, өөрчлөх, бүс нутгийн хөгжлийн төлөвийг тодорхойлохтой холбогдсон газар зохион байгуулалтыг улсын төвлөрсөн төсвөөс;

2) аймаг, нийслэл, сум, дүүрэг, хот, тосгон, бусад суурины газар зохион байгуулалтыг орон нутгийн төсвөөс;

3) иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшиж, ашиглаж байгаа газартаа хийлгэх газар зохион байгуулалтыг өөрийн хөрөнгөөр.

26 дугаар зүйл. Газрын нэгдмэл сангийн данс бүртгэл, тайлан

1. Газрын нэгдмэл сангийн данс бүртгэлд газрын нэгдмэл санг газар эзэмшигч, ашиглагчдад хуваарилсан байдал, тэдгээрийн газрын хэмжээ, үнэлгээ, төлбөр, төлөв

байдал, чанар, газрыг хамгаалах талаар авсан арга хэмжээ зэрэг үзүүлэлтийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж тус бүрээр тусгана.

2. Газрын нэгдмэл сангийн тайланд газрын хуваарилалт, ашиглалт, хамгаалалт, тэдгээрийн хөдөлгөөнийг харуулсан зургийг хавсаргасан байна.

3. Газрын нэгдмэл сангийн данс бүртгэл, тайлангийн маягт, тэдгээрийг хөтлөх журмыг Засгийн газар батална.

4. Газрын нэгдмэл сангийн сум, дүүргийн тайланг Засаг дарга тухайн оны 10 дугаар сарын 1-ний байдлаар тасалбар болгон гаргаж 11 дүгээр сарын 15-ны дотор аймаг, нийслэлийн Засаг даргад; газрын нэгдмэл сангийн аймаг, нийслэлийн тайланг Засаг дарга 12 дугаар сарын 31-ний дотор Засгийн газрын эрх бүхий байгууллагад тус тус гаргаж өгнө.

5. Засгийн газрын эрх бүхий байгууллага тухайн оны газрын нэгдмэл сангийн улсын тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор Засгийн газарт танилцуулна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Газар эзэмшүүлэх, ашиглуулах

27 дугаар зүйл. Газар эзэмшүүлэх

1. Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад төрийн өмчийн газрыг энэ хуульд заасан хугацаа, болзолтойгоор гэрээний үндсэн дээр эзэмшүүлнэ.

2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газрыг дундаа эзэмшиж болно.

3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага оршин суугаа (оршин байгаа) сум, дүүрэгтээ газар эзэмших давуу эрхтэй.

28 дугаар зүйл. Эзэмшүүлэх газрын хэмжээ, байршил

1. Иргэнд гэр бүлийнх нь хэрэгцээнд зориулан эзэмшүүлэх хувийн гэр, орон сууцны хашааны газрын хэмжээ 0,05 га-гаас илүүгүй байна.

2. Хот, тосгон, бусад сууринд оршин суугч иргэнд хувийн гэр, орон сууцны хашааны газраас гадна гэр бүлийнх нь хэрэгцээнд зориулан хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, тэжээлийн ургамал тарих зориулалтаар газар эзэмшүүлж болно. Уг газрын хэмжээ 0,1 га-гаас илүүгүй байна.

3. Иргэнд энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан зориулал-

таар тухайн сум, дүүрэгт эзэмшүүлэх газрын дээд хэмжээ, байршлыг хүн амын нягтрал, газрын нөөц, иргэний гэр бүлийн ам бүлийн тоог харгалзан тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

4. Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, тэжээлийн ургамал тарих талбай нь хувийн гэр, орон сууцны хашааны газрын зэргэлдээ, эсхүл уг зориулалтаар тусгайлан тогтоогдсон газарт тусдаа байж болно.

5. Аж ахуйн нэгжид үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд зориулан эзэмшүүлэх газрын дээд хэмжээг Засгийн газар тогтооно.

6. Тухайн аж ахуйн нэгжид эзэмшүүлэх газрын хэмжээ, байршлыг түүний үйлдвэрлэлийн хүчин чадлыг харгалзан сум, дүүргийн Засаг дарга тогтооно.

7. Байгууллагад эзэмшүүлэх газрын хэмжээ, байршлыг үйл ажиллагаатай нь уялдах шаардлагыг нь харгалзан сум, дүүргийн Засаг дарга тогтооно.

29 дүгээр зүйл. Газар эзэмшүүлэх хугацаа

1. Төрийн өмчийн газрыг Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 60 жил хүртэл хугацаатайгаар гэрээгээр эзэмшүүлж болно. Газар эзэмших гэрээг нэг удаад сунгах хугацаа 40 жилээс илүүгүй байна.

2. Иргэн төрийн өмчийн газрыг эзэмших эрхээ өв залгамжлуулан шилжүүлж болно.

3. Газар эзэмшигч нас барсан, нас барсан гэж зарлагдсан, сурагтүй алга болсонд тооцогдсон тохиолдолд уг иргэний хууль ёсны өв залгамжлагч нь газар эзэмших гэрээг өөрийн нэр дээр шилжүүлж авхдагч гэрээнд заасан газар эзэмших хугацаа дуустал газрыг үргэлжлүүлэн эзэмшиж болно.

30 дугаар зүйл. Газар эзэмших тухай хүсэлт гаргах, хүлээн авах

1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар эзэмших тухай хүсэлтээ сум, дүүргийн Засаг даргад гаргана.

2. Иргэн газар эзэмших тухай хүсэлтэд дараахь зүйлийг тусгана:

1) овог, нэр, байнга оршин суугаа хаяг, иргэний паспортын болон регистрийн дугаар;

2) эзэмших газрын засаг захиргаа, нутаг дэвсэрийн харьяалал, хэмжээ, байршлыг харуулсан зураг;

3) газар эзэмших зориулалт, хугацаа.

3. Аж ахуйн нэгж, байгууллага газар эзэмших тухай хүсэлтэд дараахь зүйлийг тусгана:

1) аж ахуйн нэгж, байгууллагын оноосон нэр, харьяалал, хаяг, орших газар;

2) аж ахуйн нэгжийн гэрээ, дүрэм, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

3) үйлдвэрлэлийн хүчин чадал, техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт;

4) эзэмших газрын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн харьяалал, хэмжээ, байршлыг харуулсан зураг;

5) үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, газар эзэмших зориулалт, хугацаа, газрыг ашиглах, хамгаалах төсөл;

6) тухайн аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн байршлын бүдүүвч зураг.

4. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар эзэмших тухай хүсэлтэд төлбөрийн чадварын баталгааг хавсаргана.

5. Сум, дүүргийн Засаг дарга эзэмшилд авахаар хүсэлт ирсэн газрын тухай үг хүсэлтийг хүлээн авмагц нийтэд зарлан мэдээлж, тухайн газрыг эзэмших, ашиглах талаар өөр сонирхогч этгээд байгаа эсэхийг тодруулна.

31 дүгээр зүйл. Газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргах

1. Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 30 дугаар зүйлийн 2, 3, 4, 5 дахь хэсэгт заасан нөхцөл байдлыг хянан үзэж тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад төрийн өмчийн тухайн газрыг эзэмшүүлэх эсэх тухай шийдвэр гаргана.

2. Шийдвэрт газар эзэмших этгээдийн нэр, хаяг, уг газрын хэмжээ, байршил, дангаар буюу дундаа эзэмших талаар нэгбүрчлэн заана. Хэрэв газар эзэмшүүлэхээс татгалзсан бол үүний шалтгаан, үндэслэлийг тодорхой заана.

3. Тухайн газрыг эзэмшихээр хоёр буюу түүнээс дээш этгээд хүсэлт гаргавал сум, дүүргийн Засаг дарга хүсэлт гаргасан этгээдийн оршин суугаа (оршин байгаа) засаг захиргаа, нутаг дэвсгэрийн харьяалал, төлбөрийн чадвар, газар эзэмших зориулалт, ашиглах үр ашиг, байгаль орчин

болон газарт үзүүлэх нөлөөлөл зэргийг харгалзан сонголт хийнэ.

4. Газар эзэмшүүлэх шийдвэрийн талаар үүссэн маргааныг энэ хуулийн 56 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасны дагуу шийдвэрлэнэ.

32 дугаар зүйл. Газар эзэмших гэрээ, түүнийг байгуулах журам

1. Газар эзэмшүүлэх тухай шийдвэрийг үндэслэн сум, дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтан тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгож, уг гэрээг улсын бүртгэлд бүртгэнэ.

2. Газар эзэмших гэрээнд дараахь зүйлийг тусгана:

1) газар эзэмшүүлэх үндэслэл (зохих шийдвэр);

2) газар эзэмших зориулалт;

3) газрын хэмжээ, байршил, заагийг жаруулсан зураг;

4) газрын төлөв байдал, чанар;

5) газар эзэмшүүлэх хугацаа;

6) газрын төлбөрийн хэмжээ, төлөх хугацаа;

7) гэрээний талуудын эрх, үүрэг хариуцлага;

8) газар эзэмших эрх дуусгавар болохоод тухайн газар дээрх барилга байгууламж, бусад эд хөрөнгийг хэрхэх тухай тохиролцоо;

9) эзэмшил газрыг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах нөхцөл, журам;

10) шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.

3. Эзэмшилд олгож байгаа газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг тухайн газар эзэмших гэрээний хавсралт болгоно.

4. Газар эзэмших гэрээний биелэлтийг талууд жил бүр дүгнэнэ.

33 дугаар зүйл. Газар эзэмшигчийн эрх, үүрэг

1. Газар эзэмшигч дараахь эрхтэй:

1) газар эзэмших гэрээнд заасан зориулалтын дагуу уг газрыг ашиглах;

2) газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг газар өмчлөгчөөс гаргуулж авах;

3) газарт учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр тогтоосон журмын дагуу нөхөн төлүүлэх;

4) гэрээний хугацаанд өөрт нь газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлтэйгээр эзэмшлийн газраа бүхэлд нь буюу түүний зарим хэсгийг бусдад ашиглуулах;

5) газрын тухай хууль тогтоомж болон газар эзэмших гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол гэрээний хугацаа дуусахад уг газрыг үргэлжлүүлэн эзэмшихээр гэрээг сунгуулах.

2. Газар эзэмшигч дараахь үүрэг хүлээнэ:

1) газар эзэмших гэрээнд заасан нөхцөл, болзлыг биелүүлэх;

2) газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх;

3) газрын төлбөрийг тогтоосон хугацаанд төлөх;

4) газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг тогтоосон журмын дагуу хийлгэж байх;

5) бусдын газар эзэмших ашгилахтай холбогдсон эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх.

34 дүгээр зүйл. Газар эзэмших эрх дуусгавар болох

1. Газар эзэмших эрх дараахь тохиолдолд дуусгавар болно:

1) газар эзэмших гэрээний хугацаа дууссан;

2) газар эзэмшигч иргэн нас барсан, нас барсан гэж зарлагдсан, сураггүй алга болсонд тооцогдсон тохиолдолд түүний хууль ёсны өв залгамжлагч байхгүй нь тогтоогдсон, газар эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага татан буугдсан;

3) газар эзэмшигч газар эзэмших гэрээг цуцлах тухай хүсэлт гаргасан.

2. Газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээд дараахь тохиолдолд тухайн газар эзэмших эрхийг захиргааны журмаар дуусгавар болгоно:

1) газар эзэмшигч газрын тухай хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг болон газар эзэмших гэрээний нөхцөл, болзлыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

2) газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашигласан нь тогтоогдсон;

3) газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан.

35 дугаар зүйл. Эзэмших эрх дуусгавар болоход газрыг чөлөөлөх

1. Газар эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь газар эзэмших эрх дуусгавар болохоД хууль болон газар эзэмших гэрээнд өөрөөр заагаагүй бол 90 хоногийн дотор уг газрыг чөлөөлж сум, дүүргийн Засаг даргын мэдэлд шилжүүлнэ.

2. Энэ хуулийн 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 2 дахь хэсгийн 1, 2-т заасан үндэслэлийн дагуу газар чөлөөлөхтэй холбогдон гарах зардлыг газар эзэмшиж байсан этгээд өөрөө хариуцна.

3. Эзэмшлийн газар нь байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулд нэрвэгдэж цаашид тухайн зориулалтаар ашиглах боломжгүй болсон тухай мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн, газар эзэмшигч газар эзэмших гэрээгээ цуцлах тухай хүсэлт гаргасан бол уг газрыг засаж тохижуулах зардлыг шаардлагатай тохиолдолд улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж болно, харин уг газар дээрх барилга, байгууламж, бусад эд хөрөнгийг шилжүүлэх зардлыг газар эзэмшиж байсан этгээд өөрөө хариуцна.

36 дугаар зүйл. Гэрээний хугацаа дуусахаас өмнө бусдын эзэмшлийн газрыг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах

1. Засгийн газрын эрх бүхий байгууллага нь гэрээний хугацаа дуусахаас өмнө иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил газрыг улсын тусгай хэрэгцээнд бүхэлд нь буюу зарим хэсгийг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах саналыг тухайн газар эзэмшигчидтэй урьдчилан тохиролцсоны дараа Засгийн газарт гаргаж болно.

2. Засгийн газар нь бусдын эзэмшил газрыг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай Засгийн газрын эрх бүхий байгууллагын санал болон түүний газар эзэмшигчтэй хийсэн урьдчилсан тохиролцоог харгалзан зохих шийдвэр гаргана.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан Засгийн газрын шийдвэрийг үндэслэн Засгийн газрын эрх бүхий байгуул-

лага нь сум, дүүргийн Засаг даргаар дамжуулан газар эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан тухайн газрыг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авна.

4. Хувийн гэр, орон сууцны газрыг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах тохиолдолд түүнийг чөлөөлөх ажлыг зөвхөн 5 дугаар сарын 15-наас 9 дүгээр сарын 15-ны хооронд хийнэ.

5. Бусдын эзэмшил газрыг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авахтай холбогдон үүссэн маргааныг энэ хуулийн 56 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 4-т заасны дагуу шийдвэрлэнэ.

37 дугаар зүйл. Гэрээний хугацаа дуусахаас өмнө бусдын эзэмшил газрыг солих буюу эргүүлэн авахад нөхөх олговор олгох

1. Газар эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь энэ хуулийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэрээ байгуулсны дараа хууль болон уг гэрээнд өөрөөр заагаагүй бол ийнхүү гэрээ байгуулсан өдрөөс хойш 90 хоногийн дотор холбогдох газрыг чөлөөлж сум, дүүргийн Засаг даргын мэдэлд шилжүүлнэ.

2. Бусдын эзэмшил газрыг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай шийдвэрт газар эзэмшигчтэй урьдчилан хийсэн тохиролцоог харгалзан уг газраас салгаж үл болох барилга байгууламж, бусад эд хөрөнгийг тухайн үеийн ханшаар үнэлсэн үнэ, газрыг чөлөөлөх зардлыг тусгана.

3. Газар эзэмшигчид олгох нөхөх олговрыг энэ хуулийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэрээг байгуулахадулсын төвлөрсөн төсвөөс сум, дүүргийн Засаг даргын мэдэлд шилжүүлсэн байна.

4. Энэ хуулийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэрээнд өөрөөр заагаагүй бол сум, дүүргийн Засаг даргаг уг гэрээ байгуулсан өдрөөс хойш 60 хоногийн дотор нөхөх олговрыг уг газрыг эзэмшиж байсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад гаргаж өгнө.

5. Энэ хуулийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэрээнд өөрөөр заагаагүй бол газар эзэмшигч өөрт нь нөхөх олговор бүрэн төлсөн өдрөөс хойш 30 хоногийн дотор уг газрыг чөлөөлнө.

6. Эзэмшил газрыг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авахад олгох нөхөх олговор нь тухайн газар ашиглагчид үл хамаарна.

38 дугаар зүйл. Газар ашиглуулах

1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад төрийн өмчийн газрыг тодорхой зориулалт, хугацаа, болзолтойгоор гэрээний үндсэн дээр, хууль тогтоомжийн дагуу ашиглуулж болно.

2. Хуульд өөрөөр заагаагүй бол бусдын эзэмшил, ашиглалтад олгосон эсэхээс үл хамааран дараахь газрыг нийтээр ашиглана:

1) бэлчээр дэх уст цэг, хужир марз бүхий газар;
2) хот, тосгон, бусад суурины нийтийн эдэлбэрийн газар;
3) зам, шугам сүлжээний газар;
4) ойн сан бүхий газар;
5) усны сан бүхий газар.

3. Газар ашиглах тухай хүсэлт гаргах, түүнийг хянаж шийдвэрлэх, газар ашиглах гэрээний агуулгыг тогтоох, түүнийг байгуулахад энэ хуулийн 30, 31, 32 дугаар зүйлийн 1, 3, 4 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1—8, 10-т заасан журмыг баримтална.

4. Газар эзэмшигч нь түүнд газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлтэйгээр тухайн газраа бүхэлд нь буюу түүний зарим хэсгийг бусдад ашиглуулж болно.

5. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан тохиолдолд газар эзэмшигч, ашиглагч хоорондоо гэрээ байгуулах бөгөөд түүнд энэ хуулийн 32 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг 1—8, 10-т заасан зүйлийг газар ашиглахад нийцүүлэн тусгана.

39 дүгээр зүйл. Газар ашиглагчийн эрх, үүрэг

Газар ашиглагч нь энэ хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2; мөн зүйлийн 2 дахь хэсэгт болон бусад хууль тогтоомжид заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

40 дүгээр зүйл. Бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг нийтийн эдэлбэрт болон тусгай хэрэгцээнд ашиглах

1. Засгийн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга газар эзэмшигч, ашиглагчтай урьдчилан тохиролцон

гэрээ байгуулсны үндсэн дээр бусдын эзэмшил, ашиглалтад байгаа төрийн өмчийн газрыг тодорхой хугацаатайгаар нийтийн эдэлбэрт болон тусгай хэрэгцээнд төлбөртэй буюу төлбөргүйгээр ашиглаж болно.

2. Засгийн газар нийгмийн зайлшгүй шаардлагыг үндэслэн бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг уг шаардлага арилтал захиргааны журмаар нийтийн эдэлбэрт болон тусгай хэрэгцээнд төлбөртэйгээр буюу төлбөргүйгээр ашиглах тухай шийдвэр гаргаж болно.

41 дүгээр зүйл. Газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болоход газар дээрх эд хөрөнгийн эрхийг шилжүүлэх

1. Газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болоход хуульд болон энэ хуулийн 32 дугаар зүйл, 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 38 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэрээнд өөрөөр заагаагүй бол уг газар дээрх барилга байгууламж, бусад эд хөрөнгө өмчлөгч этгээдийн тэрхүү эд хөрөнгөө тухайн газар дээр ашиглах эрх дуусгавар болно.

2. Газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болоход энэ хуулийн 32 дугаар зүйл, 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 38 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэрээнд өөрөөр заагаагүй бол тухайн газрын эзэмшиж, ашиглаж байсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газрыг анхны байдалд оруулж өгнө.

3. Газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болоход газар дээрх барилга байгууламж, бусад эд хөрөнгийн талаар үүссэн маргааныг энэ хуулийн 56 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т заасны дагуу шийдвэрлэнэ.

42 дугаар зүйл. Бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газарт нэвтрэх, дайран өнгөрөх

1. Бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газарт нэвтрэх, дайран өнгөрөхийг хориглосон дохио тэмдэг тавих, хашаа барих зэргээр тусгайлан хамгаалаагүй бол хэн боловч тухайн газарт хохирол учруулахгүйгээр нэвтэрч, дайран өнгөрч болно.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хориглох дохио

тэмдгийн загвар, түүнийг хэрэглэх журмыг Засгийн газрын эрх бүхий байгууллага тогтооно.

43 дугаар зүйл. Бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглах

1. Үл хөдлөх хөрөнгө өмчлөгч нь эд хөрөнгөө ашиглах, хамгаалах нөхцөлийг бүрдүүлэхээр бусдын газраар дайран өнгөрөх зам, цахилгаан, холбооны болон инженерийн шугам татах, гарц гаргах болон бусад зориулалтаар бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг ашиглахыг шаардах эрхтэй.

2. Газар эзэмшигч, ашиглагч болон уг газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглахаар шаардаж буй этгээдийн хооронд хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглах эрх үүснэ.

3. Газар эзэмшигч, ашиглагч нь газраа бусдад хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглуулснаас уг газрыг зориулалтын дагуу ашиглах боломжгүй болвол тийнхүү ашиглахыг зогсоохыг газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглаж байгаа этгээдээс шаардах эрхтэй.

4. Газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглахтай холбогдон үүссэн маргааныг энэ хуулийн 56 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т заасны дагуу шийдвэрлэнэ.

44 дүгээр зүйл. Газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглах эрх хадгалагдах

1. Тухайн газрыг эзэмших, ашиглах эрх өөр этгээдэд шилжихэд газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглах бусдын эрх хадгалагдана.

2. Газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглах эрхийг энэ хуулийн 43 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан эд хөрөнгийг өмчлөгч бус этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

45 дугаар зүйл. Гадаад улсын болон олон улсын байгууллага, хуулийн этгээдэд газар ашиглуулах

1. Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт ашиглуулах газрын хэмжээ, төлбөрийн хэмжээг тогтооход

шаардлагатай гэж үзвэл тухайн улстай харилцан адил байх зарчмыг баримтлана.

2. Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт газар ашиглуулах нөхцөл, журмыг Монгол Улсын олон улсын гэрээгээр тогтооно.

3. Гадаад улсын хуулийн этгээдэд газар ашиглуулах асуудлыг энэ хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5-д заасан журмын дагуу Засгийн газар шийдвэрлэнэ.

46 дугаар зүйл. Гадаадын төрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулах

1. Гадаадын төрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулахтай холбогдсон харилцааг Гадаадын төрөнгө оруулалтын тухай хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн холбогдох заалтаар зохицуулна.

2. Гадаадын төрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид ашиглуулсан газрын төлбөрийн хэмжээг Монгол Улсын аж ахуйн нэгжийн эзэмшилд байгаа ижил төрлийн газрынхтай нэгэк адил тогтооно. Шаардлагатай гэж үзвэл тухайн бүс нутаг, эсхүл төрөнгө оруулагч улсад мөрдөж буй газрын төлбөрийн жишгийг баримталж болно.

3. Газрыг хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэсэн болон байгаль орчинд ивээлтэй технологиор ашиглаж байгаа гадаадын төрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газрын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх, тодорхой хугацаагаар газрын төлбөрөөс чөлөөлөх асуудлыг энэ хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хуулийн дагуу шийдвэрлэнэ.

4. Тухайн газрыг ашиглахаар гадаадын төрөнгө оруулалттай хоёр буюу түүнээс дээш аж ахуйн нэгж хүсэлт гаргавал дараахь үзүүлэлтээр сонголт хийнэ:

1) газар ашиглах зориулалт;
2) үйлдвэрлэл эрхлэх төрөнгийн чадварын баталгаа;
3) үйлдвэрлэлд хэрэглэх техник, технологийн дэвшилттэй тал;
4) байгаль орчин болон газарт үзүүлэх нөлөөлөл;
5) газрын төлбөрийн хэмжээний талаарх санал.

47 дугаар зүйл. Гадаадын иргэн, харьяалалгүй хүнд газар ашиглуулах

1. Монгол Улсад байнга (183 хоногоос дээш хугацаагаар) оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд

газрыг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар төлбөр, хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол, журмаар ашиглуулж болно.

2. Гадаадын иргэн, харьяалалгүй хүнд газрыг 5 жил хүртэл хугацаагаар гэрээгээр ашиглуулж болно. Газар ашиглах гэрээг нэг удаад сунгах хугацаа 5 жилээс илүүгүй байна.

3. Гадаадын иргэн, харьяалалгүй хүнд бэлчээрийн мал аж ахуй, үр тарианы үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар газар ашиглуулахгүй.

4. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн газар ашиглах тухай хүсэлт гаргахын өмнө гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн эрх бүхий байгууллагаас тодорхойлолт авна.

5. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн газар ашиглах тухай хүсэлт гаргах, түүнийг хянаж шийдвэрлэх, газар ашиглах гэрээний агуулгыг тогтоох, түүнийг байгуулахад энэ хуулийн 30, 31 дүгээр зүйл, 32 дугаар зүйлийн 1, 3, 4 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1—8, 10-т заасан журмыг баримтална.

6. Тухайн газрыг ашиглахаар хоёр буюу түүнээс дээш гадаадын иргэн, харьяалалгүй хүн хүсэлт гаргавал энэ хуулийн 46 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан үзүүлэлтээр сонголт хийнэ.

7. Гадаадын иргэн, харьяалалгүй хүнд газар ашиглуулахтай холбогдсон бусад харилцааг энэ хуулийн холбогдох заалтаар зохицуулна.

48 дугаар зүйл. Зарим этгээдийн газар ашиглах эрх дуусгавар болоход газар дээрх эд хөрөнгийн эрх дуусгавар болох

Энэ хуулийн 45, 46, 47 дугаар зүйлд заасан этгээдийн газар ашиглах эрх дуусгавар болоход хууль болон газар ашиглах гэрээнд өөрөөр заагаагүй бол уг газар дээрх барилга байгууламж, бусад эд хөрөнгө өмчлөгч этгээдийн тэрхүү эд хөрөнгөө тухайн газар дээр ашиглах эрх дуусгавар болно.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах

49 дүгээр зүйл. Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах нийтлэг шаардлага

Газар эзэмшигч, ашиглагч нь газрыг үр ашигтай, зохис-

той ашиглах, хамгаалах талаар дараахь шаардлагыг биелүүлнэ:

1) газрын төлөв байдал, чанарыг хадгалах, байгалийн аясаар болон хүний үйл ажиллагааны улмаас хөрсний үржил шим буурах, газрын ургамлын бүрхэвч талхлагдах, хөрс элэгдэх, эвдрэх, хуурайших, намагжих, давсжих, бохирдох, хордохоос сэргийлэх арга хэмжээг өөрийн зардлаар авах;

2) эвдэрч гэмтсэн газрыг тухай бүр нөхөн сэргээж байх;

3) сорилт туршилтын ажил, ашигт малтмалын эрэл хайгуулын явцад газрын төрх байдлыг өөрчлөхөд хүрвэл түүнийг нөхөн сэргээх, засаж тохижуулах;

4) газар, түүний баялаг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахдаа байгаль орчин болон газарт сөрөг нөлөө үзүүлэхгүй байх;

5) ойн төгөл, ховор болон ховордсон амьтан, ургамал, түүх, соёлын дурсгалт зүйл бүхий газрыг хадгалах, хамгаалах;

6) төрийн өмчийн газар, бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газарт болон байгаль орчинд сөрөг нөлөөлөх үйл ажиллагаа явуулахгүй байх.

50 дугаар зүйл. Газрыг ашиглах эрүүл ахуйн шаардлага

1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар ашиглахтай холбогдолтой зураг төсөл боловсруулах, шинэ технологи нэвтрүүлэх, Монгол Улсад өмнө нь сорьж, шалгаагүй химийн бодис, бордоог газарт хэрэглэхдээ зохих мэргэжлийн эрх бүхий байгууллагаар экологийн магадлан шинжилгээг өөрийн зардлаар хийлгэнэ.

2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчны тэнцвэрт байдал, хүн амын эрүүл мэнд, мал, амьтан, агаар, ой, ус, ургамалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламж, тоног төхөөрөмж байршуулах, үйлдвэрлэлийн хаягдал, бохир ус, хортой болон бусад бодисыг газрын дор хадгалах, булах ажлыг зохих мэргэжлийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр гүйцэтгэнэ.

3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан ажлыг гүйцэтгэхийн өмнө энэ тухайгаа аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад урьдчилан мэдэгдэж, хүн амд мэдээлж энэ газрын хил, заагийг тэмдэг-

жүүлж, сэрэмжлүүлэх байнгын дохио тэмдэгтүүд өөрийн хөрөнгөөр байрлуулна.

51 дүгээр зүйл. Бэлчээр, түүнийг зохистой ашиглах, хамгаалах

1. Газрын нэгдмэл сангийн ангиллаар мал, амьтан бэлчээхэд зориулан хөдөө, аж ахуйн газарт хамааруулсан газрыг бэлчээр гэнэ.

2. Сум, дүүргийн Засаг дарга зохих мэргэжлийн байгууллагатай хамтран бэлчээрт газар зохион байгуулалтын арга хэмжээ санаачилж бэлчээрийг хамгаалах, ачааллыг нь зохицуулах арга хэмжээ авна.

3. Бэлчээрийг ашиглахдаа түүний уламжлалт тогтолцоо болох өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа гэсэн ерөнхий хуваарийг баримтална. Зуслан, намаржаа болон отрын бэлчээрийг баг, хот айлаар хуваарилж нийтээр ашиглана.

4. Ойн сан бүхий газрыг зохих хууль тогтоомжийн дагуу бэлчээрт ашиглаж болно.

5. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь байгаль орчин, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан нутаг дэвсгэртээ бэлчээрийн болон суурин мал малладааны бүс нутгийг тогтоож болно.

6. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга даац хэтэрсэн, талхлагдсан бэлчээрийг малын хөлөөс чөлөөлөх, малын тоог хязгаарлах зэрэг бэлчээрийг хамгаалах арга хэмжээ авч болно.

7. Байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын улмаас өөр аймаг, сумын нутаг дэвсгэрт нүүдэллэх шаардлага гарвал зохих шатны Засаг дарга нар уг асуудлыг тохиролцон шийдвэрлэнэ. Хэрэв тохиролцохгүйд хүрвэл уг асуудлыг тэдгээрийн дээд шатны Засаг дарга буюу Засгийн газар шийдвэрлэнэ.

8. Энэ зүйлийн 7 дахь хэсэгт заасан шийдвэрийг холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллага биелүүлэх үүрэгтэй.

52 дугаар зүйл. Хадлангийн талбайг зохистой ашиглах, хамгаалах

1. Сум, дүүргийн Засаг дарга мэргэжлийн зохих байгууллагатай хамтран хадлангийн талбайд газар зохион

байгуулалтын арга хэмжээ санаачилж, түүнийг хамгаалах арга хэмжээ авна.

2. Сум, дүүргийн Засаг дарга хадлан авах бололцоотой талбайг жил бүр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулахаар баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын хуваарийг үндэслэн олгож, тэдгээрт түүний хамгаалалтыг хариуцуулж болно.

3. Хадлангийн талбайд 5 дугаар сарын 15-наас 9 дүгээр сарын 1-нийг хүртэл хугацаанд мал, амьтан бэлчээхийг хориглоно.

4. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага сум, дүүргийн Засаг даргатай тохиролцон бэлчээрийн зохих ургацтай хэсгийг хадлангийн талбай болгон ашиглаж болно.

53 дугаар зүйл. Тариалангийн талбайг зохистой ашиглах ,хамгаалах

1. Энэ хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, энэ зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд шинээр тариалангийн талбай бий болгох асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

2. Тариалангийн талбайг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах анхны хугацаа нь 5 жилээс доошгүй 25 жилээс илүүгүй байна.

3. Тариалангийн зориулалтаар газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хөрсийг хамгаалах, түүний үржил шимийг бууруулахгүй байх арга хэмжээ байнга авч, хууль тогтоомжид заасан хугацаа, журмын дагуу тухайн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг хийлгүүлнэ.

4. Иргэн өвөлжөөндөө байгаа хувийн гэр, орон сууцны хашааны газартаа гэр бүлийнхээ хэрэгцээнд зориулан хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, тэжээлийн ургамал тарьж болно.

5. Мал, амьтан бэлчээхэд тусгайлан зориулснаас бусад тохиолдолд тариалангийн талбайд үр суулгаснаас ургац хурааж дуусах хүртэл хугацаанд мал, амьтан бэлчээхийг хориглоно.

54 дүгээр зүйл. Газрын нэгдмэл санд төрийн хяналт тавих

1. Газрын нэгдмэл санг эзэмших, ашиглах, хамгаалах болон газрын тухай хууль тогтоомжийн биелэлтэд Засгийн

газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчид, Засаг дарга энэ хуульд заасан бүрэн эрхийнхээ дагуу хяналт тавина.

2. Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих мэргэжлийн хяналтыг хууль тогтоомжийн дагуу эрх олгогдсон байгаль орчны хяналтын болон газар, ургамал, хорио цээр, эрүүл ахуй, геологи, уул уурхайн зэрэг мэргэжлийн байгууллага хэрэгжүүлнэ.

55 дугаар зүйл. Газрын төлөв байдал, чанарын улсын хяналт баталгаа, түүнийг гаргах

1. Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах үйл ажиллагаанд төрийн хяналтыг тасралтгүй хэрэгжүүлэх зорилгоор газрын төлөв байдал, чанарын тогтвортой гол үзүүлэлтүүдийг хууль тогтоомжид заасан хугацаанд давтан тодорхойлж улсын хяналтад авсан анхны үзүүлэлтүүдтэй харьцуулан дүгнэлт гаргахыг газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа гэнэ.

2. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг дараахь үзүүлэлтээр гаргана:

1) хөрсний үржил шим ус давхаргын зузаан;
2) хөрсний ялзмагийн агууламж;
3) хөрсний бохирдолт, хордолт;
4) газрын гадаргын төрх байдлын өөрчлөлт;
5) ургамлын тусгац бүрхэвчийн өөрчлөлт;
6) бэлчээр, хадлангийн талбайн ургамлын зүйлийн бүрэлдэхүүний өөрчлөлт.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үзүүлэлт дээр тухайн газрын онцлогийг харгалзан нэмж хэрэглэх үзүүлэлтийг Засгийн газар; газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны үзүүлэлтийг тодорхойлох аргачиллыг Засгийн газрын эрх бүхий байгууллага тус тус тогтооно.

4. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг Засгийн газраас эрх олгосон мэргэжлийн байгууллага гийж дүгнэлт гаргана.

5. Газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газрыг 5 жилд нэг удаа газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаанд заавал хамруулах бөгөөд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болоход энэхүү баталгааг гаргана.

6. Газрын төлөв байдал, чанарыг газар эзэмшигч, ашиглагч, бусдын ашиглалтад олгоогүй улсын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн тусгай хэрэгцээний газрын төлөв байдал, чанарыг Засгийн газрын эрх бүхий байгууллага болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга; бусад газрын төлөв байдал, чанарыг сум, дүүргийн Засаг дарга тус тус хариуцна.

7. Газар эзэмшигч, ашиглагч нь газрынхаа төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг өөрийн хөрөнгөөр; анх удаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад олгож байгаа болон бусад газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг улсын төвлөрсөн буюу орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

8. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх ажлын үнэлгээг Засгийн газар тогтооно.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

56 дугаар зүйл. Газартай холбогдон үүссэн маргааныг хянан шийдвэрлэх

1. Газартай холбогдон үүссэн дараахь маргааныг дор дурдсан байгууллага, албан тушаалтан шийдвэрлэнэ:

1) төрийн өмчийн газрыг эзэмших, ашиглах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон Засаг даргын хооронд үүссэн маргааныг тухайн Засаг даргын дээд шатны албан тушаалтан, байгууллага;

2) газар эзэмших, ашиглах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүссэн маргаан, газар ашиглах гэрээний нөхцөл, болзлын талаар газар эзэмшигч ба ашиглагчийн хооронд үүссэн маргааныг зохих шатны Засаг дарга;

3) газрын төлөв байдал, чанар, түүнийг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах талаар үүссэн маргааныг хууль тогтоомжийн дагуу зохих мэргэжлийн байгууллагын хяналт хариуцсан албан тушаалтан буюу зохих шатны Засаг дарга;

4) бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглах талаар болон газартай холбогдон үүссэн эд хөрөнгийн маргааныг шүүх.

2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газартай холбогдон үүссэн маргааны талаар энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3-т заасан байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл уг маргааныг тэдгээрийн дээд шатны албан тушаалтан, байгууллага, эсхүл шүүхээр шийдвэрлүүлнэ.

3. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн ашиглаж буй газартай холбогдон үүссэн маргааныг Монгол Улсын олон улсын гэрээ болон талуудын хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

57 дугаар зүйл. Хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, үйлдлийг таслан зогсоох

Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан өөрийн шийдвэр, үйлдэл (эс үйлдэхүй)-ээрээ газрын тухай хууль тогтоомж, газар эзэмшигч, ашиглагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол уг байгууллага, албан тушаалтан өөрөө буюу түүний дээд шатны байгууллага, албан тушаалтан, эсхүл шүүх уг хууль бус шийдвэрийг хүчингүй болгож, үйлдлийг таслан зогсооно.

58 дугаар зүйл. Хохирлыг нөхөн төлүүлэх

1. Газарт хохирол учруулсан гэм буруутай этгээд эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээсэн эсэхээс үл харгалзан уг хохирлыг өөрийн хүч хөрөнгөөр арилгах арга хэмжээ авах бөгөөд хэрэв мэргэжлийн байгууллагаар уг арга хэмжээг гүйцэтгүүлсэн бол үүнтэй холбогдон гарсан зардлыг бүрэн хариуцна.

2. Газарт нөхөн сэргээгдэшгүй хохирол учруулсан гэм буруутай этгээд эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээсэн эсэхээс үл харгалзан уг газрыг засаж тохижуулахад шаардагдах хэмжээний зардлыг нөхөн төлнө.

3. Газарт учирсан хохирол мэдэгдэж байхад уг газрыг эзэмшилдээ шилжүүлэн авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь түүний өмнөх эзэмшигчтэй өөрөөр тохироогүй бол энэ хохирлыг өөрийн хөрөнгөөр арилгана.

59 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

1. Газрын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд түүний гэм буруу, зөрчлийн шинж байдал, учруулсан хохирлын

хэмжээг харгалзан эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

2. Газрын тухай хууль тогтоомж дараахь байдлаар зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, байгаль орчны хяналтын улсын байцаагч дор дурдсан шийтгэл ногдуулна:

1) албан тушаалтан албан ёсны баримт бичигт газар усны давхар нэр хэрэглэсэн, газар усны албан ёсны нэрийг монгол хэлнээс бусад хэлээр орчуулсан, бусад хэлний дуудлагаар галиглан бичсэн бол 1000 хүртэл төгрөгөөр торгох;

2) хашаа барих, хориглосон дохио тэмдэг тавих зэргээр тусгайлан хамгаалагдсан бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газарт нэвтрэн орсон, дайран өнгөрсөн бол 3000 хүртэл төгрөгөөр торгох;

3) бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглах эрх бүхий этгээдэд уг газрыг энэ хуулийн 43 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зориулалтаар ашиглахад нь санаатайгаар саад учруулсан бол 5000 хүртэл төгрөгөөр торгох;

4) газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болоход хууль болон гэрээнд заасан хугацаанд уг газрыг чөлөөлөөгүй бол 10000 хүртэл төгрөгөөр торгох;

5) газар эзэмших, ашиглах тухай гэрээг улсын бүртгэлд бүртгүүлээгүй, хугацаа дууссан гэрээний дагуу газрыг эзэмшиж, ашиглаж байгаа, эзэмшил, ашиглалтад байгаа газрынхаа төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг хугацаанд нь хийлгээгүй бол 1000—15000 төгрөгөөр торгох;

6) нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авахаар шийдвэрлэсэн газрыг хууль болон гэрээнд заасан хугацаанд нь чөлөөлөөгүй бол 3000—15000 төгрөгөөр торгох;

7) эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр шинээр тариалангийн талбай бий болгосон бол 2000—20000 төгрөгөөр торгох;

8) эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр, зөвшөөрөлгүйгээр газрыг ашигласан, захиран зарцуулсан бол тухайн газрыг чөлөөлүүлж хууль бусаар олсон орлогыг хураажс 25000 хүртэл төгрөгөөр торгох;

9) газарт ноцтой хохирол учруулсан, энэ хуулийн 49 дүгээр зүйлийн 1, 2, 3; 50 дугаар зүйлийн заалтыг зөрчсөн бол 3000—25000 төгрөгөөр торгох;

10) бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг эзэмшигч, ашиглагчтай нь тохиролцолгүйгээр ашигласан бол хууль бусаар олсон орлогыг хураажа 5000—25000 төгрөгөөр торгох.

60 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын
дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 11 дүгээр
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсч өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, танин мэдэх зорилгоор газар нутгийг тусгай хамгаалалтад авах, ашиглах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж

1. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль

тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Газрын тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал

1. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг дараахь байдлаар ангилна:

1) дархан цаазат газар;
2) байгалийн цогцолборт газар;
3) байгалийн нөөц газар;
4) дурсгалт газар.

2. Аймаг, нийслэл, сум, дүүрэг өөрийн нутаг дэвсгэрт байгаа тодорхой газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авч болно.

4 дүгээр зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүс

1. Дархан цаазат болон байгалийн цогцолборт газрын хилийн заагтай залгаа орших, тухайн газар нутгийг хамгаалахад иргэдийг татан оролцуулах, тэдгээрийн амьдралын нөхцөлийг дээшлүүлэх зорилго бүхий үйл ажиллагаа явуулахаар тогтоосон тодорхой газар нутгийг орчны бүс гэнэ.

2. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн заагийг зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн саналыг харгалзан тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид «төрийн захиргааны төв байгууллага» гэх) тогтооно.

5 дугаар зүйл. Улсын хилийн болон хил орчмын газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах

1. Улсын хил орчмын тодорхой нутаг дэвсгэрийг хил залгаа улстай тохиролцсоны үндсэн дээр улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангилалд хамруулж болно.

2. Улсын хил орчмын газар нутгийг улсын тусгай хам-

гаалалтад авах асуудлыг шийдвэрлэхдээ Улсын хил хамгаалах байгууллагатай урьдчилан зөвшилцсөн байна.

3. Улсын хил хамгаалах байгууллага нь зохих хууль тогтоомжийн дагуу улсын хилийн болон хил орчмын дэглэмд нийцүүлэн улсын хил дээрх болон улсын хил орчмын тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх журмыг хамгаалалтын захиргаа буюу зохих шатны Засаг даргатай тохиролцон тогтооно.

4. Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалуулах зорилгоор хилийн төлөөлөгч, орлогч, туслагчид байгаль орчны хяналтын улсын байцаагчийн бүрэн эрхийг төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр олгож болно. Хилийн төлөөлөгч, орлогч, туслагч байгаль орчны хяналтын улсын байцаагчийн бүрэн эрхийг зөвхөн хилийн бүсэд хэрэгжүүлнэ.

6 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтыг санхүүжүүлэх

1. Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах ажлын төсөв нь байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг нөхөн сэргээх, газрыг засаж тохижуулах арга хэмжээг хэрэгжүүлэх, мониторингийн аргаар судалгаа, шинжилгээ хийх, сурталчлах зардал, ажиллагсдын цалин хөлс зэргээс бүрдэнэ.

2. Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах ажлыг санхүүжүүлэх хөрөнгө нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

1) улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт;

2) аялал, жуулчлалын болон бусад ажил, үйлчилгээний орлого;

3) иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, тусламж;

4) тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийн учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлого.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Дархан цаазат газар, түүний хамгаалалтын дэглэм

7 дугаар зүйл. Дархан цаазат газар

Байгалийн бүс, бүслүүрийн онцлог, хэв шинжийг төл-

лөөлж чадах унаган төрхөө хадгалсан байдал, шинжлэх ухааны онцгой ач холбогдлыг нь харгалзан байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг дархан цаазат газар гэнэ.

8 дугаар зүйл. Дархан цаазат газрын бүс

Дархан цаазат газрыг байгалийн хэв шинж; төлөв байдал, хөрс, ус, ургамал, амьтны аймгийн онцлог, хүний үйл ажиллагаанд өртөх байдал зэргийг харгалзан дараахь бүсэд хуваана:

1) онгон бүс;

2) хамгаалалтын бүс;

3) хязгаарлалтын бүс.

9 дүгээр зүйл. Онгон бүсийн дэглэм

1. Онгон бүсэд байгалийн унаган төрх, хэв шинжийг нь хадгалах шаардлагад нийцүүлж зөвхөн хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлнэ.

2. Онгон бүсэд байгалийн төлөв байдлыг нь хөндөхгүйгээр зөвхөн ажиглах хэлбэрээр судалгаа, шинжилгээний ажил явуулж болох бөгөөд үүнээс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

10 дугаар зүйл. Хамгаалалтын бүсийн дэглэм

Хамгаалалтын бүсэд энэ хуулийн 9 дүгээр зүйлд зааснаас гадна ургамал, амьтны аймгийн өсч үржих нөхцөлийг хангах, байгалийн гамшгаас учирсан хор уршгийг арилгахтай холбогдсон биотехникийн арга хэмжээг байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр хэрэгжүүлнэ.

11 дүгээр зүйл. Хязгаарлалтын бүсийн дэглэм

Хязгаарлалтын бүсэд байгаль орчинд нь сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр зохих зөвшөөрөлтэйгээр дараахь үйл ажиллагаа явуулж болно:

1) энэ хуулийн 9, 10 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа;

2) хөрс, ургамлын бүрхэвчийг нөхөн сэргээх;

3) ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх;

4) ан амьтны тооллого, тэдгээрийн тоо, нас, хүйс, сүргийн бүтцийг зохицуулах үйл ажиллагааг батлагдсан хөтөлбөр, аргачлалын дагуу явуулах;

5) рашаан, эмчилгээ, сувилгааны чанартай бусад эрдсийг ашиглах;

6) байгалийн аялал, жуулчлалыг тогтоосон зам, чиглэлээр зохих журмын дагуу зохион байгуулах;

7) аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаар зохих журмын дагуу барьсан орон байрыг ашиглах;

8) зураг авах, дууны болон дүрс бичлэг хийх, тэдгээрийг зохиол, бүтээл туурвихад ашиглах;

9) уул, овоо тахих, уламжлалт зан үйлийн бусад ёслол үйлдэх;

10) нутгийн оршин суугчид ахуйн хэрэгцээндээ зориулан байгалийн дагалт баялаг, эмийн болон хүнсний ургамлыг зохих журмын дагуу түүж ашиглах.

12 дугаар зүйл. Дархан цаазат газарт хориглох үйл ажиллагаа

Дархан цаазат газарт энэ хуулийн 10, 11 дүгээр зүйлд зааснаас өөр зориулалтаар дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

1) газар хагалах, ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, элс, хайрга чулуу авах, мод, зэгс, шагшуурга бэлтгэх, хязгаарлалтын бүсээс бусад газарт зам тавих зэргээр байгалийн төлөв байдлыг өөрчлөх;

2) байгалийн дагалт баялаг, эмийн, хүнсний болон техникийн зориулалттай ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх;

3) энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 4-т зааснаас өөр зориулалтаар ан амьтан агнах, барих, үргээх, тэдгээрийн үүр, инээ, нүх, ноохойг хөндөх, эвдэж сүйтгэх;

4) хортон шавьж, мэрэгчид, түймэртэй тэмцэх, тэдгээрээс сэргийлэх арга хэмжээнд байгаль орчинд сөрөг нөлөөлөх арга, техник, бодис хэрэглэх;

5) энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 7-д зааснаас өөр барилга байгууламж барих;

6) хөрс, ус, агаар бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулах;

7) тухайн газрын хамгаалалтын захиргааны зөвшөөрөлгүйгээр нохой дагуулж, буу авч явах;

8) аргагүйгээс бусад тохиолдолд тухайн газрын хамгаалалтын захиргаанаас урьдчилан авсан зөвшөөрөлгүйгээр агаарын хөлгөөр буулт хийх, хэт нам өндрөөр нислэг үйлдэх;

9) өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн барилга

байгууламж барих, зохих зөвшөөрөлгүйгээр мал бэлчээрлүүлэх;

10) нуур, мөрөн, гол, горхи, булаг, шанд зэрэг ил задгай усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах;

11) хууль тогтоомж болон хамгаалалтын горимоор хориглосон байгаль орчинд сөрөг нөлөөлөх бусад үйл ажиллагаа явуулах.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Байгалийн цогцолборт газар, түүний хамгаалалтын дэглэм

13 дугаар зүйл. Байгалийн цогцолборт газар

Байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалсан, түүх, соёл, шинжлэх ухааны болон танин мэдэхүй, экологийн хүмүүжилд ач холбогдол бүхий улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг байгалийн цогцолборт газар гэнэ.

14 дүгээр зүйл. Байгалийн цогцолборт газрын бүс

Байгалийн цогцолборт газрыг байгалийн хэв шинж, ургамал, амьтны аймгийн байршил, түүх, соёлын дурсгалыг нь хадгалах шаардлага, аялал, жуулчлал хөгжүүлэх нөхцөл зэргийг харгалзан дараахь бүсэд хуваана:

1) онцгой бүс;
2) аялал, жуулчлалын бүс;
3) хязгаарлалтын бүс.

15 дугаар зүйл. Онцгой бүсийн дэглэм

Онцгой бүсэд байгалийн унаган төрхийг нь хадгалах шаардлагад нийцүүлэн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхийн зэрэгцээ байгальд сөрөг нөлөөгүй арга, хэлбэрээр судалгаа, шинжилгээний ажил явуулах, ургамал, амьтны өсч үржих нөхцөлийг хангах, хөрсийг нөхөн сэргээх, байгалийн гамшгаас учирсан хор уршгийг арилгах арга хэмжээ авна.

16 дугаар зүйл. Аялал, жуулчлалын бүсийн дэглэм

Аялал, жуулчлалын бүсэд байгаль орчинд нь сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр зохих зөвшөөлтэйгээр дараахь үйл ажиллагаа явуулж болно:

1) энэ хуулийн 11, 15 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа явуулах;

2) зөвшөөрөгдсөн газар зогс барих.

17 дугаар зүйл. Хязгаарлалтын бүсийн дэглэм

Хязгаарлалтын бүсэд дараахь үйл ажиллагаа явуулж болно:

1) энэ хуулийн 11, 15, 16 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа;

2) уламжлалт аргаар мал аж ахуй эрхлэх;

3) аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн ашиглах барилга байгууламжийг батлагдсан зураг, төсөл, зөвшөөрлийн дагуу барих;

4) батлагдсан зураг төсөл, зохих журмын дагуу зам тавих, тээврийн хэрэгслэлийн зогсоол гаргах;

5) биеийн тамир, нийтийн арга хэмжээнд шаардагдах талбайг засч тохижуулах;

6) тухайн нутаг дэвсгэр дэх сууринг экологийн магадлан шинжилгээ хийж баталсан ерөнхий төлөвлөгөөний дагуу хөгжүүлэх.

18 дугаар зүйл. Байгалийн цогцолборт газарт хориглох үйл ажиллагаа

Байгалийн цогцолборт газарт энэ хуулийн 15, 16, 17 дугаар зүйлд зааснаас өөр зориулалтаар дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

1) энэ хуулийн 12 дугаар зүйлийн 1—8, 11-т заасан үйл ажиллагаа явуулах;

2) онцгой бүсэд энэ хуулийн 12 дугаар зүйлийн 9, 10-т заасан үйл ажиллагаа явуулах;

3) батлагдсан ерөнхий төлөвлөгөө, зураг төслийг зөрчиж сууринги йн нутаг дэвсгэрийг тэлэх, барилга байгууламж барих.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Байгалийн нөөц газар, түүний хамгаалалтын дэглэм

19 дүгээр зүйл. Байгалийн нөөц газар

Байгалийн тодорхой хэв шинж, аль нэгэн нөөц, баялгийг хамгаалах, хадгалах, нөхөн сэргээх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг байгалийн нөөц газар гэнэ.

20 дугаар зүйл. Байгалийн нөөц газрын төрөл

Байгалийн нөөц газрыг дараахь төрөлд хуваана:

1) байгалийн унаган төрх, хэв шинжийг хадгалах зорилго бүхий байгалийн иж бүрдлийн нөөц газар;

2) ховор ховордсон ургамал, амьтныг хамгаалах, тэдгээрийн нөхөн үржих нөхцөлийг бүрдүүлэх зорилго бүхий биологийн нөөц газар;

3) Эртний амьтан ургамлын ховор олдворыг байгалийн байдлаар нь хадгалах зорилго бүхий байгалийн түүхэн олдворын нөөц газар;

4) газрын өвөрмөц тогтоц, илэрц, тэдгээрийн бүтцийг байгалийн байдлаар нь хадгалах зорилго бүхий геологийн нөөц газар.

21 дүгээр зүйл. Байгалийн нөөц газрын дэглэм

1. Байгалийн нөөц газарт хамгаалалтад авсан байгалийн хэв шинж, тодорхой баялгийн төрх байдал, ургамал, амьтны аймгийн байршил, өсөлт, үржилтэд сөрөг нөлөөгүйгээр уламжлалт аж ахуй эрхлэж болно.

2. Байгалийн нөөц газарт түүний байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламж барих, үйлдвэрлэлийн зориулалтаар газар ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, ан амьтан агнах, барих, мод, зэгс, шагшуурга бэлтгэх зэргээр байгалийн унаган төрхийг өөрчлөх аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

ТАВДУГААР БҮЛЭГ

Дурсгалт газар, түүний хамгаалалтын дэглэм

22 дугаар зүйл. Дурсгалт газар

Байгалийн өвөрмөц тогтоц, түүх, соёлын ул мөрийг уламжлагдан хадгалагдсан байгалийн байдлаар нь өвлөн үлдээх зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг дурсгалт газар гэнэ.

23 дугаар зүйл. Дурсгалт газрын төрөл

1. Дурсгалт газрыг дараахь төрөлд хуваана:

1) байгалийн дурсгалт газар;

2) түүх, соёлын дурсгалт газар.

2. Байгалийн дурсгалт газарт өвөрмөц тогтоц, илэрц бүхий газар, хүрхрээ, хясаа, хавцал, агуй, хад цохио, явар цонж, төгөл мод, рашаан булаг, баянбүрд, элсэн манхан,

солир, солирын цар, өрх, галт уулын тогоо зэргийг хамааруулж болно.

3. Түүх, соёлын дурсгалт газарт эртний хүний оромж, отог бууц, агуй, сүг зураг, хадны бичээс, буган ба хүн чулуун хөшөө, булш бунхан, эртний хот, суурины үлдэгдэл, балгас, хэрэм, цайз, суваг шуудуу, далан, эртний зэр зэвсэг хийж байсан орд, уламжлалт зан үйлтэй холбоотой уул, овоо, тахилга бүхий болон түүхэн чухал үйл явдал болсон газар зэргийг хамааруулж болно.

24 дүгээр зүйл. Дурсгалт газрын дэглэм

1. Дурсгал газарт хаалт, хашлага барих, сэрэмжлүүлсэн дохио, тэмдэг тавих, түүний хамгаалалтыг нутгийн оршин суугчдад хариуцуулан өгөх зэргээр хамгаалалтын арга хэмжээ авна.

2. Дурсгалт газар дахь байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлээс 0,1—3,0 км-ийн орчимд сүр бараа, үзэмжийг нь дарах барилга байгууламж барих, газар хагалах, ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлийг хөндөх, эвдэх, буулгах, тэдгээрт хохирол учруулахуйц бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Тусгай хамгаалалттай газар нутгийн талаархи төрийн байгууллагын бүрэн эрх

25 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

Улсын Их Хурал тусгай хамгаалалттай газар нутгийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах талаар төрийн бодлогыг тодорхойлох;

2) Засгийн газрын өргөн мэдүүлснээр газар нутгийг тусгай хамгаалалтад авах тухай шийдвэр гаргах, эдгээр газрыг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тодорхой ангилалд хамааруулах, дархан цаазат болон байгалийн цогцолборт газрын хилийн заагийг батлах, өөрчлөх.

26 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

Засгийн газар тусгай хамгаалалттай газар нутгийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулж хангах;

2) тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах эдийн засаг, зохион байгуулалтын тогтолцоог бүрдүүлж энэ асуудлаар Засгийн газрын болон засгийн газрын бус байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах;

3) тусгай хамгаалалттай газар нутгийг байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулаас сэргийлэх, тэдгээрээс учирсан хор уршгийг арилгахад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүчийг нэгтгэн зохион байгуулж, шаардлагатай арга хэмжээ авах;

4) тусгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бүсийг хөгжүүлэх, экологийн аюулгүй байдал, байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

5) энэ хуульд заасан хамгаалалтын дэглэмийн хүрээнд тухайн дархан цаазат газар, байгалийн цогцолборт газрын хамгаалалтын горимыг батлах;

6) байгалийн нөөц газрын болон дурсгалт газрын хилийн заагийг тогтоох.

27 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2) тусгай хамгаалалттай газар нутагт явуулах судалгаа, шинжилгээний ажлын журам, хөтөлбөрийг батлах, зөвшөөрөл олгох, холбогдох тайлан, мэдээллийг авч нэгдсэн санд оруулах;

3) биологийн төрөл зүйлд судалгаа, тооллого явуулах, бүртгэл хөтлөх аргачлал, хөтөлбөрийг батлах, зөвшөөрөгдсөн бүсээс ажиглалтын зориулалтаар дээж, сорьц авах, хэмжилт хийх, сүргийн бүтцийг зохицуулах зорилгоор ан амьтныг агнах, барих журам тогтоох;

4) ойг арчлах, ойжуулах, хөрс, ургамлыг нөхөн сэргээх журам, хөтөлбөрийг батлаж, нөхөн сэргээх газрын хэмжээ, уг ажлыг гүйцэтгэх арга, технологийг тогтоох;

5) хортон шавьж, мэрэгчид, түймрээс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх журам, арга члал тогтоох, байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулаас тусгай хамгаалалттай газар нутагт учирсан хор уршгийг багасгах арга хэмжээ авах;

6) рашаан, эмчилгээ, сувилгааны зориулалттай бусад эрдэс, байгалийн дагалт баялгийг ашиглах журам, эмийн, хүнсний болон техникийн зориулалттай ургамлын жагсаалт, тэдгээрийг түүж бэлтгэх журмыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран тогтоох;

7) аялал, жуулчлалын зам, чиглэл, журам тогтоох;

8) тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдсөн бүс дэх суурин газрын ерөнхий төлөвлөгөө, шинээр байгуулах аялал, жуулчлалын бааз, амралт, сувиллын байршил, төслийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран хянан батлах;

9) тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдсөн бүсэд тодорхой зориулалтаар ашиглаж болох газар, түүний хэмжээ, ашиглах журам, уг газарт байлгаж болох малын төрөл, тоог тогтоох;

10) зохих шатны Засаг даргатай зөвшилцөн тухайн дархан цаазат газар, байгалийн цогцолборт газарт хамгаалалтын захиргаа байгуулах асуудлыг шийдвэрлэж, даргыг нь томилох.

28 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тусгай хамгаалалттай газар нутгийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) өөрийн нутаг дэвсгэр дэх тусгай хамгаалалттай газар нутагт холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар Засаг даргын илтгэлийг хэлэлцэж зохих шийдвэр гаргах, түүний биелэлтийг хангуулах;

2) нутаг дэвсгэрийнхээ тодорхой хэсгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай саналыг дээд шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал буюу Засгийн газарт уламжлах;

3) нутаг дэвсгэрийнхээ тодорхой хэсгийг орон нутгийн

хамгаалалтад авах тухай шийдвэр гаргах, түүний хилийн зааг, хамгаалалтын горимыг тогтоох.

29 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тусгай хамгаалалттай газар нутгийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2) өөрийн нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийг улсын тусгай болон орон нутгийн хамгаалалтад авах талаар санал боловсруулж зохих байгууллагад уламжлах;

3) байгалийн нөөц газар, дурсгалт газрын хамгаалалтыг эрхлэх.

30 дугаар зүйл. Дархан цаазат газар, байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны үйл ажиллагаа

Дархан цаазат газар, байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа (цаашид «хамгаалалтын» захиргаа» гэх) нь дараахь үйл ажиллагаа явуулна:

1) тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх хууль тогтоомж, тухайн газар нутгийн хамгаалалтын горимын биелэлтийг хангуулах;

2) судалгаа, шинжилгээ хийх зөвшөөрөл авсан байгууллагатай гэрээ байгуулах, тухайн газар нутгийн хамгаалалтын горимын хүрээнд явуулж болох үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, хяналт тавих;

3) зохих журмын дагуу судалгаа, шинжилгээний зориулалтаар дээж, сорьц авах, ан амьтны сүргийн бүтцийг зохицуулах, байгалийн баялгийг нөхөн сэргээх, ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх;

4) ан амьтанд зориулан ус задгайлах, хадлан бэлтгэх, өвс тэжээл, хужир, шүү тавих, нөмөр хорго барих болон биотехникийн бусад арга хэмжээг зохих журмын дагуу гүйцэтгэх;

5) рашаан, эмчилгээ, сувилгааны зориулалттай эрдэс, байгалийн дагалт баялгийг зохих журмын дагуу ашиглуулах;

6) зөвшөөрөгдсөн аялал, жуучлалын зам, чиглэлийг тэмдэгжүүлэх, шаардлагатай орон байр барих, тээврийн хэрэгслэлийн зогсоол гаргах, биеийн тамирын болон нийтийн бусад арга хэмжээ явуулах газар, журмыг тогтоох, эрүүл ахуйн нөхцлийг нь хангах, тэдгээрийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран тохижуулах;

7) зөвшөөрөгдсөн бүс дэх сууринг тохижуулах, барилга байгууламж барих ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж байгаад хяналт тавих;

8) уул, овоо тахих, уламжлалт зан үйлийн бусад ёслол үйлдэх ажиллагааг зохицуулах;

9) тусгай хамгаалалттай газар нутгийн ач холбогдол, хамгаалалтын горим, холбогдох хууль тогтоомжийг сурталчлан таниулах, он дараалллын бичиг хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх;

10) зөвшөөрөгдсөн бүсэд байлгаж болох малын төрөл, тоо болон зохих журмын дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах газрыг тогтоох.

31 дүгээр зүйл. Байгаль хамгаалагчийн бүрэн эрх

1. Хамгаалалтын захиргааны хамгаалалт хариуцсан ажилтан болон байгаль хамгаалагч нь байгаль орчны хяналтын улсын байцаагчийн эрх, үүрэгтэй байна.

2. Тусгай хамгаалалттай газар нутагт ажиллаж байгаа байгаль хамгаалагч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) энэ хууль болон байгаль орчныг хамгаалах бусад хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг таслан зогсоож, гэм буруутай этгээдэд зохих хариуцлага хүлээлгэх;

2) хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэн орох, шалгалт хийх;

3) хууль тогтоомж зөрчсөн сэжиг бүхий иргэний бичиг баримтыг шалгах, түр хураах, шаардлагатай гэж үзвэл унаа хөсөгт нь үзлэг хийх, зэвсэг, хэрэгсэл, агнасан түүсэн, бэлтгэсэн зүйлийг хураан авах;

4) хууль тогтоомж, хамгаалалтын горимыг зөрчиж байгаль орчинд сөрөг нөлөөлөх үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг түр зогсоох, тэдгээрт хугацаатай үүрэг, даалгавар өгөх, шаардлага тавих;

5) албан үүргээ гүйцэтгэх үедээ дүрэмт хувцас, ялгах тэмдэг, зэвсэг, хэрэгсэлтэй байх.

32 дугаар зүйл. Байгаль хамгаалагч зэвсэг хэрэглэх

1. Тусгай хамгаалалттай газар нутагт ажиллаж байгаа байгаль хамгаалагчийн хэрэглэх зэвсэг, хэрэгслийн төрөл, тэдгээрийг хэрэглэх журмыг төрийн захиргааны төв байгууллага Цагдаагийн ерөнхий газартай зөвшилцөн тогтооно.

2. Байгаль хамгаалагч албан үүргээ гүйцэтгэж байх үедээ дараахь тохиолдолд зэвсэг хэрэглэж болно:

1) байгаль хамгаалагчийн амь нас, эрүүл мэндэд гэмт этгээд хохирол учруулж болзошгүй байдал бодитоор бий болсон;

2) байгаль хамгаалагчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байдлаар зэрлэг амьтан довтолсон.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах, судалгаа, шинжилгээний ажил явуулах

33 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах

1. Дархан цааз газрын болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газраас Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тодорхой зориулалт, хугацаа, болзолтойгоор байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга, хэлбэрээр гэрээний үндсэн дээр ашиглуулж болно.

2. Тусгай хамгаалалттай газар нутагт гадаад улсын хуулийн этгээд олон улсын байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулахыг хориглоно.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн заалт нь гадаад улсын болон олон улсын байгууллага тусгай хамгаалалттай газрын зохих бусад энэ хуулиар зөвшөөрөгдсөн хүрээнд төслийн дагуу үйл ажиллагаа явуулахад хамаарахгүй.

34 дүгээр зүйл. Газар ашиглах хугацаа, газрын хэмжээ

1. Энэ хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан

газар ашиглах тухай гэрээний хугацаа 5 жилээс илүүгүй байх бөгөөд үг гэрээг нэг удаад сунгах хугацаа 5 жилээс илүүгүй байна.

2. Тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах газрын хэмжээг төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хэмжээний дотор хамгаалалтын захиргаа буюу сум, дүүргийн Засаг дарга тогтооно.

35 дугаар зүйл. Газар ашиглах тухай хүсэлт гаргах

1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан журмыг баримтлан газар ашиглах тухай хүсэлтээ хамгаалалтын захиргаа буюу хамгаалалтын захиргаа байгуулаагүй тусгай хамгаалалттай газар нутагт сум, дүүргийн Засаг даргад гаргана.

2. Хамгаалалтын захиргаа буюу Засаг дарга нь газар ашиглах тухай иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлт болон түүний талаарх санналаа төрийн захиргааны төв байгууллагад уламжилна.

36 дугаар зүйл. Газар ашиглуулах тухай шийдвэр гаргах

1. Төрийн захиргааны төв байгууллага нь дархан цаазат газрын болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газраас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглуулах тухай шийдвэрийг хамгаалалтын захиргаа болон сум, дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн гаргана.

2. Тухайн газрыг хоёр буюу түүнээс дээш этгээд ашиглах хүсэлт гаргавал газар ашиглалтын зориулалт, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, байгаль орчныг хамгаалах талаар авах арга хэмжээний зардал зэргийг харгалзан сонголт хийнэ.

3. Аялал, жуулчлал эрхлэх зориулалтаар газар ашиглах тухай хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын аялал, жуулчлалын үйл ажиллагаа явуулах материаллаг баазыг олон улсын стандарт, түвшинд хүргэсэн байдлыг нь харгалзан сонголт хийнэ.

4. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэрт ашиглуулах газрын зориулалт, орших бүс, байршил, зааг, хэмжээ, дангаар буюу дундаа ашиглах талаар тодорхой заана.

5. Газар ашиглуулахаас татгалзсан бол төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрт үүний шалтгаан, үндэслэлийг заана.

37 дугаар зүйл. Газар ашиглах тухай гэрээ

1. Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 36 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэрийг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар ашиглах тухай гэрээг өөрөө буюу хамгаалалтын захиргаатай хамтран байгуулна.

2. Газар ашиглах тухай гэрээнд Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас гадна дараахь зүйлийг тусгана:

1) тухайн газрын унаган төрхийг хадгалах, хамгаалах, нөхөн сэргээх талаар авах арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгө;

2) газрын төлбөрийн хэмжээ, төлөх хугацаа;

3) газрыг ашиглах, хамгаалах талаарх талуудын эрх, үүрэг, хариуцлага;

4) гэрээ дуусгавар болсон тохиолдолд газрыг эргүүлж авах нөхцөл, журам, ут газрыг нөхөн сэргээх, засаж тохижуулах, хүлээлгэн өгөх журам.

38 дугаар зүйл. Газар ашиглагчийн эрх, үүрэг

1. Тусгай хамгалалттай газар нутагт газар ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан эрх эдэлнэ.

2. Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглаж байгаа иргэн, а ж ахуйн нэгж, байгууллага Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан үүргээс гадна дараахь үүрэг хүлээнэ;

1) тухайн газрын унаган төрхийг хадгалах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх;

2) ашиглахаар авсан газартаа тогтоосон замаар орж, гарах;

3) хууль буюу гэрээнд заасан үйл ажиллагаа явуулахтай холбогдуулан ашиглаж байгаа газрынхаа төлөв байдал, ашиглалтын зориулалтыг өөрчлөхөд хүрвэл холбогдох зураг төслөө төрийн захиргааны төв байгууллагад танилцуулж зөвшөөрөл авах;

4) газар ашиглах эрх дуусгавар болоход ашиглаж байсан газраа нөхөн сэргээж, засаж тохижуулан хамгаалал-

тын захиргаа буюу сум, дүүргийн Засаг даргад хүлээлгэн өгөх.

39 дүгээр зүйл. Газар ашиглагчид хориглох үйл ажиллагаа

1. Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглаж байгаа иргэн, аж ахуй, нэгж, байгууллага дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

1) ашиглаж байгаа газраа бүхэлд нь буюу зарим хэсгийг бусдад дамжуулан ашиглуулах;

2) энэ хууль болон тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын горимоор хориглосон, гэрээнд зааснаас өөр буюу байгаль орчинд сөрөг нөлөөлөх үйл ажиллагаа явуулах.

2. Ашиглагчаас газрыг хуульд заасан үндэслэлээр эргүүлж авах тохиолдолд тусгай хмгаалалттай газар нутгаас түүнд дахин газар олгохгүй байж болно.

40 дүгээр зүйл. Газар ашиглах эрх дуусгавар болох, газрыг чөлөөлөх

1. Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах эрх дараахь тохиолдолд дуусгавар болно:

1) Газрын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3; 2 дахь хэсгийн 1, 2-т заасан үндэслэлээр;

2) тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын горимыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн.

2. Газар ашиглах эрх дуусгавар болоход иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ашиглаж байсан газраа чөлөөлж энэ хуулийн 37 дугаар зүйлд заасан гэрээнд өөрөөр заагаагүй бол 90 хоногийн дотор тухайн газар нутгийн хамгаалалтын захиргаа буюу сум, дүүргийн Засаг даргад хүлээлгэн өгнө.

41 дүгээр зүйл. Тусгай хамгаалалттай газар нутагт судалгаа, шинжилгээний ажил явуулах байгууллага, түүний үүрэг

1. Тусгай хамгаалалттай газар нутагт төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсан байгууллага, гадаадын болон олон улсын эрдэм шинжилгээний байгууллага судалгаа, шинжилгээний ажлыг гэрээний үндсэн дээр явуулж болно.

2. Тусгай хамгаалалттай газар нутагт судалгаа, шинжилгээ явуулах байгууллагын үүрэг:

1) тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж, хамгаалалтын горимыг сахин биелүүлэх;

2) судалгаа, шинжилгээний ажил явуулахдаа зохих зөвшөөрөл авах, хураамж төлөх;

3) судалгаа, шинжилгээний ажлыг байгаль орчинд сөрөг нөлөөгүй аргаар гүйцэтгэх;

4) судалгаа, шинжилгээний ажлын талаар хамгаалалтын захиргаа болон төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах;

5) судалгаа, шинжилгээний ажлын явцад байгаль орчинд хохирол учруулсан бол түүнийг нөхөн сэргээх арга хэмжээ авч тухайн газар нутгийг хамгаалалтын захиргаа буюу сум, дүүргийн Засаг даргад хүлээлгэн өгөх.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

42 дугаар зүйл. Төрийн хяналт

1. Тусгай хамгаалалттай газар нутийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд төрийн захиргааны төв байгууллага, хамгаалалтын захиргаа, бүх шатны Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.

2. Байгаль орчны хяналтын улсын байцаагчид тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж, зөрчигчдөд эрх хэмжээнийхээ хүрээнд хариуцлага хүлээлгэнэ.

43 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

1. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд түүний гэм буруу, зөрчлийн шинж байдал, учруулсан хохирлын хэмжээг харгалзан хуульд заасан эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

2. Тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон буюу зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа явуулсны улмаас газрын төрх байдал, хөрс, ус, ургамал, амьтны аймагт хохирол

учирсан бол гэм буруутай этгээдээр хохирлыг зохих журмын дагуу нөхөн төлүүлнэ.

3. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийг дараахь байдлаар зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, байгаль орчны хяналтын улсын байцаагч гэм буруутай этгээдэд дор дурдсан шийтгэл ногдуулна:

1) тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын горимыг зөрчиж үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар олсон орлогыг хурааж 10000 хүртэл төгрөгөөр торгох;

2) байгалийн нөөц болон дурсгалт газарт хориглосон үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар олсон орлогыг хурааж 1000—10000 төгрөгөөр торгох;

3) байгалийн цогцолборт газарт хориглосон үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар олсон орлогыг хурааж 5000—20000 төгрөгөөр торгох;

4) тусгай хамгаалалттай газар нутагт судалгаа, шинжилгээний ажил явуулахдаа газрын төлөв байдал, хөрс, ус, агаар, ургамал, амьтны аймагт сөрөг нөлөөлсөн, хохирол учруулсан бол 5000—25000 төгрөгөөр торгох;

5) дархан цаазат газарт хориглосон үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар олсон орлогыг хурааж 10000—25000 төгрөгөөр торгох.

44 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын
дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

ЭРДЭНЭСИЙН САНГИЙН ТУХАЙ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын эрдэнэсийн эх нөөцийг хамгаалах, төрийн эрдэнэсийн сан (цаашид «эрдэнэсийн сан» гэх)-г бүрдүүлэх, хамгаалах, арвижуулах, уул сангаас хөрөнгө гүйлгээнд оруулах, захиран зарцуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Эрдэнэсийн сангийн тухай хууль тогтоомж

Эрдэнэсийн сангийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, Банкны тухай, Валютын зохицуулалтын тухай түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай болон ашигт малтмалын тухай хуулийн холбогдох заалт, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

Энэ хуульд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1) «эрдэнэс» гэж түүхий эд, хайлш, химийн нэгдэл бүтээгдэхүүн, түүх, соёлын дурсгалт зүйл зэрэг ямар ч байдалд байгаа үнэт металл, эрдэнийн чулууг хэлнэ;

2) «үнэт металл» гэж алт, мөнгө, платина болон түүний бүлэгт багтдаг палладий, иридий, родий, рутений, осмийг хэлнэ;

3) «эрдэнийн чулуу» гэж доржпалам, бадмараг, маргад эрдэнэ, индранил болон сувдыг хэлнэ;

4) «эрдэнэсийн сан» гэж төрийн нэрийн өмнөөс Монголбанк эрхлэн хуримтлуулж, хадгалж, хамгаалж, хэрэглэж байгаа эрдэнэсийг хуримтлалыг хэлнэ;

5) «байгалийн төрц» гэж 100,0 граммаас дээш жинтэй буюу 3,0 X 2,0 сантиметрээс дээш хэмжээтэй, түүнээс бага

боловч онцгой чамин дүрс хэлбэртэй байгалийн тогтоц, дүрс хэлбэрээрээ олдсон үнэт металлыг хэлнэ.

4 дүгээр зүйл. Эрдэнэсийн сан, түүний ангилал

1. Эрдэнэсийн сан нь төрийн өмчлөлд байна.

2. Эрдэнэсийн санг үндсэн болон гүйлгээний санд хуваана.

3. Үндсэн сан нь байнгын болон байнгын бус хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1) байнгын хэсэгт худалдах, шилжүүлэхийг хориглосон эрдэнэс орно. Энэ хэсэгт байгаа эрдэнэс нь Монгол Улсын хуваагдашгүй өмч мөн;

2) байнгын бус хэсэгт Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу эрдэнэсийн санд шилжүүлсэн олон улсын жишигт хүргэж цэвэршүүлсэн үнэт металл, засаж өнгөлсөн эрдэнийн чулуу, түүх соёлын үнэт дурсгалт зүйл, үнэт металлаар хийж нөөцөд авсан зоос орно.

4. Гүйлгээний санд үнэт металл боловсруулах аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн, мөн эрдэм шинжилгээний ажил, эмчилгээний хэрэгцээнд зориулан гүйлгээнд оруулах цэвэршүүлсэн болон цэвэршүүлээгүй үнэт металл, түүгээр хийсэн зоос, засч өнгөлсөн болон байгалийн төрхөөрөө байгаа эрдэнийн чулуу, сувд зэрэг энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас бусад Монголбанкинд хадгалагдаж байгаа бүх эрдэнэс хамаарна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Эрдэнэсийн сангийн талаар төрийн байгууллагуудын эдлэх бүрэн эрх

5 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

Улсын Их Хурал эрдэнэсийн сангийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) үндсэн сангийн байнгын болон байнгын бус хэсэгт байвал зохих эрдэнэсийн нэр төрөл, хэмжээг тогтоох;

2) үндсэн сангийн жилийн орлого, зарлагын хэмжээ болон гүйцэтгэлийн тайланг батлах;

3) гүйлгээний сангаас жил бүр зарцуулах хэмжээг тогтоох;

4) үндсэн сангаас үнэт металл, эрдэнийн чулуу гадаа-

дад худалдах, гадаадаас худалдан авах шийдвэр гаргах;

5) олборлосон үнэт металл, эрдэнийн чулууг эрдэнэсийн санд зориулан Монголбанкинд худалдан авах доод хэмжээг тогтоох;

6) хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

6 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

Засгийн газар эрдэнэсийн сангийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) Улсын Их Хурлаас тогтоосон хэмжээнд гүйлгээний сангаас үнэт металл, эрдэнийн чулуу худалдах асуудлыг Монголбанктай хамтран шийдвэрлэх;

2) хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

7 дугаар зүйл. Монголбанкны бүрэн эрх

Монголбанк эрдэнэсийн сангийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) эрдэнэсийн сангийн хөдөлгөөний бүртгэл, тооцоог эрхлэх;

2) хууль, Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу үндсэн болон гүйлгээний сангийн орлогыг нэмэгдүүлж зарлагын гүйцэтгэлийг хангах;

3) гүйлгээний санд байгаа үнэт металлаас олон улсын жишигт хүргэн гадаадад цэвэршүүлж, гадаадын банк, санхүүгийн байгууллагад оновчтой байршуулах;

4) үндсэн сангаас үнэт металл, эрдэнийн чулуу гадаадад худалдах, гадаадаас худалдан авч нөөц нэмэгдүүлэх тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж гаргасан шийдвэрийг нь хэрэгжүүлэх;

5) эрдэнэсийн сангийн эрдэнэсийн үнэ тогтоох журам батлаж мөрдүүлэх;

6) хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Эрдэнэсийн санг эрхлэх үйл ажиллагаа, түүний зохион байгуулалт

8 дугаар зүйл. Эрдэнэсийн санг эрхлэх үйл ажиллагаа

Эрдэнэсийн санд хүримтлуулсан эрдэнэсийг хадгалах, хадгалуулах, худалдан авах, худалдах, цэвэршүүлэх, байр-

шуулах, үзэсгэлэн гаргах, үзмэр зохион байгуулах, эрдэнэсийн санг нэмэгдүүлэх, тэдгээрийг хамгаалах, сэлбэн тордох, сэргээн засварлах зэрэг ажил эрдэнэсийн санг эрхлэх үйл ажиллагаанд хамаарна.

9 дүгээр зүйл. Зохион байгуулалт

1. Эрдэнэсийн санг Монголбанк эрхэлнэ. Түүний бүтцэд энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан ажлыг эрхлэх нэгж байх бөгөөд үйл ажиллагааг нь Монголбанк Ерөнхийлөгч байгуулагаар хангана.

2. Монголбанкны Ерөнхийлөгч эрдэнэсийн санг эрхлэх нэгжийн бүтэц, орон тоо, цалингийн санг Монголбанкны зардлын төсөвт багтаан тогтоож, захирлыг нь томилж, чөлөөлнө.

10 дугаар зүйл. Эрдэнэсийн сангийн орлого

Эрдэнэсийн сангийн орлого нь гадаад, дотоодын банк, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс улсад худалдсан, бэлэглэсэн, хандивласан, түүнчлэн хууль тогтоомжийн дагуу хураасан, дайчлан авсан болон хадгалуулсан, тушаасан эрдэнэсээс бүрдэнэ.

11 дүгээр зүйл. Эрдэнэсийн сангийн зарлага

Эрдэнэсийн сангаас орлого, зарлагын батлагдсан тэнцлийн дагуу дараахь журмаар зарлага гаргана:

1. аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд үнэт металл, эрдэнийн чулуут дэлхийн зах зээлийн үнийг харгалзан Монголбанкнаас тогтоосон үнээр худалдах;

2) Улсын Их Хурлаас гаргасан шийдвэрийн дагуу үнэт металл, эрдэнийн чулууг гадаадад худалдах;

3) үнэт металл, эрдэнийн чулууг засах, цэвэршүүлэх, сэлбэн тордох явцад гарсан хорогдлыг хасах.

12 дугаар зүйл. Эрдэнэсийн сангийн бүртгэл, тооцоо

1. Эрдэнэсийн санд байгаа үнэт металл, эрдэнийн чулуугаар хийсэн эдлэл, түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх мэргэжлийн зөвлөлөөс өгсөн тодорхойлолт бүхий хувийн хэрэг хөтөлж, Монголбанкнаас тогтоосон журмын дагуу үнэлж эрдэнэсийн сангийн бүртгэлмэдээллийн санд бүртгэнэ.

2. Эрдэнэсийн сангийн нэгдсэн бүртгэл нь төрийн нууцад хамаарах бөгөөд Засгийн газар, Монголбанкинд тус бүр нэг хувь хадгалагдана.

3. Алт, платина, түүний бүлэгт багтдаг металлыг миллиграммын, цагаан мөнгийг граммын нарийвчлалтайгаар тус тус жинлэн бүртгэж, тооцоолно.

4. Эрдэнэсийн санд үнэт металл, эрдэнийн чулуу, тэдгээрээр хийсэн эдлэл, түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг нэг эд хариуцагчаас нөгөөд шилжүүлэхдээ нэгбүрчлэн тоолж, жинлэж, бүртгэлтэй тулган тооцож, удирдлагын хяналттайгаар хүлээлцэнэ.

5. Эрдэнэсийн сангийн бүртгэл, хадгалалт, хяналтын журмыг Монголбанкны Ерөнхийлөгч батлана.

13 дугаар зүйл. Эрдэнэсийн хадгалалт

1. Эрдэнэсийн санд байгаа бүх эрдэнэсийн чанар байдлыг нь алдагдуулахгүйгээр тусгайлан төхөөрөмжлөгдсөн зориулалтын байр, сейфэнд хадгална.

2. Эрдэнэсийн сангийн үнэт металл, эрдэнийн чулуугаар хийсэн эдлэл, түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг сэлбэн тордох, сэргээн засварлах, өнгө үзэмжийг сайжруулах, бүрэн бүтэн байлгах хэвийн нөхцөлийг бүрдүүлэхтэй холбогдсон үйлчилгээг Монголбанкны Ерөнхийлөгчөөс бусад этгээд зөвшөөрөл авсан заавар, хуваарийн дагуу тогтмол хийж байна.

14 дүгээр зүйл. Эрдэнэсийн санд эрдэнэсийг шилжүүлэх, байршуулах, эрдэнэсийн сангаас мөрдөх журам

1. Үнэт металл, эрдэнийн чулуу, тэдгээрээр хийсэн эдлэл, түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг эрдэнэсийн санд хүлээн авах, шилжүүлэх, байршуулах, эрдэнэсийн сангаас гаргах, тээвэрлэх ажлыг холбогдох байгууллагын гүйцэтгэх албаны хяналт, тусгай хамгаалалттайгаар гүйцэтгэнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хяналт, тусгай хамгаалалтын журмыг Монголбанкны Ерөнхийлөгч, Ташуулын төв газар, Цагдаагийн ерөнхий газрын дарга нар хамтран тогтооно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Эрдэнэс эзэмшигчийн эрх, үүрэг

15 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эрх, үүрэг

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт эрдэнэс эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь дор дурдсан үүрэг хүлээнэ:

1) олборлосон болон олсон үнэт металл, байгалийн төрц, эрдэнийн чулууг Монголбанкнаас тогтоосон үнээр эрдэнэсийн санд худалдах;

2) эрдэнэсийн санд худалдах үнэт металл, эрдэнийн чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийг Сангийн яамны хяналтын зохих албаар сорьц тогтоолгон баталгаажуулсан байх;

3) үнэт металл, эрдэнийн чулуугаар хийсэн түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг эзэмшиж байгаа бол түүний жинхэнэ эхийг эрдэнэсийн санд хадгалуулах. Иймхүү хадгалуулбал зохих зүйлийн жагсаалтыг Монголбанкны Ерөнхийлөгч, Соёлын сайд хамтран батална.

2. Аж ахуйн нэгж, иргэн нь эрдэнэсийн санд худалдах болон хадгалуулах эрдэнэсийн үнийг хэлэлцэн тохирох, нэхэмжлэн авах эрхтэй.

16 дугаар зүйл. Монголбанкны үүрэг, эрх

1. Монголбанк эрдэнэсийн сангийн талаар дараахь үүрэг хүлээнэ:

1) эрдэнэсийн санд авсан зүйлийн үнийг төлөх;

2) эрдэнэсийн санг нэмэгдүүлэх хэмжээ, гүйлгээ хөрөнгийн орлого, зарлагын жилийн төлөвлөгөө, тэнцлийг болон жил бүрийн худалдан авах эрдэнэсийн доод хэмжээг тодорхойлж Улсын Их Хуралд өргөн мэдүүлж гаргасан шийдвэрийг нь хэрэгжүүлэх;

3) эрдэнэсийн санг хамгаалах, хадгалах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавих;

4) эрдэнэсийн санг эрхлэх нэгжийг эрдэнэсийн сангийн зүйлийг хэмжих, жинлэх, сорьц шалгах, өнгөлөх, хадгалж хамгаалах, тээвэрлэх, шаардлагатай холбоо, дохиоллын болон бусад багаж, тоног төхөөрөмж, сэлбэг, химийн бодис зэргээр хангах.

2. Монголбанк эрдэнэсийн сангийн талаар дараахь эрхтэй:

1) эрдэнэсийн санд эрдэнэс худалдан авах, гүйлгээний сангаас зөвшөөрөгдсөн хэмжээгээр худалдах, арилжих;

2) Монгол Улсын болон олон улсын нийтлэг ач холбогдол бүхий тэмдэглэлт ой зэрэг онцгой чухал үйл явдлыг тохиолдуулан хууль тогтоомжийн дагуу үнэт металлаар дурсгалын зоос үйлдвэрлүүлэх, зохих журмын дагуу үзэсгэлэн гаргах.

17 дугаар зүйл. Эрдэнэсийн сангийн харуул, хамгаалалт

1. Эрдэнэсийн сан улсын хамгаалалтад байна. Эрдэнэсийн сангийн харуул, хамгаалалтын журмыг Монголбанкны Ерөнхийлөгч, Цагдаагийн ерөнхий газрын дарга хамтран тогтооно.

2. Эрдэнэсийн сангийн харуул хамгаалалтыг Монголбанктай байгуулсан гэрээний үндсэн дээр цагдаагийн байгууллага эрхлэн гүйцэтгэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

18 дугаар зүйл. Хяналт шалгалт

1. Эрдэнэсийн сангийн байдал, түүнийг эрхлэх үйл ажиллагаанд Монголбанкны Ерөнхийлөгч, түүний хяналт шалгалтын алба шалгалт хийж, хянан байцаана.

2. Монголбанк жил бүр эрдэнэсийн сангийн үлдэгдэлд тооллого явуулан дүгнэж, тайланг Улсын Их Хуралд танилцуулна.

3. Эрдэнэсийн сангийн харуул, хамгаалалтын байдалд Цагдаагийн ерөнхий газар хяналт тавина.

19 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

Эрдэнэсийн сангийн тухай хууль тогтоомж дараахь байдлаар зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Монголбанкны улсын хянан шалгагч, валютын хяналтын улсын байцаагч түүнд дор дурдсан шийтгэл ногдуулна:

1) эрдэнэсийн сангийн эрдэнэсийг хүлээн авах, хадга-

лах, хамгаалах, шилжүүлэх, байршуулах, тээвэрлэх журмыг зөрчсөн бол 1000—20000 төгрөгөөр торгох;

2) энэ хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалтыг зөрчсөн бол 5000—25000 төгрөгөөр торгох;

3) олборлох үйлдвэрээс тухайн жилд улсад худалдах хэмжээг зөрчсөн бол 15000—25000 төгрөгөөр торгох;

4) энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн бол хууль бусаар олсон орлого, эд зүйлийг хураажс 20000—25000 төгрөгөөр торгох.

20 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын

дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 12 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ХЭВЛИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Газрын хэвлийн хуулийн гарчгийг «Газрын хэвлийн тухай Монгол Улсын хууль» гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Газрын хэвлийн хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

«1. Газрын хэвлийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.»

2/4 дүгээр зүйл:

«4 дүгээр зүйл. Газрын хэвлий, түүний улсын нэгдмэл сан

1. Хөрснөөс доош газрын гүн рүү үргэлжлэх орон зай, түүнийг эзлэн орших материаллаг бүх зүйлс (бүх төрлийн чулуулаг, ашигт малтмал болон геологийн бусад биет, түүнчлэн барилга байгууламж)-ийг газрын хэвлий гэнэ.

2. Газрын хэвлий нь ашиглаж байгаа эсэхээс үл хамааран бүхэлдээ улсын нэгдмэл санг бүрдүүлнэ.»

3/6 дугаар зүйл:

«6 дугаар зүйл. Газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаарх үйл ажиллагааг төрөөс удирдах

1. Улсын Их Хурал газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаарх төрийн бодлогыг тодорхойлох;

2) газрын хэвлийн улсын нэгдмэл санг захиран зарцуулах бодлогын үндсийг тодорхойлж, чиглэлийг тогтоох;

3) хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

2. Засгийн газар газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлж, газрын хэвлийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулж хангах;

2) газрын хэвлийг ашиглах, хамгаалах техникийн нэгдсэн бодлогыг тодорхойлох;

3) хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

3. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

2) газрын хэвлийн баялаг, эрдэс түүхий эдийг зохистой ашиглах бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэх;

3) газрын хэвлийг ашиглах, геологийн судалгаа хийх үйл ажиллагаанд улсын хяналтыг хэрэгжүүлэх;

4) ердийн ашигт малтмалаас бусад ашигт малтмалын орд ашиглахад зориулан аж ахуйн нэгж, байгууллагад зохих хууль тогтоомжийн дагуу уурхайн эдэлбэр олгох;

5) хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

4. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх, газрын хэвлийг ашиглах үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөө багатайгаар хэрэгжүүлэхэд төрийн хяналт тавих;

2) газрын хэвлийг зохистой ашиглуулах, хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

3) хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

4/7 дугаар зүйл:

«7 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын бүрэн эрх

2. Аймаг нийслэлийн Засаг дарга газрын хэвлийг ашиг-газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) нутаг дэвсгэртээ газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаарх төрийн бодлого, газрын хэвлийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих;

2) энэ хэсгийн 1-д заасан асуудлын талаар аймаг, нийслэлийн Засаг даргын тайлан, мэдээллийг хэлэлцэх.

2. Аймаг нийслэлийн Засаг дарга газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) нутаг дэвсгэртээ газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлж, газрын хэвлийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, мөн хуульд заасан эрх хэмжээнийхээ дотор аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулж хангах;

2) нутаг дэвсгэртээ хийгдсэн геологийн судалгааны болон нутаг дэвсгэртээ оршиж байгаа ашигт малтмалын талаарх мэдээллийг зохих журмын дагуу холбогдох аж ахуйн нэгж, байгууллагаас гаргуулан авч танилцах;

3) газрын хэвлийг ашиглах, хамгаалах ажилд хяналт шалгалт хийх;

4) энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасан тохиолдолд газ-

рын хэвлийг ашиглах эрхийг хуульд заасан эрх хэмжээнийхээ дотор дуусгавар болгох;

5) газрын хэвлийг дур мэдэн ашиглах болон ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж дур мэдэн барихыг зогсоох;

6) хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.»

5/8 дугаар зүйл:

«8 дугаар зүйл. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын бүрэн эрх

1. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) нутаг дэвсгэртээ газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаарх төрийн бодлого, газрын хэвлийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих;

2) энэ хэсгийн 1-д заасан асуудлын талаар сум, дүүргийн Засаг даргын тайлан, мэдээллийг хэлэлцэх.

2. Сум, дүүргийн Засаг дарга газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) нутаг дэвсгэртээ газрын хэвлийг ашиглах, хамаалах талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлж, газрын хэвлийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, мөн хуульд заасан эрх хэмжээнийхээ дотор сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулж хангах;

2) нутаг дэвсгэртээ газрын хэвлийн баялгийг ашиглуулахтай холбогдуулан эдэлбэр газар олгох;

3) ашигт малтмалын нөөцийг илрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

4) ердийн ашигт малтмал, газар доорхи цэнгэг усыг ашиглах тухай саналыг холбогдох байгууллагад тавих;

5) ердийн ашигт малтмалын ордыг зохистой ашиглах болон газрын хэвлийг ашиглах явцад эвдэрсэн газрыг ашуул осолгүй болгож, аж ахуйн хэрэгцээнд цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулахад хяналт тавих, засаж тохижуулсан газрыг хүлээн авах;

6) хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.»

6/9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

«2. Монгол Улсын хууль тогтоомжид заасан тохиолдолд

газрын хэвлийг гадаад улсын хуулийн этгээд, иргэн, харьяалалгүй хүнд зохих журмын дагуу ашиглуулж болно.»

7/11 дүгээр зүйл:

«11 дүгээр зүйл. Газрын хэвлийг ашигласны төлбөр

1. Газрын хэвлийг төлбөртэй ашиглана.

2. Газрын хэвлийг ашигласны төлбөрийн дээд, доод хэмжээг хуулиар тогтооно.»

8/12 дугаар зүйл:

«12 дугаар зүйл. Геологийн судалгаа хийхэд зориулан ашиглуулахаар газрын хэвлийг олгох

1. Геологийн судалгаа хийх (геологийн тогтоц, ашигт малтмалын байршлын зүй тогтлыг судлан ордыг илрүүлж үнэлгээ өгөх, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газрын хэвлийг ашиглах, уул-техникийн болон шаардлагатай бусад нөхцөлийг тодруулах зэрэг)-эд зориулан ашиглуулахаар газрын хэвлийг олгох асуудлыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

2. Геологийн судалгаа хийгч нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйл ажиллагаагаа явуулах тухайгаа сум, дүүргийн Засаг даргад бүртгүүлсний дараа ажлаа эхэлнэ.»

9/15 дугаар зүйл:

«15 дугаар зүйл. Ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар ашиглуулахаар газрын хэвлийг олгох

1.Ашигт малтмал олборлох, газар доор нефть, хий, бусад бодис, материал хадгалах, хортой бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг хамгаалан булах, бохир ус зайлуулахаас өөр зориулалтаар ашиглуулахаар газар доор барилга байгууламж барих, ашиглахад зориулан газрын хэвлийг дор дурдсан байгууллага, албан тушаалтан олгоно:

1) улсын болон аймаг, нийслэлийн чанартай барилга байгууламж барих, ашиглахад зориулан тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга;

2) орон нутгийн чанартай барилга байгууламж барих, ашиглахад зориулан тухайн сум, дүүргийн Засаг дарга.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан барилга байгууламжийн ажлыг эхлэхдээ тухайн сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэнэ.

3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшил газрынхаа хилийн дотор ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар аж ахуйн болон ахуйн хэрэгцээндээ зориулан тухайн сум, дүүргийн Засаг даргаас тогтоосон журмын дагуу газрын хэвлийг ашиглах эрхтэй.

4. Газар доор нефть, хий, бусад бодис, материал хадгалах, хортой бодис, үйлдвэрлэлийн хаядлыг хамгаалан булах, бохир ус зайлуулах зориулалттай барилга байгууламж барих, ашиглахад зориулан газрын хэвлийг тухайн аймаг, нийслэлийн Засаг даргын зөвшөөрлийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга олгоно.

5. Газар доор нефть, хий, бусад бодис, материал хадгалах, хортой бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг булах, бохир ус зайлуулахдаа эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон тусгай нөхцөл, шаардлага хангасан байвал зохино.

6. Хүн амын эрүүл мэнд, мал, ан амьтан байгаль орчинд онцгой нөлөө бүхий хортой бодисыг хамгаалан булахад зориулан газрын хэвлийг ашиглуулах тухай асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

7. Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан зориулалтаар газрын хэвлийг ашиглуулахыг Засгийн газраас зөвшөөрсөн тохиолдолд газрын хэвлийг аймаг, нийслэлийн Засаг дарга олгоно. Гүйцэтгэгч байгууллага нь хортой бодисыг хамгаалан булснаа байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлнэ.»

10/19 дүгээр зүйл:

«19 дүгээр зүйл. Газрын хэвлийг ашиглах хугацаа

1. Газрын хэвлийг хугацаагүй буюу хугацаатайгаар ашиглалтад олгож болно.

2. Газрын хэвлийг урьдчилан тодорхой хугацаа тогтоолгүйгээр ашиглалтад олгосон бол хугацаагүй түрээслэн ашиглах гэнэ.

3. Газрын хэвлийг ашиглалтад хугацаатай олгох нийт хугацаа 30 жилээс илүүгүй байна. Шаардлагатай бол тогтоосон хугацааг газрын хэвлийг түрээслэн ашиглуулахаар анх олгосон байгууллагын шийдвэрээр сунгаж болох бөгөөд нэг удаад сунгах хугацаа 20 жилээс дээшгүй байна.

4. Ашигт малтмалын ордыг ашиглах хугацааг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв бай-

гууллагад уурхайн эдэлбэрийн зөвшөөрлийг бүртгүүлсэн өдрөөс эхлэн тооцно.»

11/27 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн сүүлчийн өгүүлбэр:

«Онцгой шаардлага гарвал ашигт малтмал олборлох аж ахуйн нэгж, байгууллагын зураг төслийг Засгийн газрын зөвшөөрснөөр ашигт малтмалын нөөц батлахаас өмнө зохиож болно.»

12/ Дөрөвдүгээр бүлгийн гарчиг:

«Газрын хэвлийг ашигт малтмал олборлох зориулалтаар ашиглах.»

13/31 дүгээр зүйл:

«31 дүгээр зүйл. Газрын хэвлийг ашигт малтмал олборлох зориулалтаар ашиглах журам

1. Ашигт малтмал олборлох аж ахуйн нэгж, байгууллага батлагдсан зураг төсөл, уулын ажлын төлөвлөгөө, техник ашиглалтын журмын дагуу газрын хэвлийг ашиглана.

2. Ашигт малтмал олборлох аж ахуйн нэгж, байгууллагын техник ашиглалтын журмыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлтэйгээр холбогдох төрийн захиргааны төв байгууллага батална.

3. Ашигт малтмал олборлох аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчныг бохирдуулсан, түүний баялгийг зүй бусаар ашигласан, гэмтээж сүйтгэсэн зэргээс учирсан хохирлыг арилгах үүрэгтэй.»

14/32 дугаар зүйлийн гарчиг:

«Газрын хэвлийг ашигт малтмал олборлох зориулалтаар ашиглахад тавих үндсэн шаардлага.»

15/32 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн эхлэл:

«1. Газрын хэвлийг ашигт малтмал олборлох зориулалтаар ашиглахдаа дараахь үндсэн шаардлагыг хангасан байвал зохино:»

16/35 дугаар зүйл:

«35 дугаар зүйл. Түрээслэгч нь газрын хэвлийг бусдад ашиглуулах

Уурхайн эдэлбэр түрээслэгч нь ордыг үйлдвэрлэлийн аргаар ашиглах боломжгүй болох нь тогтоогдсон хэсгийг

иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ажил гүйцэтгэх гэрээгээр ашиглуулж болно.»

17/38 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

«2. Уулын ажил эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага нь уурхайн доторх агаарын найрлагыг сайжруулах, уулын ажлын технологи, аюулгүй ажиллагааны арга, техник хэрэгслийг боловсронгуй болгох асуудлыг тусгасан, мэргэжлээс шалтгаалах өвчин, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн техник-зохион байгуулалтын иж бүрэн арга хэмжээ авч уулын ажил гүйцэтгэдэг ажилтан, албан хаагчдын аюул осолгүй, хэвийн ажиллаж, амьдрах болон ариун цэврийн дүрэм, хэм хэмжээг байнга боловсронгуй болгож байна.»

18/40 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

«3. Уул уурхайн аюул ослоос аврах үйл ажиллагааны дүрмийг холбогдох яам, тусгай газар, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай тохиролцож батална.»

19/44 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

«1. Олон нийтийн байгууллага, хөдөлмөрийн хамт олон нь хууль тогтоомж дүрмийнхээ дагуу газрын хэвлийг хамгаалах, зохистой ашиглах арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцож, төрийн байгууллагад тус дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.»

20/48 дугаар зүйл:

«48 дугаар зүйл. Ашигт малтмалын нөөцийн үнэмшлийг тогтоох

Газрын хэвлийн хайгуул хийсэн ордын ашигт малтмалын нөөцийг үнэн зөв байдал, тоо хэмжээ, чанар, орших нөхцөл, судалгааны түвшин, эдийн засгийн ач холбогдол, ордыг үйлдвэрлэлийн ашиглалтад бэлтгэсэн байдалд Улсын геологийн сан, мэдээллийн байгууллага магадлан шинжилгээ хийж үнэмшлийг тогтооно.»

21 /51 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

«1. Газрын хэвлийн ашиглалт, хамгаалалтад тавих төрийн хяналтын зорилт нь тус улсын яам, тусгай газар, аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, түүнчлэн гадаад улсын

хуулийн этгээд, иргэн, харьяалалгүй хүн хэвлийг ашиглах, хамгаалах талаар тогтоосон журмыг сахиж, түүнийг ашиглахад аюулгүй ажиллагааг хангах, болзошгүй аюул, хортой нөлөөнөөс хүн ам болон мал, ан амьтан, байгаль орчин, барилга байгууламжийг хамгаалах, сэргийлэх, уг аюул, хортой нөлөөг арилгах үүргийн биелэлтийг хангах, ашигт малтмалын нөөц, ордын болон газрын хэвлийн улсын тоо бүртгэлийн журам, түүнчлэн газрын хэвлийн тухай хууль тогтоомжийн бусад заалтыг хэрэгжүүлэх явдлыг хангахад оршино.»

22/52 дугаар зүйл:

«52 дугаар зүйл. Газрын хэвлийн ашиглалт, хамгаалалт, геологийн судалгаанд хяналт тавих байгууллага

1. Геологи, уул уурхайн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны байгууллага газрын хэвлийн ашиглалт, хамгаалалт, геологийн судалгаанд тус тус хяналт тавина.

2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, тэдгээрийн Засаг дарга нь газрын хэвлийн ашиглалт, хамгаалалтад тавих төрийн хяналтыг нутаг дэвсгэртээ эрх хэмжээнийхээ дагуу хэрэгжүүлнэ.»

23/53 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

«3. Засгийн газар нь газрын хэвлийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавих үүргийг холбогдох бусад байгууллагад хариуцуулах замаар аюулгүй ажиллагааны болон газрын хэвлийг хамгаалах журам, хэм хэмжээг зөрчихөөс сэргийлэх, зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авч хэрэгжүүлж болно.»

24/54 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг:

«2. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь геологийн судалгаатай холбогдуулан дараахь эрх эдэлнэ:

1) газрын хэвлийд геологийн судалгаа хийх үед гарсан зөрчил, дутагдлыг арилгах талаар заавал биелүүлэх шаардлагыг холбогдох аж ахуйн нэгж, байгууллагад тавьж, биелэлтийг нь хангуулах;

2) газрын хэвлийн геологийн судалгаа нь баталсан зураг төсөлд тохироогүй буюу түүнийг улсын бүртгэлд бүртгүүлээгүй, түүнчлэн энэ ажлыг хийх журам, хэм хэмжээг зөрчсөн байвал түүнийг зогсоох.

3. Засгийн газар нь газрын хэвлийд геологийн судалгаа хийх хэм хэмжээг зөрчихөөс сэргийлэх, зөрчлийг таслан зогсоохтой холбогдсон бусад журам тогтоож болно.»

25/56 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

«2. Газрын хэвлийг ашиглах асуудлаар гарсан эд хөрөнгийн маргааныг шүүх хянан шийдвэрлэнэ.»

26/58 дугаар зүйл:

«58 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

1. Газрын хэвлийг төр өмчлөх эрхийг аливаа хэлбэрээр зөрчсөн хэлцлийг хүчингүйд тооцно.

2. Газрын хэвлийн тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол геологи, уул уурхайн болон байгаль орчны хяналтын улсын байцаагч дор дурдсан шийтгэл ногдуулна:

1) газрын хэвлийг ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээг зөрчсөн бол 15000 хүртэл төгрөгөөр торгох;

2) газрын хэвлийг хамгаалах журам, түүнийг ашиглахад үүсч болзошгүй аюул осол, хортой нөлөөнөөс ажиллагчид, хүн ам болон мал, ан амьтан, байгаль орчин, барилга байгууламжийг хамгаалах шаардлагыг биелүүлээгүй бол 1000—15000 төгрөгөөр торгох;

3) газар доорх усны горимыг ашиглах цооног, геодези, маркшейдерийн тэмдгийг устгасан, гэмтээсэн бол 5000—15000 төгрөгөөр торгох;

4) ашигт малтмал олборлох, эрдэс түүхий эдийг боловсруулах, түүнчлэн ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн зураг төсөл зохиох, тэдгээрийг барих, ашиглалтад оруулах талаар энэ хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй бол 5000—15000 төгрөгөөр торгох;

5) энэ хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5-д заасан шаардлагыг биелүүлээгүй бол 5000—15000 төгрөгөөр торгох;

6) газрын хэвлийг дур мэдэн ашигласан, ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж дур мэдэн барьсан бол 10000—25000 төгрөгөөр торгох;

7) геологи, маркшейдерийн баримт бичиг, түүнчлэн

цаашид газрын хэвлийд геологийн судалгаа хийх, ордыг ашиглахад зайлшгүй шаардлагатай ашигт малтмалын сорьцын хувь, цооногийн чөмгийг үрэгдүүлсэн бол 25000 хүртэл төгрөгөөр торгох;

8) газрын хэвлийд геологийн судалгаа хийх журам, шаардлагыг зөрчсөн нь хайгуул хийсэн ашигт малтмалын нөөцийг буруу үнэлэх, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламжийг барих нөхцөлийг буруу тодорхойлоход хүргэсэн бол 15000—25000 төгрөгөөр торгох;

9) ашигт малтмалын ордыг гэмтээж сүйтгэсэн, баялаг хэсгийг нь өөрчлөн олборлосон, ашигт малтмалын балансын нөөцийг зохистой ашиглах шаардлагыг бусад хэлбэрээр зөрчсөн, олборлох үед ашигт малтмалын хаягдал, бохирдлыг тогтоосон хэм хэмжээнээс хэтрүүлсэн бол 15000—25000 төгрөгөөр торгох;

10) газрын хэвлийг ашиглах явцад эвдэрсэн газрыг аюул осолгүй болгож цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулаагүй бол 15000—25000 төгрөгөөр торгох.»

3 дугаар зүйл. Газрын хэвлийн хуульд дор дурдсан агуулгатай дараахь зүйл, хэсэг нэмсүгэй:

1/2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

«2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.»

2/10 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг:

«2. Газрын хэвлийд ашигт малтмалын хайгуул хийх, ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулна.

3. Газрын хэвлийг ашиглагчид нь газар эзэмшигч, ашиглагчдаас зохих журмын дагуу зөвшөөрөл авна.»

3/20 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

«3. Газрын хэвлийг ашиглагчид нь газар өмчлөх, эзэмших, ашиглах талаарх бусдын эрхийг аливаа хэлбэрээр хөндөхгүй байх үүрэгтэй бөгөөд ийм зөрчлийн улмаас тэдгээрт учруулсан хохирлыг өөрийн хөрөнгө, зардлаар нөхөн төлнө.»

4/41[1] дүгээр зүйл:

«41[1] дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх

1. Газрын хэвлийг ашиглагч нь байгаль орчныг хамгаа-

лах арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд энэ зорилгоор газрын хэвлийг болон ашигт малтмалын ордыг ашиглах зураг төсөл, техникийн баримт бичигт экологийн магадлан шинжилгээ, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.

2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг үндэслэн байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг арилгах, ашигт малтмалын орд, түүний хэсэг дэх малтсан газрыг дарах буюу цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулах, хөрсийг нь нөхөн сэргээх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3. Газрын хэвлийг ашиглагч энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүгийн баталгаа болгож мөнгөн барьцаат сум, дүүргийн нутгийн захиргааны байгууллагад шилжүүлнэ.

4. Мөнгөн барьцааны хэмжээ, түүнийг улсын орлого болгох асуудлыг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулна.»

5/45 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

«3. Ашигт малтмалын нөөц, ордын болон газрын хэвлийн улсын тоо бүртгэл, ашигт малтмалын ордын данс, нөөцийн балансыг Улсын геологийн сан эрхлэн хөтөлнө.»

4 дүгээр зүйл. Газрын хэвлийн хуулийн зүйл хэсэг, заалтад

«БНМАУ-ын» гэснийг «Монгол Улсын» гэж,

«Сайд нарын Зөвлөл» гэснийг «Засгийн газар» гэж,

«сум, хороо, район, орон нутгийн хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаа» гэснийг «сум, дүүргийн Засаг дарга» гэж,

«аймаг, хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаа» гэснийг «аймаг, нийслэлийн Засаг дарга» гэж,

«үйлдвэр, албан газар» гэснийг «аж ахуйн нэгж, байгууллага» гэж,

«түгээмэл тархацтай ашигт малтмал» гэснийг «ердийн ашигт малтмал» гэж,

«улсын геологийн хяналтын байгууллага», «улсын уул уурхайн хяналтын байгууллага» гэснийг «геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага» гэж,

«улсын өмч» гэснийг «төрийн өмч» гэж,

«дархан цаазтай» гэснийг «тусгай хамгаалалттай» гэж,

«хүрээлж байгаа байгаль, орчин» гэснийг «байгаль орчин» гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Газрын хэвлийн хуулийн зүйл, хэсэг заалтад «Улсын хороо» гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Газрын хэвлийн тухай хуулийн 5 дугаар зүйл (Газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаарх төрийн удирдлага), 14 дүгээр зүйл (Ашигт малтмалын ордыг ашиглахад зориулан уурхайн эдэлбэр олгох), 16 дугаар зүйл (Түгээмэл тархацтай ашигт малтмалын жагсаалт), 17 дугаар зүйл (Түгээмэл тархацтай ашигт малтмалын ордыг ашиглахад зориулан уурхайн эдэлбэр олгох нөхцөл), 25 дугаар зүйл (Ашигт малтмалын хайгуул хийсэн ордыг үйлдвэрийн ашиглалтад шилжүүлэх), 26 дугаар зүйл (Ашигт малтмалын ордыг анхлан нээгч), 34 дүгээр зүйл (Ашигт малтмал олборлох үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулах, татан буулгах, нөөцөд үлдээх), 38 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 12 дугаар бүлэг (Олон улсын гэрээ)-ийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл. Энэ хуулийг 1995 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын
дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1994 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 78

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Газрын тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай:

1) 1995 онд багтаан Монгол Улсын газрын сангийн бүртгэл, ангиллыг шинэчлэх;

2) аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрыг газар зохион байгуулалтын мэргэжлийн боловсон хүчнээр хангах, тэдгээрийг газрын менежментийн чиглэлээр мэргэшлүүлэх;

3) Газрын төлбөрийн тухай хуулийн төслийг 1994 онд багтаан боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

4) Газрын тухай хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах журам зааварболон гэрчилгээ, бусад баримтын маягтыг батлан албажуулах;

5) Засгийн газрын болон яам, тусгай газрын шийдвэрийг 1995 оны 4 дүгээр сарын 1-ний дотор багтаан Газрын тухай хуульд нийцүүлэх.

Дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1994 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр

Дугаар 81

Улаанбаатар хот

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай Монгол Улсын хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай:

1) тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөрийг боловсруулж 1996 оны 1 улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2) тусгай хамгаалалттай газар нутгийн зохих бүсэд оршин суугаа иргэд, оршин байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудтай Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулд, заасан болзол, хугацаа, журмын дагуу газар ашиглах гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах;

3) Засгийн газар болон яам, тусгай газрын шийдвэрийг 1995 оны 4 дүгээр сарын 1-ний дотор багтаан Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нийцүүлэх.

Дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1994 оны 12 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 92

ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ

Үнэт цаасны тухай Монгол Улсын хуулийн 19 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХнь:

Үнэт цаасны хорооны дүрмийг хавсралтын ёсоор батал-сугай.

Дарга **Н. БАГАБАНДИ**

Монгол Улсын Их Хурлын 1994 оны 92 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ҮНЭТ ЦААСНЫ ХОРООНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Үнэт цаасны хороо нь (цаашид «хороо» гэх) үнэт цаасны зах зээлийн харилцаанд оролцогч этгээдийн үйл ажиллагаат зохицуулах, хянах эрх бүхий байгуул-лага мөн.

2 дугаар зүйл. Хорооны зорилт нь Үнэт цаасны тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, үнэт цаасны зах зээлд оролцогч этгээдийн үйл ажиллагаанд хя-налт тавих, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, үнэт цаасны зах зээлийн талаар олон нийтэд мэдээлэл өгөх, эрх хэмжээнийхээ дотор гаргасан журмыг хэрэгжүүлэх, аргачлал, заавар боловсруулах, сургалт явуулах ажлыг удирдан зохицуулахад оршино.

3 дугаар зүйл. Хороо нь Монгол Улсын Үнэт цаасны

тухай хууль тогтоомж, энэ дүрмийг удирдлага болгон ажиллана.

4 дүгээр зүйл. Үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан журмын дагуу Улсын Их Хурал хорооны дарга, гишүүдийг 5 жилийн хугацаатаар томилно. Даргыг зөвхөн нэг удаа улируулан томилж болно.

5 дугаар зүйл. Хороо нь үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд хариуцан тайлагнана.

6 дугаар зүйл. Хороо үйл ажиллагаагаа явуулахдаа үнэт цаасны зах зээлд оролцогч этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, бусдын нөлөөнд үл автах болон хамтын удирдлагын зарчмаар ажиллана.

7 дугаар зүйл. Хорооны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

8 дугаар зүйл. Хорооноос үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг хангах асуудлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар хариуцна.

9 дүгээр зүйл. Үнэт цаасны тухай хууль тогтоомжийн хэрэгжүүлэхээр хорооноос гаргасан шийдвэрийг үнэт цаасны зах зээлд оролцогч этгээд дагаж биелүүлэх үүрэгтэй.

10 дугаар зүйл. Хороо нь үнэт цаасны зах зээлийг зохицуулах, хяналт тавихтай холбогдуулан гаргасан тогтоол, шийдвэр болон өөрийн үйл ажиллагааны талаар нийтэд мэдээлж байна.

11 дүгээр зүйл. Хороо нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, (тэмдэг), албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Хорооноос явуулах үйл ажиллагаа

12 дугаар зүйл. Хороо нь Үнэт цаасны тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд дараахь үйл ажиллагаа явуулна:

1) үнэт цаасны тухай хууль тогтоомжийг үнэт цаасны зах зээлд оролцогчдоос хэрэгжүүлж байгаа байдал, үр дүнг судлан, боловсронгуй болгох талаар саналаа боловсруулж зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;

2) үнэт цаасны зах зээлийн талаар эрх хэмжээнийхээ дотор гаргасан журмыг хэрэгжүүлэх, аргачлал, заавар боловсруулах, сургалт явуулах ажлыг удирдан зохион байгуулах;

3) хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түү-

ний мөрөөр авсан арга хэмжээний тухай цаг тухайд нь олон нийтэд мэдээлж байх;

4) үнэт цаасны зах зээлийн талаар тухайн жилд явуулах бодлого, үндсэн чиглэлийг Улсын Их Хуралд танилцуулах;

5) санхүү бүртгэл, хяналт шалгалтын ажлын мэдлэг туршлагатай хүмүүсийг сонгон авч үнэт цаас гаргагчийн тайлан тэнцэл, санхүүгийн бусад үйл ажиллагаанд шалгалт хийлгэх, тэдэнд зохих урамшил олгох;

6) үнэт цаас өмчлөгчдийн цөөнхийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах.

Гурав. Хорооны удирдлага, ажлын зохион байгуулалт

13 дугаар зүйл

1. Хорооны ажлын зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Гишүүдийг олонхи оролцсоноор хорооны хуралдаан хүчин төгөлдөр болно.

2. Хорооны дарга, гишүүд хуралдаанд таслах эрхтэй оролцоно. Асуудлыг хуралдаанд оролцогчдын дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.

3. Хороо тогтоол гаргана. Тогтоолд дарга гарын үсэг зурна.

4. Хуралдааныг ажлын шаардлагаар, эсхүл хорооны даргын санал, гишүүдийн олонхи шаардсанаар хийнэ.

14 дүгээр зүйл

1. Хорооны дарга дараахь эрх үүрэгтэй байна:

1) Хорооны ажлыг удирдан зохион байгуулах;

2) хуралдааны бэлтгэлийг хангуулж, хуралдааныг даргалах;

3) Хорооны нэрийн өмнөөс бусад байгууллагатай харилцаж Хороог дотоод, гадаадад төлөөлөх;

4) батлагдсан төсвийг захиран зарцуулах;

5) ажилтнуудын ажил үүргийн хуваарийг баталж мөрдүүлэх;

6) дотоод ажлын хүрээнд хамаарах асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах;

7) батлагдсан төсөвт багтааж, орон тооны бус гишүүдэд урамшил олгох асуудлыг шийдвэрлэх.

2. Хорооны даргын эзгүйд түүнийг Хорооны шийдвэрээр аль нэг гишүүн орлон ажиллана.

3. Хорооны даргын цалинг Улсын Их Хурал тогтооно.

15 дугаар зүйл

Хорооны гишүүн нь:

1. Ажил үүргийн хуваарьт заасан үүргээ биелүүлэхээс гадна Хорооны шийдвэрээр тодорхой ажил үүргийг гүйцэтгэнэ.

2. Хорооны гишүүн нь Хорооны зөвшөөрөл бүхий хөрөнгийн биржийн буюу үнэт цаасны худалдаа, арилжаанд хувийн сонирхлоор хандахыг хориглоно.

16 дугаар зүйл

1. Хорооны дарга, гишүүд, орон тооны ажилтан үнэт цаас өмчилж байгаагаа Хороонд тухай бүр мэдээлэх үүрэгтэй.

2. Хорооны дарга, гишүүд компаниас гаргасан үнэт цаасны хяналтын хувийг өмчилж байгаа бол тэдгээр нь тухайн компанитай холбогдолтой аливаа шийдвэр гаргахад таслах эрхтэй оролцохгүй.

17 дугаар зүйл. Хяналт шалгалтын ажлын зохих туршлагатай өндөр мэдлэг дадлагатай, итгэл найдвар хүлээх боломжтой ажилтанд Хорооноос үнэт цаасны түйлгээний хяналтын улсын байцаагчийн эрх олгож болно.

18 дугаар зүйл. Үнэт цаасны түйлгээний хяналтын улсын байцаагч Үнэт цаасны тухай хуулийн хүрээнд дараахь үйл ажиллагаа явуулна:

1) үнэт цаасны холбогдолтой бүртгэл хөтлөх, мэдээ, тайлан гаргах ажлыг үнэт цаас гаргагч болон үнэт цаасны зах зээлд оролцогч этгээдүүд тогтоосон хугацаанд гүйцэтгэж байгаа эсэхэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авах;

2) үйлчилгээний хураамжийг холбогдох этгээд хуулийн дагуу төлж байгаа эсэхийг шалгах;

3) үнэт цаас гаргах, нийтэд санал болгож худалдах, арилжих, түүний төлбөр тооцоог хийх, хадгалах зэрэгтэй холбогдсон түйлгээнд баримтын шалгалт хийх.

19 дүгээр зүйл. Улсын байцаагч үнэмлэхтэй байх бөгөөд хувийн тэмдэг, торгуулийн хуудас хэрэглэнэ.

20 дугаар зүйл. Үнэт цаасны түйлгээний хяналтын улсын байцаагч нь албаны үйл ажиллагааг буруу явуулсан бол хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

21 дүгээр зүйл. Улсын байцаагчийн үйл ажиллагааны талаар үнэт цаас гаргагч, үнэт цаасны зах зээлд оролцогч

эцгээд болон сонирхогч бусад этгээд гомдлоо Хороонд болон шүүхэд гаргаж болно. Хороо гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш нэг сарын дотор барагдуулж, хариу өгнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1994 оны 12 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 93

ҮНЭТ ЦААСНЫ ХОРООНЫ ЗАРИМ ГИШҮҮНИЙГ ТОМИЛОХ ТУХАЙ

Үнэт цаасны тухай Монгол Улсын хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Бямбажавын Гантөмөр, Догсомжавын Балдан-Очир нарыг Үнэт цаасны хорооны гишүүнээр томилсугай.

Дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1994 оны 12 дугаар сарын 22-ны өдөр | Улаанбаатар хот

Дугаар 94

СТАНДАРТЧИЛАЛ, ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай Монгол Улсын хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасугай:

1. Засгийн газар болон яам, тусгай газрын шийдвэрийг 1995 оны 4 дүгээр сарын 1-ний дотор энэ хуульд нийцүүлэх;

2) стандартчилал, чанарын баталгаажуулалт, хэмжилзүйн үйл ажиллагааг төв болон орон нутагт нэг байгууллага хэрэгжүүлэх нөхцөлийг хангах.

Дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1994 оны 12 дугаар сарын 22-ны өдөр | Улаанбаатар хот

Дугаар 95

ХЭМЖЛИЙН НЭГДМЭЛ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай Монгол Улсын хуульд Засгийн газрын болон яам, тусгай газрын шийдвэ-

рийг 1995 оны 4 дүгээр сарын 1-ний дотор нийцүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газарт үүрэг болгосугай.

Дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1994 оны 12 дугаар сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 96

ГАЗРЫН ХЭВЛИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Газрын хэвлийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Дараахь арга хэмжээг 1995 оны 4 дүгээр сарын 1-ний дотор авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай:

1) Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг орсон бүх нэмэлт, өөрчлөлтийг тусган одоогийн мөрдөж байгаа хууль тогтоомжийн техник, хэл зүйн шаардлагад нийцүүлэн боловсруулж бүрэн эхээр нь төрийн төв хэвлэлд албан ёсоор нийтлүүлэх;

2) дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газар, яам, тусгай газрын шийдвэрийг энэ хуульд нийцүүлэх.

Дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 1 дүгээр сарын 02-ны өдөр | Улаанбаатар хот

Дугаар 01

ХУУЧИН ЮГОСЛАВЫН БҮГД НАЙРАМДАХ МАКЕДОН УЛСЫН ТУСГААР ТОГТНОЛЫГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Ард түмний өөртөө засан тохинох эрхийг хүндэтгэх зарчмыг үндэслэн хуучин Югославын Бүгд Найрамдах Македон Улсын тусгаар тогтнолыг Монгол Улс хүлээн зөвшөөрсүгэй.

2. Хуучин Югославын Бүгд Найрамдах Македон Улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн тухай тус Улсын Засгийн газарт мэдэгдэж дипломат харилцаа тогтоох талаар хэлэлцээ хийхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай.

Дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 1 дүгээр сарын 02-ний өдөр | Улаанбаатар хот

Дугаар 02

МОНГОЛБАНКНЫ 1995 ОНЫ ОРЛОГО, ЗАРЛАГЫН ТӨСВИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монголбанкны 1995 оны орлогыг 1130,0 сая төгрөгөөр; зарлагыг 900,0 сая төгрөгөөр; үүнээс хүүний орлогоос давсан зарлагыг 100,0 сая төгрөгөөр тус тус баталсугай.

Дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 04

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Төрийн албаны тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай:

1) хууль тогтоомж, Засгийн газрын болон холбогдох бусад байгууллагын шийдвэрийг Төрийн албаны тухай хуульд нийцүүлэх;

2) Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах бэлтгэл ажлыг хангах;

3) төрийн албаны төв байгууллагын дүрмийн төслийг боловсруулж 1995 оны 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

Дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 1 дүгээр сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 05

«ХҮҮХЭД-ХӨГЖИЛ-ХАМГААЛАЛ» СЭДЭВТ ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 1, арван долдугаар зүйлийн 2, манай улс 1990 онд

нэгдэн орсон Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн үзэл санааг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын төрийн бодлогын Хүүхэд бүр эсэн мэнд амьдарч хөгжих тэгш нөхцөл бүрдүүлэх үзэл баримтлалыг тогтоох, түүний эрх зүйн баталгааг Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлэн боловсронгуй болгох бэлтгэлийг хангах, энэ асуудлаар нийгмийн зөвшилд хүрэх, үндэсний мэдрэмжийг дээшлүүлэх зорилгоор «Хүүхэд-хөгжил-хамгаалал» сэдэвт үндэсний анхдугаар чуулганыг 1995 оны 1 дүгээр улиралд багтаан хийх нь зүйтэй гэж үзсүгэй.

2. «Хүүхэд-хөгжил-хамгаалал» сэдэвт чуулганыг бэлтгэж, зохион байгуулах ажлын төлөвлөгөө, хорооны бүрэлдэхүүнийг батлаж, шаардлагатай туслалцаа дэмжлэг үзүүлж ажиллахыг Улсын Их Хурлын дарга (Н. Багабанди)-д даалгасугай.

дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 1 дүгээр сарын 06-ны өдөр | Дугаар 06 | Улаанбаатар хот

АЖЛЫН ХЭСЭГ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан бэлтгэж Улсын Их Хурлын 1995 оны хаврын чуулганд хэлэлцүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

1. Ж. Гомбожав — Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга

Ажлын хэсгийн гишүүд:

2. Р. Гончигдорж — Улсын Их Хурлын гишүүн
3. Ж. Жадамбаа — Улсын Их Хурлын гишүүн
4 Ч. Зоригтбаатар — Улсын Их Хурлын гишүүн
5. Д. Лүндээжанцан — Улсын Их Хурлын гишүүн
6. Б. Чимид — Улсын Их Хурлын гишүүн

дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 1 дүгээр сарын 09-ний өдөр — Улаанбаатар хот

Дугаар 8

ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛҮҮЛЭХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Засгийн газар, нийслэлийн нутгийн захиргааны байгууллага хоорондын тохиролцсоны үндсэн дээр Төв аймгийн төсвийн зарлагын зарим хэсгийг нөхөхөд зориулан Улаанбаатар хотын төсвөөс зээлээр түр олгосон 154094,2 мянган төгрөгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, шаардлагатай гэж үзвэл саналаа 1994 оны төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хамт Улсын Их Хуралд оруулахыг Засгийн газарт даалгасугай.

дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 1 дүгээр Улаанбаатар

Дугаар 10

сарын 10-ны өдөр хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Монгол Улсын Их Хурлын Байнгын хороодын бүрэлдэхүүнийг дараахь байдлаар тогтоосугай:

1. Нийгмийн бодлогын байнгын хороо:

1) В. Алзахгүй
2) Д. Батбаатар
3) Ш. Батбаяр
4) О. Батмөнх
5) С. Батмөнх
6) Ж. Батсуурь
7) Н. Баяртсайхан
8) Ж. Болдбаатар
9) Ж. Бямбажав
10) А. Ганбаатар
11) Т. Ганди
12) Р. Гончигдорж
13) Б. Дэмбэрэл
14) Б. Лхагвасүрэн
15) Д. Мөнхөө
16) Ц. Намхайнямбуу
17) Н. Тогтох
18) Ц. Товуусүрэн
19) Ц. Төрмандах
20) Г. Төртогтох
21) С. Чулуунбаатр
22) Ш. Чунаг
23) Л. Энэбиш
24) Н. Энхбаяр
25) Т. Эрдэнэбилэг

2. Төрийн байгуулалтын байнгын хороо:

1) Ё. Адилбиш
2) Д. Базарсад
3) Д. Батбаатар
4) С. Батмөнх
5) О. Батмөнх
6) А. Болат
7) Ж. Болдбаатар
8) Ж. Бямбадорж
9) А. Ганбаатар
10) Ц. Ганбат
11) Б. Ганболд
12) Н. Ганбямба
13) Т. Ганди
14) Ч. Ган-Өлзий
15) Р. Гончигдорж
16) Б. Гомбо
17) Ц. Гомбосүрэн
18) С. Гүндэнбал
19) Д. Дагвасүрэн
20) Д. Дашцэдэн

21) Н. Жалбажав
22) Ж. Жадамбаа
23) П. Жасрай
24) С. Зориг
25) Ч. Зоригтбаатар
26) М. Зэнээ
27) Д. Лүндээжанцан
28) Ц. Нямдорж
29) С. Төмөр
30) Г. Төртогтох
31) Б. Чимид
32) С. Чулуунбаатар
33) Ш. Чунаг
34) О. Шаалуу
35) Л. Энэбиш
36) Т. Эрдэнэбилэг

3. Төсөв, санхүү, мөнгө, зээлийн бодлогын байнгын хороо

1) А. Базархүү
2) Ш. Батбаяр
3) Ч. Баянжаргал
4) А. Болат
5) Ж. Бямбажав
6) А. Ганбаатар
7) Ц. Ганбат
8) Д. Ганболд
9) Ц. Гомбосүрэн
10) С. Гүндэнбал
11) Д. Дагвасүрэн
12) М. Далайхүү
13) Д. Данзан
14) Ж. Дэлгэрцэцэг
15) Д. Дэмбэрэл
16) С. Зориг
17) Д. Мөнхөө
18) М. Мэндбилэг
19) С. Нарангэрэл
20) С. Нямзагд
21) Т. Очирхүү
22) Р. Одонбаатар
23) Г. Цэдэндагва
24) Ч. Пүрэвдорж
25) Н. Энхбаяр
26) Л. Энэбиш

4. Хууль зүйн байнгын хороо:

1) А. Базархүү
2) Ж. Бямбадорж
3) Х. Володя
4) Г. Ганболд
5) Б. Гомбо
6) Ж. Гомбожав
7) Р. Гончигдорж
8) М. Далайхүү
9) Н. Жалбажав
10) С. Зориг
11) Ч. Зоригтбаатар
12) М. Зэнээ
13) М. Мэндбилэг
14) С. Нарангэрэл
15) Ж. Норовсамбуу
16) Ц. Нямдорж
17) С. Нямзагд
18) Ц. Төрмандах
19) С. Төмөр
20) Ц. Шаравдорж
21) Т. Эрдэнэбилэг

5. Хөдөөгийн бодлого, байгаль орчны байнгын хороо:

1) Ж. Алгаа
2) В. Алзахгүй
3) Н. Багабанди
4) Д. Базарсад

5) О. Батмөнх
6) Ж. Батсуурь
7) Н. Баяртсайхан
8) Х. Володя
9) Б. Ганболд
10) Д. Ганболд
11) Ч. Ган-Өлзий
12) Д. Дагвасүрэн
13) М. Далайхүү
14) Ч. Дашдэмбэрэл
15) Д. Дашцэдэн
16) Б. Дэмбэрэл
17) Ж. Жадамбаа
18) Д. Идэвхтэн
19) Д. Лүндээжанцан
20) М. Мэндбилэг
21) Ж. Норовсамбуу
22) Р. Одонбаатар
23) Т. Султан
24) Н. Тогтох
25) Г. Төртогтох
26) Ж. Уртнасан
27) Ч. Хурц
28) Б. Чимид

6. Эдийн засгийн бодлогын байнгын хороо:

1) Ж. Алгаа
2) Ж. Батсуурь
3) Ч. Баянжаргал
4) Ж. Бямбажав
5) Б. Ганболд
6) Г. Ганболд
7) Д. Ганболд
8) Н. Ганбямба
9) Д. Данзан
10) Ж. Дэлгэрцэцэг
11) Д. Дэмбэрэл
12) Ч. Зоригтбаатар
13) Д. Идэвхтэн
14) Р. Одонбаатар
15) Т. Очирхүү
16) Ч. Пүрэвдорж
17) Т. Султан
18) Ц. Товуусүрэн
19) Н. Тогтох
20) Ж. Уртнасан
21) Ч. Хурц
22) Р. Цагаанхүү
23) Г. Цэдэндагва
24) О. Шаалуу
25) Ц. Шаравдорж

Хоёр. Энэ тогтоолыг 1995 оны 1 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гурав. Монгол Улсын Их Хурлын 1993 оны 80 дугаар тогтоолыг энэ тогтоол хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 12 дугаар сарын 06-ны өдөр — Улаанбаатар хот

Дугаар 158

САМБУУГИЙН ИШБАЛЖИРТ МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ БАГШ ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Техникийн их сургуулийн багшаар үр бүтээлтэй ажиллан авто-тээврийн олон зуун инженер, эдийн засагч бэлтгэж, их дээд сургуулийн багш, оюутан, үйлдвэрийн инженер техникийн ажилтан нарт чухал шаардлагатай ном, сурах бичиг, аргачлал бичиж нийтийн хүртээл болгож, хиам, үрлэн чихэр, ундаа үйлдвэрлэх цехийн тоног төхөөрөмж зохион бүтээж, хөдөлмөр хөнгөвчлөх, үйлдвэрлэлийн технологийг боловсронгуй болгох олон шинэ бүтээл, оновчтой санал гарган үйлдвэрлэлд нэвтрүүлж техникийн сэтгэлгээг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Техникийн их сургуулийн Тээврийн сургуулийн дэд захирал Самбуугийн Ишбалжирт Монгол Улсын гавьяат багш цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч — **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 12 дугаар сарын 06-ны өдөр — Улаанбаатар хот

Дугаар 159

МЯГМАРЫН ХАЖИДМААД МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ МЕХАНИКЖУУЛАГЧ ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Газар тариалангийн үйлдвэрлэлд олон жил үр бүтээлтэй ажиллаж, техникийн хүчин чадлыг бүрэн ашиглан уринш

боловсруулалт, тариалалтыг агротехникийн шаардлагын дагуу мэргэжлийн өндөр төвшинд чанартай явуулснаар жил бүр арвин ургац хурааж, нэгж талбайгаас авах ургацын хэмжээг улс, аймгийн дунджаас давуулж, үр тарианы салааг чадамгай удирдан зохион байгуулан ажилсаг, туршлагатай хамт олныг бүрдүүлж газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Булган аймгийн Орхон сумын «Мандал» компанийн салааны ахлагч, мехникжуулагч Мягмарын Хажидмаад Монгол Улсын гавьяат механикжуулагч цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 12 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 160

ДАМБЫН ЛХАГВАСҮРЭНД МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ГАВЬЯАТ ЭМЧ ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Мэс заслын эмчилгээний шинэ аргуудыг чадамгай эзэмшиж, орон нутгийн нөхцөлд олон зуун хүнд мэс заслын тусламжийг мэргэжлийн өндөр төвшинд үзүүлж, малчид, хөдөлмөрчдийн эрүүл мэндийг хамгаалах үйлсэд идэвхи зүтгэл гарган үр бүтээлтэй ажиллаж байгааг нь үнэлж Булган аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийн эрхлэгч Дамбын Лхагвасүрэнд Монгол Улсын Хүний гавьяат эмч цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 12 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 161

БАЛЖИРЫН ХЭНМЭДЭХЭВТ МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ГАВЬЯАТ ЭМЧ ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Эрүүл мэндийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж эх барих эмэгтэйчүүдийн тусламжийг хөдөөгийн хүн амд шуурхай хүргэхэд хүч хөдөлмөрөө дайчлан, мэргэжлийн ур чадвараараа олон түмний талархлыг хүлээж, эхийн эндэгдлийг улсын хэмжээний хамгийн бага төвшинд хүртэл бууруулан эх, нялхсын эрүүл мэндийг сахин хамгаалах үйлсэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн эрхлэгч Балжирын Хэнмэдэхэвт Монгол Улсын Хүний гавьяат эмч цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 12 дугаар сарын 6-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 162

ЗАРИМ ХҮНИЙГ ОДОН, МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Төрийн захиргааны байгууллага болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд олон жил үр бүтээлтэй ажиллаж байгааг нь үнэлж Дорноговь аймгийн дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

«Алтан гадас» одонгоор:

1. Лувсангийн Ишдорж
Дорноговь аймгийн Алтанширээ сумын «Саруул зам» ББХК-ийн захирал
— Зах зээлийн үед компанийхаа хамт олныг чадамгай зохион байгуулан удирдаж үйлдвэрлэлийн эдийн засгийн үзүүлэлтүүдийг жил бүр тогтвортой нэмэгдүүлэн хөдөөгийн хөдөлмөрчдийн нийгэм, ахуйн хэрэгцээг хангах болон нутгийн захиргааны байгууллагыг аж ахуй, санхүүгийн хувьд бэхжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

2. Шагдаржавын Маналжав
Дорноговь аймгийн «Равжаа» сангийн даамал
— Төрийн болон аж ахуйн байгууллагын удирдах ажилтнаар олон жил үр бүтээлтэй ажиллаж аймгийн төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, ажлаар доголдож байсан салбарын ажлыг богино хугацаанд сайжруулах, сүүлийн жилүүдэд «Равжаа» санг санаачлан зохион байгуулж ноён хутагт Данзанравжаагийн үйл амьдрал, уран бүтээлийг судлан сурталчилж дэлгэрүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

Хөдөлмөрийн хүндэт медалиар:

1. Дамдиндоржийн Баатар
Дорноговь аймгийн архивын эрхлэгч
— Аймгийн архивын сан хөмрөгийг баяжуулах, ялангуяа ноён хутагт Данзанравжаагийн уран бүтээл, намтар болон гүн ухаан, соёлын гайхамшигт бүтээл «Эрхэм дээд», «Алтан-гэ-

рэл» зэрэг судруудыг кирилл үсэгт буулгасан, түүний 26 бүтээлийг шинээр олж «Үлэмжийн чанар» эмхэтгэлд оруулсан зэргийг үнэлж

2. Цагааны Дэмбээ Дорноговь аймгийн Алтанширээ сумын «Саруул зам» ББХК-ийн малчин — Нэгдэл, компанийн малчнаар олон жил үр бүтээлтэй ажиллаж үйлдвэрлэлийн даалгавар, захиалгыг жил бүр тогтмол давуулан биелүүлж, олон залуу малчныг халамжлан хүмүүжүүлж мал маллах, амьдрах арга ухаанд сургахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 163

СҮРЭНГИЙН ЦЭРЭНДОЛГОРТ МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ЖҮЖИГЧИН ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Төв, орон нутгийн урлагийн байгууллагад үр бүтээлтэй ажиллаж иргэний уянгын болон монгол ардын олон арван дуур үзэгч сонсогчдын сэтгэл зүрхэнд хоногшгол чадварлаг дуулж, монголын радио, телевизийн урын санг баяжуулан эх орныхоо соёл урлагийг дотоод, гадаадад сурталчлахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Сүрэнгийн Цэрэндолгорт Монгол Улсын гавьяат жүжигчин цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН
ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1995 оны 1 дүгээр сарын 4-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 01

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТ МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ ЗӨРЧСӨН ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн энэ дүгнэлтийг 1995 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 20 цагт зөвлөлдөх тасалгаанд (төрийн ордны 251 дүгээр өрөө) үйлдэв.

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн хуралдааныг Цэцийн гишүүн Г. Нямдоо даргалж, гишүүдэд Л. Баасан, Ц. Цолмон, С. Жанцан, Ч. Энхбаатар (илтгэгч) нарын бүрэлдэхүүнтэй, Цэцийн хуралдааны нарийн бичгийн даргаар Цэцийн нарийн бичгийн дарга Б. Цэндээхүүг оролцуулан хийв.

Хуралдаанд маргагч талуудыг төлөөлж гомдол гаргагч иргэн Д. Ламжав, Ц. Цэрэнжээ нар Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч С. Чулуунбаатар, Г. Ганболд нар оролцов.

Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 13 дугаар хорооны иргэн Дондовын Ламжав Үндсэн хуулийн Цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө:

1. Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн «. . . Улсын Их Хурлын гишүүний тавьсан асуулт, асуулгын талаар гарсан маргааныг Улсын Их Хурал эцэслэн шийдвэрлэнэ» гэсэн заалт Үндсэн хуулийн 52 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн «Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ», 50 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн «Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ», 64 дүгээр зүйлийн нэг дэх хэсгийн «. . . Цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн» гэсэн заалтуудыг зөрчиж байна. Учир нь Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт

дурдсан маргаан нь Үндсэн хууль, бусад хуулийг сахиулахтай холбогдон гарч болох бөгөөд энэ тухай Цэцийн бүрэлдэхүүнд нэг шатны шүүхийн шийдвэр гарч болно.

2. Улсын Их Хурлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн «. . . Үүнд илтгэлийг сонссоны дараа Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг сонсоно. . .», 38 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн «. . . хэрэв Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан үндэслэл байна гэж үзвэл Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг заавал сонсоно. . .» гэсэн заалтууд Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн «Үндсэн хуулийн Цэц энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр дараахь маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна» гэсэн заалтыг зөрчиж байна. Учир нь 66 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт заасан үндэслэл гараагүй нөхцөлд Цэцээс дүгнэлт гарахгүй тул Цэцийн дүгнэлтийг шууд дуудан сонсох хууль зүйн үндэслэл байхгүй юм.

3. Улсын Их Хурлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн «. . . Улсын Их Хурал Ерөнхийлөгчийг огцруулах асуудлыг хэлэлцэхдээ дараахь шалтгаан, нөхцөлийг заавал тогтоосон байна:

1. Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан үндэслэлээр Үндсэн хуулийн Цэцийн гаргасан дүгнэлт үнэн зөв эсэх;

2. Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж, Үндсэн хууль зөрчсөн үндэслэл, шалтгааныг зөв тогтоосон эсэх;

3. Ерөнхийлөгч Үндсэн хууль зөрчсөн хүрээ, нөхцөл байдлыг зөв тогтоосон эсэх гэсэн заалт Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх заалт болон 35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн «Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаар хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний дийлэнх олонхийн саналаар огцруулна» гэсэн заалтуудыг зөрчиж байна. Учир нь Үндсэн хуулийн холбогдох заалтууд ёсоор Ерөнхийлөгчийг огцруулах буюу эгүүлэн татах үндэслэл байгаа нь Цэцийн дүгнэлтээр нэгэнт тогтоогдсон үед л энэ асуудлыг Улсын Их Хурал авч хэлэлцэх бөгөөд хэлэлцэх явцад Цэцийн дүгнэлтийг хэлэлцэх ёсгүй. Гэтэл хэлэлцэхээр хуульчилсан нь Үндсэн хуулийн дээрх хоёр заалтыг зөрчиж байна.

4. Улсын Их Хурлын тухай хуулийн 45[2] дугаар зүйлийн

нэг дэх хэсгийн «Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын шийдвэрийн талаар гарсан ... Цэцийн дүгнэлтийг ... Цэцийн дарга, эсхүл түүний итгэмжилснээр ... Цэцийн аль нэг гишүүн Улсын Их Хуралд танилцуулна» гэсэн заалтаас өөр Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтын дагуу Цэцийн дүгнэлтийг хэлэлцэх тухай заалт энэ хуульд ороогүй байна. Тодруулж хэлбэл, Улсын Их Хурлын авч хэлэлцэх ёстой арван төрлийн Цэцийн дүгнэлтээс хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн талаар гарсан Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хэрхэн авч хэлэлцэхийг дээрх зүйлд тодорхой заасан боловч үлдсэн найман төрлийн дүгнэлтийг хэрхэн хэлэлцэх талаар Улсын Их Хурлын тухай хуульд заагаагүй байна. Улсын Их Хурлаар хэлэлцэх ёстой Цэцийн дүгнэлтийнхүү өрөөсгөл тусгагдсан атлаа Улсын Их Хурлаар хэлэлцэх ёсгүй, Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт (3, 4-т) заасны дагуу гарсан Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хэлэлцэхээр хуульчилсан тухай дээр өгүүлсэн билээ. Улсын Их Хурлын байнгын хороо (Дотоод асуудлын) 1994 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн хурлаараа гишүүн Ц. Төрмандах Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн тухай Цэцийн дүгнэлтийг хүлээж авах боломжгүй гэж үзэж, энэ дүгнэлтээ Улсын Их Хуралд оруулжээ.

Гишүүд Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4 дэх заалтын дагуу гарсан Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал шүүн хэлэлцэж эцсийн шийдвэр гаргах эрхтэй эсэх талаар маргалдсан боловч ганц ч удаа санал хураагаагүй бөгөөд дараа нь энэ асуудлаар тайлбар гаргахаар болж уг асуудлыг хаажээ.

Харин С. Зоригг Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн нэг дэх хэсгийн заалтыг зөрчсөн тухай Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийн талаар дахин хүчтэй маргаан өрнүүлсний эцэст санал хурааж Цэцийн дүгнэлтийг зөвшөөрчээ. Иймхүү Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан асуудлаар цаашдаа Үндсэн хуулийн цэцээс гаргасан дүгнэлтийг Улсын Их Хурал зөвшөөрөх эсэх тухай санал хурааж шийдэж байна гэсэн жишиг тогтлоо гэж гишүүд үзкээ. Улсын Их Хурлаас Ерөнхий прокурор Н. Ганбаяр Үндсэн хуулийн зарим заалт зөрчсөн тухай Цэцийн дүгнэлтийг хууль зүйн үндэслэлгүй гэсэн (88 дугаар) тогтоол гаргасан

нь Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4 дэх заалтын дагуу гарсан Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал зөвшөөрөх эсэх тухай санал хураах байдлаар эцсийн шийдвэр гаргана гэдгээ эрх зүйн актын хэмжээнд албан ёсоор илэрхийлсэн анхны тохиолдол юм.

Үндсэн хууль зөрчсөн шийдвэрт хүрэх тулгуур нь Улсын Их Хурлын тухай хуулийн 45² дугаар зүйлийн 3 дахь заалт болсон нь дээрх хоёр баримтаас харагдаж байна.

5. Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн: «Дараахь тохиолдолд Улсын Их Хурлын гишүүнийг чөлөөлөх буюу эгүүлэн татна:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон;

2. Биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсноос чөлөөлж өгөхийг хүсэж өргөдөл гаргасан;

...5. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон тохиолдолд Улсын Их Хурал түүнийг гишүүнээс эгүүлэн татах шийдвэр гаргана» гэсэн заалтаас өөр Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах тухай заалт энэ хуульд байхгүй юм. Энэ нь Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтын үйлчилгээг зогсоож, эсхүл 64 дүгээр зүйлийн 1 дэх заалт зөрчигдөж байна. Учир нь Үндсэн хуулийн энэхүү заалтын дагуу Улсын Их Хурлын даргыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх талаар Цэцийн дүгнэлт гаргах шаардлагатай болох үед Улсын Их Хурлын тухай хуулиас баримтлах заалт олдохгүй тул Цэц Үндсэн хуулийг сахиулах, баталгаа болохынхоо хувьд Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу, Үндсэн хууль болон зарим хуулийн заалтыг төсөөтэй хэрэглэн огцруулах буюу эгүүлэн татах үндэслэл байна гэж тогтоогоод Улсын Их Хуралд оруултал энэ өргөдлийн 4-т дурдсан тохиолдолтой адил Улсын Их Хурал Цэцийн дүгнэлтийг хянан хэлэлцээд Цэц Улсын Их Хурлын тухай хууль зөрчжээ гэсэн дээр санал хураж баталгаажуулахад энэ санал хураалтаа эрх зүйн баримт болгон үйлдэх шаардлагагүй гэж үзэж болох юм.

Иймд тохиолдолд Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх заалт зөрчигдөж байгаа нь ойлгомжтой бөгөөд энэ санал хураалтын дүнг Улсын Их Хурлын бусад шийдвэрийн хүрээнд хамруулахгүй бол Үндсэн хууль зөрчигдсөн хэвээр

хоцорч Үндсэн хуулийг сахиулах баталгаанд хохирод учирна. Хэрэв хамааруулбал Үндсэн хууль зөрчигдсөнийг залруулах боломж үлдэнэ.

6. Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн: «Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах цалинтай ажил, албан тушаал хавсарч болохгүй» гэсэн заалт Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн; «Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд Улсын төсвөөс цалин авна Улсын Их Хурлын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй» гэсэн заалтыг зөрчиж байна.

Учир нь Улсын Их Хурлын тухай хуульд заасан ёсоор Улсын Их Хурлын гишүүн хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарх албан тушаалыг цалингүйгээр эрхэлж болохоор заажээ.

7. Улсын Их Хурлын тухай хуулийн 45² дугаар зүйлийн 3 дахь хэсгийн «Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөх эсэхийг чуулганы хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ.

Улсын Их Хурал Цэцийн дүгнэлтийг хянан хэлэлцээд уг дүгнэлтийг хууль зүйн үндэслэлгүй гэж үзсэн тохиолдолд энэ тухай тогтоол гаргана» гэсэн заалтыг би урьд нь уг зүйлийн нэгд заасны дагуу Улсын Их Хурлын шийдвэрийн тухай гарсан Цэцийн дүгнэлтийн тухай асуудал гэж ойлгосон нь буруу байжээ. Учир нь Улсын Их Хурал нь Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь заалтын 3, 4 дэх заалтын дагуу гарсан Цэцийн дүгнэлтийг зөвшөөрөх эсэх тухай санал хураах байдлаар эцсийн шийдвэр гаргаж болох эрх зүйн үндэслэл нь чухамхүү 45² дугаар зүйлийн 3 дахь хэсэг болох нь Улсын Их Хурлын хуралдааны дэлгэрэнгүй тэмлэглэлээс тодорхой байна. Иймхүү 45² дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн: «Цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг ... хянан шийдвэрлэнэ» гэсэн заалтуудыг зөрчиж байна.

8. Улсын Их Хурлын 1994 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 88 дугаар тогтоолын: «2. Ерөнхий прокурор Н. Ганбаяр Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 12 дахь хэсэг, 56 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн тухай Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг хууль зүйн үндэслэлгүй гэж

үзсүгэй» гэсэн хэсэг нь Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудыг тус тус зөрчиж байна.

9. Улсын Их Хурлын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн «Үндсэн хууль энэ хууль, бусад хуулиар өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурал тухайн асуудлаар санал хураалт явуулж чуулганы хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ. Энэ хууль болон бусад хуульд нууц санал хураалт явуулж шийдвэрлэхээр зааснаас бусад тохиолдолд санал хураалтыг илээр явуулна. Ил санал хураалтыг гар өргөж эсхүл цахим тооцоолууруар, нууц санал хураалтыг санал хураах хуудсаар, эсхүл цахим тооцоолуур ашиглан явуулна. Тухайн хуралдаанд оролцсон 5-аас доошгүй гишүүний шаардсанаар эсхүл хуралдаан даргалагчийн санаачилгаар ил санал хураалтыг нэрээр хураж болно. Ийнхүү нэрээр санал хураахдаа хуралдаан даргалагч цахим тооцоолуур дээр бичигдсэн эсхүл гар өргөсөн гишүүн нэг бүрийн нэр, өгсөн санал болон санал хураалтын дүнг таилцуулна» гэсэн заалт Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн: «Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн» гэсэн заалтыг зөрчиж байна.

Учир нь: цахим тооцоолууруар санал хураахыг ил санал хураалт ч мөн, нууц санал хураалт ч мөн гэж үзээд хурал даргалагчийн хувьд хэн яаж саналаа өгсөн нь мэдэгдэж байдгийг хүлээн зөвшөөрсөн байна. Ийнхүү нууц санал хураалтын утга учрыг алдагдуулсны шалтгаан нь ил саналыг нуун далдлах зорилго тавьсанд оршино. Энэ нь нэрээр санал хураах гэсэн ойлголт, түүнтэй холбогдсон заалтуудаар (Улсын Их Хурлын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 4, 6 дахь хэсэг, 55 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг) нотлогдож байна.

10. Улсын Их Хурлын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 4-ийн «. . . хэрэв нэрээр санал хураавал Улсын Их Хурлын гишүүн нэг бүрийн нэр, өгсөн санал»-ыг хуралдааны явцын тэмдэглэлийг гараар бичихдээ заавал тусгахаар заасан нь Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 17 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 1 дэх заалтуудыг зөрчиж байна. Учир нь зөвхөн нэрээр санал хураасан тохиолдолд гишүүдийн санал өгсөн

байдал гишүүн бүрээр гарч байхаар заасан, цаг хожихын тулд санал хураалт үндсэндээ компьютероор явагддаг, компьютероор явагдсан санал хураалтын дүнг хуралдааны явцын тэмдэглэлд тусгахгүй байгаа нь Улсын Их Хурлаас гарч байгаа шийдвэрт гишүүн хэрхэн санал өгч байгааг мөн чанартаа нууц болгож байна.

Ингэснээр тухайн гишүүн өргөсөн тангараггаа хэр зэрэг үнэнч байгаат сонсогчдын зүгээс бодитой хянах хамгийн чухал хөшүүргийг ажиллахгүй болгожээ. Үүгээр төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад үл хамаарх асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг Монгол Улсын иргэн баталгаатай эдэлнэ гэсэн Үндсэн хуулийн заалт зөрчигджээ.

Улсын Их Хурлын гишүүний санал өгөлтийн талаар бодитой мэдээ цацагдахгүй байгаа нь нам болон гишүүний зүгээс сонсогчдыг элдвээр төөрөгдүүлэх өргөн боломж бий болгож улмаар засгийн эрх ард түмний мэдэлд байна гэсэн Үндсэн хуулийн заалт эцсийн дүнд хоосон уриа болоход хүрнэ. Мөн Улсын Их Хурлын үйл ажиллагаа сонгогчдынхоо өмнө ил тод байх тухай ардчилсан ёсны хамгийн чухал зарчим алдагдаж байна.

11 Улсын Их Хурлын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн «Улсын Их Хурлын чуулганы хуралдаан, Улсын Их Хурлын гишүүдийн ажлын зөвлөлгөөн, байнгын хорооны хуралдааны явцыг албан ёсоор дэс дараалан тэмдэглэн авах, уг тэмдэглэлийг ашиглах, хадгалах ажлыг Ерөнхий нарийн бичгийн даргын тогтоосон журмын дагуу Улсын Их Хурлын Тамгын газар эрхлэн гүйцэтгэнэ» гэсэн заалт нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт заасан иргэдийн төр, түүний байгууллагаас хууль ёсоор хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг зөрчиж байна.

12. Улсын Их Хурлын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасан «Хуралдааны явцын гар тэмдэглэл, соронзон болон дуутай дүрс бичлэгийг зөвхөн уг ажлыг эрхлэх ажилтан, эсхүл архивчийн дэргэд үзэж сонсох бөгөөд тэдгээрийг олшруулах, хувилахыг хориглоно» гэсэн заалт Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг тус тус зөрчиж байна.

Учир нь: Улсын Их Хурал болон байнгын хороодын ху-

ралдааны явцын тэмдэглэлийг хориг саадгүй үзүүлдэг байлаа ч гэсэн уг тэмдэглэлийн талаар эргэлзээ гарч болно. Энэ тохиолдолд сонирхсон иргэн, зохих албан тушаалгүй л бол эргэлзээгээ тайлах боломжоо Улсын Их Хурлын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасан ёсоор бүрэн хаагдсан байгаа нь Монол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. Хүнийг албан тушаалаар нь ялгаварлаж болохгүй гэсэн Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт зөрчигдөж байна» гэжээ.

Иргэн Ц. Цэрэнжээ гомдолдоо: «Шинэ Үндсэн хуулиар төрийн дээд байууллагуудын эрх, үүргийг зааглан өгч, гагцхүү хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байхаар тогтоосон.

1. Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2-ын гурав дахь хэсэгт «Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх дүгнэлтийг» гагцхүү Үндсэн хуулийн цэц гаргах эрхтэй. Өөр ямар нэг байгууллага, түүний дотор Улсын Их Хуралд энэ эрх хуулиар олгогдоогүй юм.

2. Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийг энэ тогтоол зөрчлөө. Уг зүйлд: «Прокурор нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно» гэжээ. Улсын Их Хурал тогтоол гаргаж, Улсын прокурорын газраас явуулсан мөрдөн байцаах ажиллагааг хамгаалснаараа Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөөг ноцтой зөрчлөө. Иймд Улсын Их Хурлын 88 дугаар тогтоолын талаар зохих шийдвэр гаргаж өгнө үү» гэжээ.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн С. Чулуунбаатар, Г. Ганболд нараас: «Иргэн Д. Ламжав, Ц. Цэрэнжээ нарын Цэцэд хандаж гаргасан өргөдлийн дагуу болох Цэцийн хуралдаанд Улсын Их Хурлын талаас биднийг оролцуулах болсонтой холбогдуулан бид мэргэжлийн хүмүүсийн хамт дээр нэр дурдсан иргэдийн Цэцэд удаа дараалан ирүүлсэн өргөдөлд дурдсан үндэслэлүүдийг судлан үзсэн ба одоо ч үзсээр байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийг улам боловсронгуй болгох, Ерөнхийлөгчийн, Засгийн газрын болон Шүүхийн тухай хуулиудтай уялдуулах, зарим зүйлийг тод-

руулах шаардлага байгаа бөгөөд энэ талаар Монгол Улсын Их Хурал тусгай ажлын хэсэг байгуулаад ажиллаж байна.

Иймхүү Улсын Их Хурлын тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах явцад иргэн Ламжавын саналд ч Их Хурлын гишүүд анхааралтай хандана гэдэгт итгэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулинд «Улсын Их Хурлын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт, нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй» гэж заасан атал «цалинтай» гэсэн тодотгол оруулсан зэрэг эргэж харах зүйл байгааг үгүйсгэхгүй. Гэхдээ Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн нэн олон зүйл, заалт Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж байгаа дээрх иргэдийн саналтай санал нийлэхгүй байгаа бөгөөд энэ тухай үндэслэлээ бид Цэцийн хуралдаан дээр дэлгэрэнгүй тайлбарлах боломж олдоно гэдэгт итгэж байна» гэсэн тайлбар ирүүлжээ.

Иргэн Д. Ламжавын гомдлыг үндэслэн Цэцийн гишүүн Ч. Энхбаатар 1994 оны 12 дугаар сарын 15-нд маргаан шийдвэрлэх ажиллагаа үүсгэжээ. Мөн иргэн Ц. Цэрэнжээгийн гомдлыг нэгтгэн шалгав.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн зарим зүйл, заалт, Улсын Их Хурлын 1994 оны 88 дугаар тогтоол Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянан шалгах болон Цэцийн хуралдааны үед шалгах тогтоов.

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн хуралдаанд оролцож иргэн Д. Ламжав тайлбарлахдаа:

Би Цэцэд гаргасан өргөдлийн шаардлагаа дэмжиж байна. Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт Улсын Их Хурлаар эцэслэн шийдвэрлүүлэхээр заасан маргаан нь зөвхөн ажил төрлийн бус хуулийн асуудлаар ч гарсан маргаан байж болно. Ийм маргааныг Улсын Их Хурал эцэслэн шийдвэрлэвэл шүүх засаглалд хохирол учирна.

Мөн Улсын Их Хурлын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 54 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 55 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалтууд үнэхээр иргэнд Үндсэн хуулиар олгогдсон мэдээллийн эрх чөлөөг хаан боогдуулж байна.

Улсын Их Хурлын чуулган, Улсын Их Хурлын гишүүдийн ажлын зөвлөлгөөн, Байнгын хорооны хуралдааны явцын тэмдэглэлийг ашиглах, хадгалах ажлыг Ерөнхий на-

рийн бичгийн даргын тогтоосон журмын дагуу Тамгын газар эрхлэн гүйцэтгэх, тэдгээрийг зөвхөн Ерөнхий нарийн бичгийн даргын зөвшөөрлөөр үзүүлж байхаар тогтоосон энэ асуудлыг нэг албан тушаалтны гарт оруулж иргэдээс төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг баталгаагүй болгосон гэж үзнэ.

Өөрийн гомдолд дурдсан шаардлагуудтай холбогдуулан Улсын Их Хурлын ямар зүйлийн ямар заалт Үндсэн хуулийн ямар заалтыг зөрчиж байгаа бүр цаашилбал Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын шууд холбогдох ямар заалтыг зөрчиж байгаа тухай дэлгэрэнгүй хүснэгт үйлдсэнийг танилцуулах нь зүйтэй» гэв.

Итгэмжлэгдсэн төлөөлөгч Г. Ганболдоос: Гомдол гаргагч нарын гаргасан үндэслэлүүдтэй танилцлаа. Улсын Их Хурлын 20 дугаар зүйлийн 3 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй. Энэ бол ажил төрлийн маргааны тухай асуудал бөгөөд Улсын Их Хурлын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2-т чухамдаа Засгийн газарт асуулт тавьж, өмнө тавьсан асуулгын хариуг сонсоно гэж маш тодорхой заасан.

Улсын Их Хурлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 38 дугаар зүйлийн 1 дэх хэсэг нь Үндсэн хуулийг бас зөрчөөгүй. Учир нь дээрх зүйлүүдэд дурдагдсан асуудлыг шийдвэрлэхдээ Улсын Их Хурал Цэцдээ хүндэтгэл үзүүлж дүгнэлтийг нь сонссоны дараа л уг асуудлыг шийдвэрлэнэ гэсэн утгатай юм. Түүнээс биш Цэцэд тулгасан зүйл бол байхгүй.

Улсын Их Хурлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт нь боловсронгуй биш боловч энэ нь Үндсэн хуулийн холбогдох заалт нь өөрөө хоёрдмол утгатай, дотоодын зөрчилтэйгээс үүдэлтэй. Үүнийг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэхгүй байна.

Улсын Их Хурлын тухай хуулийн 45² дугаар зүйл бол урьд өмнө огт зохицуулагдаагүй процессын ажиллагааг зохицуулах зорилгоор сүүлд нэмэлт өөрчлөлтөөр орсон зүйл. Үүнийг боловсруулж батлахдаа бид үнэхээр дутуу харжээ. Гэхдээ энэ бол хийдэл мөн бөгөөд энэ тохиолдолд хуулийг төсөөтэй хэрэглэж болно гэж үзэж байна. Бид энэ зүйлийг одоо Улсын Их Хуралд оруулах, уг хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр боловсронгуй болгоно. Улсын Их Хурлын тухай

хуулийн 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт үнэхээр хуулийн хийдэл байна. Энэ бол Үндсэн хуулийн зөрчил биш.

Хуулийн хийдлийг арилгах олон зам бий. Тухайлбал тайлбар гаргах, заалтыг боловсронгуй болгох гэх мэт.

Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсэг нь Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгээс зөрж байгаа. Гэхдээ амьдрал дээр хэцүү байдаг. Тухайлбал, Улсын Их Хурлын гишүүн яагаад цалингүйгээр, өөрийн чөлөө заваар өөр ямар нэг сонгуульт ч юм уу, үүрэг хүлээж болдоггүй юм бэ? Бүрмөсөн хааж болохгүй гэж бодож байна.

Улсын Их Хурлын 1994 оны 88 дугаар тогтоол Үндсэн хуулийг зөрчөөгүй гэж үзэж байна. Ерөнхий прокурорын газраас мөрдөн байцаалт бус мөрдөн шалгах ажиллагаа явуулсан. Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалт иргэдийн зарим эрх чөлөөг боогдуулж байгаа тухай асуудлаар гарсан гомдол нь миний гарт хожуу ирсэн учраас би сайтар танилцаж амжаагүй. Манай удирдлагаас энэ асуудлаар төлөөлөл гүйцэтгэхийг албан ёсоор даалгаагүй тул миний бие энэ асуудлыг хэлэлцэхэд Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох боломжгүй байна гэсэн тайлбар өгөв.

Итгэмжлэгдсэн төлөөлөгч С. Чулуунбаатараас:

Улсын Их Хурлын тухай хуулийн холбогдох зүйл, заалтууд Үндсэн хуулийн зүйл, заалтыг зөрчөөгүй гэдэг дээр санал нэг байна. Тухайлбал, Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт бид их учиртай хандах ёстой. Улсын Бага Хурлаас энэ хуулийг батлах үед энэ талаар их яриа гарсан. Улсын Их Хурлын гишүүдэд, үүрэгт нь л хамааraагүй бол ямар ч ажил эрхлэхийг хориглох юм бол хүний эрх ч хөндөгдөх болзошгүй. Тухайлбал, яагаад Улсын Их Хурлын гишүүн багшилж болдоггүй юм бэ? Яагаад нэг сайн дурын байгууллагад сонирхлоороо нэгдэж, гүүнд сонгуульт үүрэг хүлээж болдоггүй юм бэ?

Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалт иргэдийн эрх, эрх чөлөөг боогдуулсан гэдэгтэй санал нийлэхгүй байна. Ер нь төрийн аль ч байгууллагын үйл ажиллагаанд илүү байх зарчмыг хангах нь зүйн асуудал. Гэхдээ байгууллага дотоод дэг журамтай байх ёстой. Тэгж байж л тухайн байгууллагын хэвийн ажиллагаа хангагдах учиртай.

Дотоод дэг журмын асуудал бол манайд Ерөнхий на-

рийн бичгийн даргын харицуцлагын асуудал. Ийм ч учраас тэмдэглэлийг хадгалах, ашиглах зэрэг зарим журмыг ерөнхий нарийн бичгийн дарга тогтоож байгаа нь буруу биш. Харин үйл ажиллагаандаа хүнд суртал гаргаж, иргэдийг чирэгдүүлсэн, материал үзүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзсан бол өөр хэрэг гэсэн тайлбар өгөв.

ХЯНАВАЛ:

1. Үндсэн хуулийн Цэц Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Үндсэн хуулийн биелэлт дээр хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болохын хувьд Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн тухай асуудлаар гарсан Цэцийн дүгнэлт эцсийн байх бөгөөд түүнийг Улсын Их Хурал хэлэлцэх тухай Үндсэн хуульд ч, Улсын Их Хурлын тухай хуульд ч заагаагүй байна.

Харин эдгээр албан тушаалтны талаар гарсан Цэцийн дүгнэлт Улсын Их Хуралд хянагдахгүй, гагцхүү шийдвэр гаргах үндэслэл болно гэсэн ангуулга эдгээр хуулийн зохих заалтуудаар нотлогдож байна. Тухайлбал Үндсэн хуулийн 66 дугаар зүйлд, зөвхөн энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасны дагуу оруулсан дүгнэлтийг Улсын Их Хурал хэлэлцэх тухай заасан нь ангуулгаараа Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасны дагуу гарсан цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хэлэлцэхгүй гэсэн санааг илэрхийлсэн байгаа юм.

Мөн хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт «Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж, Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаар хэлэлцэж, чуулганд оролцсон нийт гишүүний дийлэнх олонхийн саналаар огцруулна» гэжээ.

Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт «... хэрэв Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан үндэслэл байна гэж үзвэл Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг заавал сонсоно..» гэж заасан байна. Мөн түүнчлэн Улсын Их Хурлын шийдвэрийн талаар гарсан Цэцийн дүгнэлтийг хянан хэлэлцэх журмыг

зохицуулсан Улсын Их Хурлын тухай хуулийн 45² дугаар зүйлд энэ тухай заалт байхгүй байна. Тодорхой албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн тухай Цэцийн дүгнэлтийг хэлэлцэх хууль зүйн үндэслэлгүй байхад Улсын Их Хурлын тухай хуулийн 45² дугаар зүйлийг төсөөтэйгээр хэрэглэн Улсын Их Хурлын гишүүн С. Зориг, Улсын ерөнхий прокурор Н. Ганбаяр нарын талаар гарсан Цэцийн дүгнэлтийг хэлэлцэж санал хураах замаар шийдвэрлэж байгаа нь Үндсэн хууль, Улсын Их Хурлын хуулиар олгоогүй эрх хэмжээг Улсын Их Хурал хэрэгжүүлэхэд хүргэж байна. Иймд Улсын Их Хурлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Улсын Их Хурлын 1994 оны 88 дугаар тогтоолын 2 дахь заалт Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх үндэстэй байна.

2. Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг хянан хэлэлцэх тухай Улсын Их Хурлын тухай хуулийн 45² дугаар зүйл нь Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасан Улсын Их Хурлаас хэлэлцэх Цэцийн дүгнэлтээс зөвхөн Улсын Их Хурлын шийдвэрийн талаар гаргасан Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг хэлэлцэхээр сугалан авч, зарлиг, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ, ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар Цэцээс гаргах дүгнэлтийг хэлэлцэхийг орхигдуулан Үндсэн хуулийн заалтыг хэт явцуурууллсан нь Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх үндэстэй байна.

3. Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн, Улсын Их Хурлын гишүүний тавьсан асуулт, асуулгын талаар гарсан маргааныг Улсын Их Хурал эцэслэн шийдвэрлэх тухай заалт нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх агуулгыг илэрхийлж байгаа бөгөөд асуулт, асуулгын талаар гарч болох аливаа маргаан нь эрх зүйн шинжтэй болсон тохиолдолд Улсын Их Хурлын гишүүн, маргагч гал аль аль нь шүүх, Үндсэн хуулийн Цэцэд хандаж хөндөгдсөн эрхээ хамгаалуулах боломжоо алдахад хүргэж болох учир дээрх заалт Үндсэн хуулийн 52 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 50 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн тухай иргэн Д. Ламжавын гомдлыг хангах үндэслэлтэй байна.

4. Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн

4 дэх хэсгийн заалтын дагуу Улсын Их Хурлын гишүүн хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаалыг цалингүйгээр эрхлэх боломж нээгдэж байгаа нь Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн «. . . Улсын Их Хурлын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй» гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэстэй.

5. Улсын Их Хурлын чуулганы хуралдаан, гишүүдийн ажлын зөвлөлгөөн, байнгын хороодын хуралдааны явцын тэмдэглэлийг хөтлөх, ашиглах, хадгалах журмыг Улсын Их Хурлын тухай хуулийн зохих заалтын дагуу Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжаар батлагдсан зааврaар зохицуулж байгаа нь аль ч байгууллагын дотоод үйл ажиллагааны нийтлэг журам юм.

Улсын Их Хурлын хуралдааны явцын тэмдэглэлтэй иргэд, албан лушаалтнаас танилцахад зарим саад бэрхшээл учирч байгаа бодит байдал нь энэ үйл ажиллагааны зохион байгуулалт, зарим ажилтны үйл ажиллагаатай холбоотой байгаа учир улсын нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах иргэний эрх зөрчигдсөн гэх түүнчлэн мөн санал хураалтын журам ч Үндсэн хуулийн зохих заалтыг зөрчсөн гэх үндэслэлгүй байна.

6. Улсын Их Хурлын хуралдаанд Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг сонсох нь танин мэдэх агуулгатай зүй ёсны асуудал болохын сацуу Улсын Их Хурлын гишүүнийг гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон нөхцөлд эгүүлэн татах тухай Монгол Улсын Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлд заасан байх тул иргэн Д. Ламжавын өргөдөлд бүй «Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 2, 38 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудыг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчиж байна» гэсэн шаардлагыг хангах үндэслэлгүй байна.

Үндсэн хуулийн Цэц Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 19 дүгээр зүйлийг баримтлан дор дурдсан дүгнэлт гаргав. Үүнд:

Нэг. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн «. . . Улсын Их Хурлын гишүүний тавьсан асуулт, асуулгын талаар гарсан маргааныг улсын Их Хурал эцэслэн шийдвэрлэнэ» гэсэн заалт нь Үндсэн хуу-

лийн 52 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн «Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаас хянан хэлэлцэж шийдвэрлэнэ», Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн «Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ» Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн «Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн» гэсэн заалтуудыг;

Хоёр. Мөн хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн .. Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд Үндсэн хууль, энэ хууль бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах цалинтай ажил, албан тушаал хавсарч болохгүй» гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн «... Улсын Их Хурлын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах, бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй» гэсэн заалтыг;

Гурав. Улсын Их Хурлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн «... Улсын Их Хурал Ерөнхийлөгчийг огцруулах асуудлыг хэлэлцэхдээ дараахь шалтгаан, нөхцөлийг заавал тогтоосон байна:

1. Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан үндэслэлээр Үндсэн хуулийн Цэцийн гаргасан дүгнэлт үнэн зөв эсэх.

2. Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж, Үндсэн хууль зөрчсөн үндэслэл, шалтгааныг зөв тогтоосон эсэх.

3. Ерөнхийлөгч бүрэн эрхээ зөрчсөн хүрээ, нөхцөл байдлыг зөв тогтоосон эсэх ...» гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн «Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаар хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүдийн дийлэнх олонхийн саналаар огцруулна» гэсэн заалтыг;

Дөрөв. Улсын Их Хурлын тухай хуулийн 45[2] дугаар зүйлийн 1 дэх хэсгийн «Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын шийдвэрийн талаар гаргасан Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн Цэцийн дарга, эсхүл түүний итгэм-

жилснээр Үндсэн хуулийн Цэц аль нэг гишүүн Улсын Их Хуралд танилцуулна».

2 дахь хэсгийн «Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг танилцуулсны дараа тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хариуцаж байсан зохих байгнын хороо, Хууль зүйн байнгын хороо дүгнэлт гаргана. Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийн талаар Улсын Их Хурлын гишүүд асуулт тавж хариулт авч, санал дүгнэлт гаргаж болно.»

3 дахь хэсгийн «Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөх эсэхийг чуулганы хуралдаанд оролцсон нийт Хурал хүлээн зөвшөөрөх эсэхийг чуулганы хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ. Улсын Их Хурал Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг хянан хэлэлцээд уг дүнэлтийг хууль зүйн үндэслэлгүй гэж үзсэн тохиолдолд энэ тухай тогтоол гаргана.»

4 дэх хэсгийн «Улсын Их Хурал Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг хянан хэлэлцээд уг дүгнэлт хууль зүйн үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг бүхэлд нь буюу түүний зарим хэсгийг хүчингүй болгож, эсхүл тэдгээрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулна» гэсэн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн «Үндсэн хуулийн Цэц энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр дараахь маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна».

1. Хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх.

2. Ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүнийг ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх» гэсэн заалтыг.

Тав. Улсын Их Хурлын 1994 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 88 дугаар тогтоолын «Монгол Улсын ерөнхий прокурор Н. Ганбаяр Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 12 дахь заалт, 56 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн тухай Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг хууль зүйн үндэслэлгүй гэж үзсүгэй» гэсэн 2 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн «Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай

дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн», мөн хуулийн 66 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн «Үндсэн хуулийн Цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ» гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Зургаа. Улсын Их Хурлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 2, 38 дугаар зүйлийн 1, мөн хуулийн 51, 54, 55 дугаар зүйлүүдийн 1 дэх хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчиж байна гэсэн иргэн Д. Ламжавын өргөдөлд дурдсан гомдлыг хэрэгсэхгүй болгосугай.

Дарга **Г. НЯМДОО**

Гишүүд **Л. БААСАН**

Ц. ЦОЛМОН

С. ЖАНЦАН

Ч. ЭНХБААТАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 12 дугаар сарын 8-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 201

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. «Байгууллага хоорондын гэрээ байгуулах журам»-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Сайд, тусгай газрын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгах нь:

а) одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа байгууллага хоорондын бүх гэрээг энэ журамд нийцүүлэн холбогдох байгууллагад хянуулж бүртгүүлэх арга хэмжээг 1995 оны нэгдүгээр улиралд багтаан авах;

б) энэ журмыг яам, Засгийн газрын үндсэн болон дэд бүтцэд ордог газар, аймаг, нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, тэдгээрийн харьяа төсөвт байгууллага, төрийн түйцэтгэх тусгай чиг үүрэг бүхий Засгийн газрын бус байгууллагуудын үйл ажиллагаанд мөрдүүлж, гүйцэтгэлд нь хяналт тавьж байх.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Гадаад харилцааны сайд **Ц. ГОМБОСҮРЭН**

Засгийн газрын 1994 оны 201 дүгээр тогтоолын хавсралт

БАЙГУУЛЛАГА ХООРОНДЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЖУРАМ

1. Энэхүү журмыг дараахь байгууллагууд өөрийн үйл ажиллагааны дүрэмд тодорхойлсон бүрэн эрхэд хамаарах асуудлаар бусад улсын ижил төрлийн байгууллага, хуулийн этгээд, хувь хүнтэй байгууллага хоорондын гэрээ (хэлэл

цээр, протокол, тохиролцоо гэх мэт ямар ч нэртэй байж болно) байгуулахад баримтална:

а) Монгол Улсын яам, Засгийн газрын үндсэн болон дэд бүтцэд ордог газар болон нутгийн захиргааны байгууллага (цаашид «төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага» гэнэ);

б) тэдгээрийн харьяа төсөвт байгууллага;

в) төрийн гүйцэтгэх тусгай чиг үүргийг эрхлэн хэрэгжүүлж, тэр тухайдаа улсын төсвөөс санхүүжиж байгаа Засгийн газрын бус байгууллагууд тэрхүү үүргийнхээ хүрээнд.

2. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын харьяа төрийн өмчийн аж ахуйн нэгжээс гадаад улсын аж ахуйн нэгж, хуулийн этгээд, хувь хүнтэй байгууллага хоорондын гэрээ, арилжааны хэлцэл байгуулах болон тэдгээрийг зохих хууль тогтоомжийн дагуу уг асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар хянуулахад энэ журам хамаарахгүй.

3. Энэ журмын 1-д дурдсан байгууллага нь өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар гадаад улсын ижил төрлийн байгууллага, хуулийн этгээд, хувь хүнтэй байгууллага хоорондын гэрээ байгуулахдаа Монгол Улсын хууль, тогтоомжийн бусад акт, тухайн улстай байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээний заалтыг удирдлага болгоно.

4. Энэ журмын 1-д дурдсан байгууллагууд дор дурдсан чиглэлийн гэрээ байгуулахад Монгол Улсын Засгийн газраас зөвшөөрөл авна:

а) бусад байгууллагын эрх ашгийг хөндсөн буюу хамтарч үүрэг хүлээх гэрээ;

б) эрх бүхий дээд шатны байгууллагаас тогтоон батлсан төсвөөс гадуур нэмэлт хөрөнгө шаардах заалт бүхий гэрээ;

в) Монгол Улсын хууль, хууль тогтоомжийн бусад актад зааснаас өөр журам тогтоож буй гэрээ.

5. Энэ журмын 1-ийн «а»-д дурдсан байгууллагууд 4-т зааснаас бусад асуудлаар гадаад улсын ижил төрлийн байгууллага, хуулийн этгээд, хувь хүнтэй байгууллага хоорондын гэрээг өөрсдөө шийдвэрлэн байгуулах бөгөөд уг гэрээг бүртгүүлж хянуулахаар гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад түүнийг байгуулснаас хойш нэг сарын дотор ирүүлнэ.

6. Энэ журмын 1-ийн «б», «в»-д дурдсан байгууллагууд

4-т заасnаас бусад асуудлаар гадаад улсын ижил төрлийн байгууллага, хуулийн этгээд, хувь хүнтэй байгууллага хоорондын гэрээ байгуулахдаа гэрээний төслийг тухайн асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны байгууллагын аль нэгэнд харьяаллынхаа дагуу урьдчилан хянуулан бүртгүүлж бичгээр зөвшөөрөл авна.

7. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 5-д заасны дагуу ирүүлсэн гэрээг Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хууль болон Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд нийцэж буй эсэхийг хянан үзнэ. Хэрэв гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага уг гэрээг хянан үзсэний эцэст дээрх шаардлагад бүрэн нийцэж буй гэж үзсэн тохиолдолд түүнийг гэрээ, хэлэлцээрийн бүртгэлд авч 14 хоногийн дотор холбогдох байгууллагад бичгээр хариу мэдэгдэнэ.

8. Хэрэв гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага уг гэрээг бүхэлд нь, эсвэл түүний хэсгийг эс мөрдөх тухай дүгнэлт гаргасан бол холбогдох байгууллагад энэ тухай 14 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

9. Энэ журмын 8-д заасны дагуу гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэрээг бүхэлд нь, эсвэл түүний зарим хэсгийг эс мөрдөх тухай дүгнэлт гаргасан бол тухайн гэрээг бүхэлд нь, эсвэл түүний тухайн холбогдох хэсгийг тухайн гэрээг байгуулсан байгууллага өөрөө, эсвэл Засгийн газар хүчингүй болгоно.

10. Энэ журмын 1-ийн «а»-д дурдсан байгууллагууд гадаад улсын ижил төрлийн байгууллага, хуулийн этгээд, хувь хүнтэй байгууллага хоорондын гэрээ байгуулахын өмнө тухайн гэрээний төслийн талаар гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал, дүгнэлтийг авч болно. Энэ тохиолдолд гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дор дурдсан материалыг ирүүлнэ:

а) нөгөө талтай хэлэлцэн тохирсон гэрээний төсөл;

б) гэрээ байгуулах шаардлага, ач холбогдол, санхүү, эдийн засгийн тооцоог тусгасан танилцуулга.

11. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захир-

гааны төв байгууллага санал дүгнэлтээ 7 хоногт багтаан бичгээр өгнө.

Иймхүү урьдчилан дүгнэлт гаргуулсан хэдий ч тухайн байгууллага энэ журмын 7-д заасны дагуу гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад үг гэрээг бүртгүүлнэ.

12. Энэ журмын 1-ийн «а»-д дурдсан байгууллагуудын албан тушаалтан байгууллага хоорондын гэрээ байгуулах тохиолдолд асуудлыг тухайн байгууллагын удирдлагын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцүүлж, сайд, дарга нар тушаал, аймаг, нийслэлийн Засаг дарга нар захирамж тус тус гаргаж хэрэгжүүлнэ.

13. Энэ журмын 1-ийн «б», «в»-д дурдсан байгууллагын албан тушаалтанд байгууллага хоорондын гэрээ байгуулах эрхийг энэ журмын 6-д заасны дагуу үг гэрээний төслийг урьдчилан хянасан төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын удирдлагын шийдвэр (сайд, тусгай газрын даргын тушаал, Засаг даргын захирамжаар)-ээр тус тус олгоно.

14. Энэ журмын 9-д заасан асуудлаар үүссэн аливаа маргааныг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

15. Энэ журмын заалтыг зөрчин эрх мэдэл буюу бүрэн эрхээ хэтрүүлж байгууллага хоорондын гэрээ байгуулсан албан тушаалтан Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 12 дугаар Улаанбаатар

Дугаар 204

сарын 14-ний өдөр хот

ХУУЛЬ, ЗАРЛИГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

«Архидан согтуурахтай тэмцэх тухай» Монгол Улсын

хууль, «Архидан согтуурахтай хийх тэмцлийг хүчтэй болгох тухай» Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1994 оны 151 дүгээр зарлигийн хэрэгжилтийг ханган зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Архидан согтуурахтай тэмцэх талаар гарсан хууль, зарлиг, тогтоол шийдвэрүүдийн биелэлтийг нийгмийн дэг журам ханган ажлыг зохицуулан зохион байгуулах салбар зөвлөлтэй хамтран төр, олон нийтийн болон бусад бүх байгууллага, аж ахуйн нэгжид өмчийн төрөл, хэлбэрийг харгалзахгүйгээр шалган дүгнэлт хийж, архидан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлэн дүнг хагас жил тутамд Засгийн газарт илтгэж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1994 оны 151 дүгээр зарлигаар Засгийн газарт өгсөн чиглэлийн дагуу холбогдох хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулж, 1995 оны 1 дүгээр улиралд багтаан Засгийн газарт оруулахыг Хууль зүйн сайд, Худалдаа, үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд, Хүнс, хөдөө аж ахуйн сайд, Цагдаагийн ерөнхий газрын дарга нарт даалгасугай.

3. Согтууруулах ундаагаар үйлчлэх байгууллагууд (зочид буудал, зоогийн газар, шөнийн цэнгээний газар)-ын үйлчилгээний зэрэглэл, тэдгээрт согтууруулах ундаагаар үйлчлэх журмыг 1995 оны 1 дүгээр сард багтаан шинэчлэн боловсруулж батлуулахыг Худалдаа, үйлдвэрийн яаманд, энэхүү журмыг үндэслэн зөвшөөрөл олгож үйлчилгээний чанарт байнга хяналт тавих, үйлчилгээний зэрэглэлийг өсгөх буюу бууруулах арга хэмжээ авч байхыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. «Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль» болон согтууруулах ундаа импортлох, худалдах, түүгээр үйлчлэх, хяналт тавих талаар Засгийн газраас баталсан журмыг зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллагын дээрх үйл ажиллагааны зөвшөөрлийг хүчингүй болгож байхыг Худалдаа, үйлдвэрийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, аймаг, нийслэлийн Засаг даргад үүрэг болгосугай.

5. Хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг идэвхтэй өнгөрүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээнүүд авч хэрэгжүүлэхийг Шинжлэх ухаан, боловсролын яам, Соёлын яам, Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам болон бүх шатны Засаг даргад даалгасугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан «Архидан согтуурахтай тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай» Засгийн газрын 1994 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн 76 дугаар тогтоолын 1, 2 дугаар хавсралтуудад дараахь өөрчлөлт оруулж 1995 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдүүлсүгэй:

а) 1 дүгээр хавсралтын 3-ын 4 дүгээр заалт:

«3. 4. Бүтээгдэхүүний чанар, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь хэрэглэгчдийн эрх ашгийг хохироож байгаа нь тогтоогдвол холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн Хүнс, хөдөө аж ахуйн яам хууль тогтоомжийн дагуу зохих арга хэмжээ авна.»

б) 2 дугаар хавсралтын 2-ын 6 дугаар заалт:

«2. 6. Зөвшөөрлийн хуудсанд заагдсанаас өөр нэр төрлийн болон шинжилгээгүй, илүү хэмжээний согтууруулах ундааг импортоор оруулж ирэхийг хориглоно. Хүнсний спиртийг согтууруулах ундаа үйлдвэрлэх зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж зөвхөн үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашиглах бөгөөд спирт импортлоход Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас тодорхойлолт гаргуулсан байна.»

в) 2 дугаар хавсралтын 3-ын 6 дугаар заалт:

«3. 6. Жижиглэн худалдаалах цэгүүдэд хүнсний спирт худалдах, бүх төрлийн архи, дарс, пиво (шар айраг)-ыг дахин савлах буюу хундагалаж, аягалаж борлуулахыг хориглоно.»

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Монгол Улсын шадар сайд **Л. ЭНЭБИШ**

Хууль зүйн сайд **Н. ЛУВСАНЖАВ**

Худалдаа, үйлдвэрийн сайд **Ц. ЦОГТ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 12 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 205

ТЭТГЭВЭР АВАГЧДЫН НЭМЭГДЭЛ НӨХВӨРИЙН ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн 1995 оны Үндсэн чиглэлд заасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор 1995 оноос өмнө насны, тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгосон иргэдэд тэтгэвэр, Засгийн газрын тогтоолоор хэмжээг нь тогтоон олгож байгаа нөхвөр дээр нь тэдгээрийн нийлбэр дүнгийн 30 хувьтай тэнцэх хэмжээний нөхвөрийг 1995 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн нэмж олгохоор тогтоосугай.

2. Ахуйн хэрэглээний цахилгаан, дулаан, төвлөрсөн шугам сүлжээгээр түгээж байгаа ус, түүнчлэн ариутгах татуургын үйлчилгээний тариф зарим газарт нэмэгдэж байгаатай холбогдуулан энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан нэмэгдэл нөхвөр олгох арга хэмжээг энэ оны 12 дугаар сараас эхлэн хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд **Э. ГОМБОЖАВ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 12 дугаар сарын 21-ний өдөр | Дугаар 213 | Улаанбаатар хот

ТОГТООЛЫН ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

«Хүн амын нийгмийн баталгааг хангах ээлжит арга хэмжээний тухай» Засгийн газрын 1993 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 184 дүгээр тогтоолын 9 дүгээр зүйл, 6 дугаар зүйлийн, «өрхдөө бодод шилжүүлснээр 20-иос доош толгой малтай буюу өрхийн жилийн орлого нь 180,0 мянгаас доош төгрөг байгаа» гэснийг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд **Э. ГОМБОЖАВ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 12 дугаар сарын 21-ний өдөр | Дугаар 217 | Улаанбаатар хот

МАЛ ЭМНЭЛЭГ, УРЖЛИЙН АЛБАНААС ҮЗҮҮЛЭХ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭГ ТӨЛБӨРТЭЙ ЯВУУЛАХ ЖУРАМ, ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭГ БАТЛАХ ТУХАЙ

«Монгол Улсын Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль»-ийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. «Мал эмнэлэг, үржлийн албанаас үзүүлэх ажил, үйлчилгээг төлбөртэй явуулах журам»-ыг 1 дүгээр хавсралтын, ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталж 1995 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдүүлсүгэй.

2. Мөнгөний ханш болон эм урвалж, био бэлдмэл, эрчим хүч, шатахууны үнийн өөрчлөлттэй уялдуулан мал эмнэлэг, үржлийн албанаас үзүүлэх ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээг 30 хүртэл хувиар хямдруулах буюу өсгөн тогтоож байх эрхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц. Өөлдөд олгосугай.

3. Мал эмнэлэг, үржлийн албанаас үзүүлэх ажил, үйлчилгээний төлбөрийн орлогоос дээрх албадуудыг бэхжүүлэх, ажил, үйлчилгээний чанарыг сайжруулахад болон ажиллагчдын нийгмийн арга хэмжээнд зориулан зарцуулах талаар зохих журам гаргаж мөрдүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн яам (Ц. ӨӨЛД), Сангийн яам (Д. ДАВААСАМБУУ)-д даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Хүнс, хөдөө аж ахуйн сайд **Ц. ӨӨЛД**

Засгийн газрын 1994 оны 217 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

МАЛ ЭМНЭЛЭГ, ҮРЖЛИЙН АЛБАНААС ҮЗҮҮЛЭХ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭГ ТӨЛБӨРТЭЙ ЯВУУЛАХ ЖУРАМ

Нэг, **Нийтлэг үндэслэл**

1. Энэхүү журмын зорилго нь «Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль»-ийн дагуу улсын мал эмнэлэг, үржлийн алба (цаашид «мэргэжлийн алба» гэх)-наас үзүүлэх ажил, үйлчилгээг төлбөртэй явуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2. Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчинтэй тэм-

цэх, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх, төрийн өмчид байх цөм сүргийн малыг өсгөн үржүүлэх, үржлийн ажлыг явуулахаас бусад ажил, үйлчилгээний төлбөрийг мал, амьтан бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага (цаашид «үйлчлүүлэгч» гэх) хариуцна.

3. Мэргэжлийн албань тухайн нутаг дэвсгэрийн үйлчлүүлэгчидтэй ажил, үйлчилгээний нэр төрөл, чанарын талаар хугацаатай гэрээг жил бүр байгуулан ажиллаж болно.

4. Мэргэжлийн албанаас ажил, үйлчилгээг төлбөртэй явуулахад өмчийн хэлбэр харгалзахгүй.

Хоёр. **Мэргэжлийн алба ба үйлчлүүлэгчийн үүрэг**

5. Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээ явуулж байгаа мэргэжлийн алба дор дурдсан үүрэг хүлээнэ:

а) батлагдсан стандарт, заавар, арга зүйн дагуу ажил, үйлчилгээг чанартай явуулах;

б) зохих шаардлага хангаж зөвшөөрөгдсөн багаж, төхөөрөмж, үр ,эм, тарилга, биа бэлдмэл, химийн бодис, урвалжийг ажил, үйлчилгээнд ашиглах;

в) мал, амьтныг чиглэлтэйгээр үржүүлэх, эрүүлжүүлэхийн ач холбогдол, халдварт, гоц халдварт, паразиттах өвчний хор хөнөөл, ажил, үйлчилгээний онцлогийн талаар нийтэд мэдээлэх;

г) ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн дүн, орлогын тайланг дээд шатны байгууллагад тогтоосон хугацаанд мэдээлж байх.

6. Үйлчлүүлэгч дор дурдсан үүрэг хүлээнэ:

а) мал, амьтны гаралтай түүхий эд, мах, сүү, малын гэжээл бэлтгэх, боловсруулах, зах зээлд нийлүүлэх, тээвэрлэх, хүлээн авах, улсын хилээр нэвтрүүлэхэд мал эмнэлэгзриун цэврийн зохих шаардлага, нөхцөлийг хангах;

б) цөм, торгон сүргийн мал болон гойд ашиг шимт малд ангилалт хийлгэн тэмдэг, дугаар тавих, үржлийн малын удмын талаархи болон үржил, ашиг шимийн бүртгэлийг зохих журмын дагуу хөтлөх;

в) мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээний төлбөрийг тогтоогдсон хэмжээний дагуу төлөх;

г) мал эмнэлэг, үржлийн төлбөрт ажил, үйлчилгээний явцад мэргэжлийн алба, мэргэжилтний буруугаас мал, амьтан өвчлөх, хохирол гарсан үед хохирлыг нөхөн төлүүлэх.

Гурав. Ажил, үйлчилгээний төлбөр тооцох, тайлагнах, хяналт тавих

7. Мэргэжлийн алба, тэдгээрт ажилладаг эмч, мэргэжилтэн нар ажил, үйлчилгээний төлбөрийг тооцохдоо «Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээний төлбөрийн хуудас»-ыг 2 хувь бичиж нэг хувийг үйлчлүүлэгчид өгч, нөгөөгөөр тооцоо хийнэ. Төлбөрийн хуудас нь санхүүгийн тэмдэг, индексийн дугаартай, батлагдсан нэг загвартай байна.

8. Мал эмнэлэг, үржлийн албанаас үзүүлэх ажил, үйлчилгээний төлбөрийн орлогыг мэргэжлийн албаны их, бага эмч, мал зүйч нар сар тутам орон нутгийн төсвийн орлогод оруулах бөгөөд тухайн нутаг дэвсгэрийн нэгжийн нягтлан бодогч хяналт тавина.

9. Үйлчлүүлэгчээс ажил, үйлчилгээний төлбөрийн орлогыг дараахь хэлбэрээр авч болно. Үүнд:

а) үйлчлүүлэгчидтэй байгуулсан гэрээний үндсэн дээр тэдгээрээс улирлын эхэнд урьдчилгаа гаргуулж, эцсийн тооцоог улирлын сүүлчээр ажил, үйлчилгээний чанар, үр дүнтэй холбон хийх;

б) ажил, үйлчилгээ явуулсан тухай бүрт бэлэн мөнгөөр;

в) үйлчлүүлэгчид нь ажил, үйлчилгээний төлбөрийг мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд болон бусад бүтээгдэхүүнээр харилцан тохиролцсоны үндсэн дээр хийж болно.

10. Ажил, үйлчилгээний төлбөрийг мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээний төлбөрийн хуудас хэрэглэлгүйгээр авахыг хатуу хориглоно.

11. Мэргэжлийн албанаас үзүүлэх ажил, үйлчилгээний орлого, зарлагыг жил, улирлаар төлөвлөн орлогын зохих хувийг албаны материаллаг баазыг бэхжүүлэх, ажиллагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, үйлчилгээний чанарыг сайжруулахад холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудаас гаргасан шийдвэр, журмын дагуу зарцуулж болно.

12. «Мал эмнэлэг, үржлийн албанаас үзүүлэх ажил, үйлчилгээг төлбөртэй явуулах журам»-ыг хэрэгжүүлэх ажлыг аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар, мал аж ахуйн үржлийн алба хариуцан биелэлтийн байдалд хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар хяналт тавина.

Дөрөв. Хариуцлага

13. Энэхүү журмыг зөрчсөн иргэн, албан · тушаалтны үйлдэл, эс үйлдэлд түүний гэм буруу, зөрчлийн шинж байдал, учруулсан хохирлын хэмжээг харгалзан Монгол Улсын Эрүүгийн хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, «Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль»-ийн холбогдох заалтын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Засгийн газрын 1994 оны 217 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

МАЛ ЭМНЭЛЭГ, УРЖЛИЙН АЛБАНААС ҮЗҮҮЛЭХ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

Нэг. Мал эмнэлгийн эмчлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ

№	Үйлчилгээний төрөл	Хэмжих нэгж	Төлбөрийн хэмжээ (төгрөгөөр)
1		2	3
1.	Мэс заслын ажилбарууд:		
—	эргүү эмчлэх — бод	толгой тутам	250,0
	— бог	—„—	125,0
—	бөөм авах — бодын төл	—„—	100,0
	— богийн төл	—"—	60,0
—	саванд хагалгаа — бод	—„—	950,0
	хийх — бог	—„—	550,0
	— жижиг амьтан	—„—	330,0
—	үхсэн төл эвдэж — бод	—„—	500,0
	авах — бог	—„—	350,0
—	сав тайрах — бод	—„—	250,0
	— бог	—„—	175,0
		—"—	60,0
		—"—	40,0
—	төрөл бүрийн оёдол тавих	хэсэг газар	30,0

1		2	3
— эвэрхийг эмчлэх	— бод	—„—	300,0
	— бог	—„—	150,0
— ходоод, гүзээнээс гаднын биет авах		—„—	2000,0
— улаан хоолойноос гаднын биет авах	— бод	—„—	350,0
	— бог	—„—	180,0
— эвэр, туурай засах			
	— бод	толгой тутам	100,0
	— бог	—"—	35,0
— нохойн чихний засал хийх		—„—	500,0
— нохойн сүүлэнд засал хийх		—„—	250,0
— адууны туурай тахлах		—„—	540,0
2. Мал, амьтны төрөлтийн хүндрэлд тусламж үзүүлэх		толгой тутам	тохиролцоно
3. Саатсан хаг гараар салгах		—"—	тохиролцоно
4. Мал, амьтан хөнгөлөх		—"—	тохиролцоно
5. Эргэсэн шулуун гэдэс, сав оруулах	— бод	толгой тутам	150,0
	— бог	—„—	100,0
6. Төрөл бүрийн эмийн бодис олгох. Үүнд:			
— булчин, арьсан дор тариа хийх	— бод	толгой тутам	5,0
	— бог	—"—	3,0
— арьсан дотор тариа хийх	— бод	—"—	10,0
	— бог	—"—	5,0
— судас, цагаан мөгөөрсөн хоолойгоор тариа хийх			
	— бод	—"—	50,0
	— бог	—"—	25,0
— дуслын тариа хийх			
	— бод	—„—	100,0
	— бог	—"—	50,0
— цээж, хэвлийн хөндийд тариа хийх, хатах			

1	2	3
— бод	—"—	80,0
— бог	—"—	40,0
— буглаа, шарх эмчлэх (курс эмчилгээ)		
— бод	—"—	350
— бог	—"—	210
— төрөл бүрийн цацлага, тосон түрхмэл, угаалга, цэвэрлэгээ хийх — бод	—"—	80,0
— бог	—"—	40,0
— агаар дуслын эмчилгээ хийх — бод	—"—	10,0
— бог	—"—	6,0
— шувуу	—"—	4,0
— гахай	—"—	3,0
7. Паразиттах өвчний эсрэг арга хэмжээ авах. Үүнд:		
— туулгалт — бод	толгой тутам	30,0
— бог	—"—	15,0
— нохой	—"—	50,0
— боловсруулалт — бод	—"—	10,0
— бог	—"—	6,0
— угаалга (ванн) — бод	—"—	30,0
— бог	—"—	12,0
— угаалга (гараар) — бод	—"—	40,0
— бог	—"—	20,0
— дэлэнгийн курс эмчилгээ	—„—	350,0
— бүх төрлийн мэдээ алдуулах эмчилгээ		
— бод	—"—	50,0
— бог	—"—	35,0
8. Хаймсуур, бургуй тавих, ходоод, сав, ам, хамрын хөндий угаах — бод	толгой тутам	100,0
— бог	—"—	80,0
9. Ардын уламжлалт эмчилгээ (хатгах, ханах, төөнөх, утах, барих зэрэг) хийх	—"—	тохиролцоно

1	2	3
10. Мал эмнэлгийн шүүх мэгадлалын шинжилгээ:		
— эмгэг анатомын задаргаагаар оношт тодруулах		
— бод	толгой тутамд	1400,0
— бог	—„—	780,0
— махаар нь мал, амьтныг тодорхойлох	—„—	500,0
— ясаар нь мал, амьтныг тодорхойлох	—„—	410,0
— эх, төлийг тодорхойлох:		
— энгийн аргаар	—„—	320,0
— лабораторийн аргаар	—„—	720,0
11. Лабораторийн аргаар тодруулах:		
— цусанд иж бүрэн шинжилгээ хийх	нэгж дээж	320,0
— шээсэнд иж бүрэн шинжилгээ хийх	—„—	270,0
— ялгадас, бусад зүйлд иж бүрэн шинжилгээ хийх	—„—	180,0

Хоёр. **Мал эмнэлэг, ариун цэврийн үзлэг шинжилгээ**

№	Үйлчилгээний төрөл, тодорхойлох үзүүлэлт	Хэмжих нэгж	Төлбөрийн хэмжээ (төгрөгөөр)	
			үзлэгийн	шинжилгээний
1		2	3	4
12.	Мал, амьтны эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ хийх:			
	— бод малд	толгой	350,0	—
	— бог малд	—"—	20,0	—
	— гахай, бусад тэжээвэр амьтанд	—"—	25,0	—
	— бүх төрлийн шувуунд	—"—	10,0	—
	— нохой, мууранд	—"—	45,0	—
13.	Сүү, сүүн бүтээгдэхүүнд:			
	— бохирдлын зэрэг тодорхойлох	нэгж дээж	10,0	40,0
	— хүчиллэг, нягтрал тодорхойлох	—"—	—	70,0
	— тослог тодорхойлох	—"—	—	30,0
	— хуурай бодис тодорхойлох	—"—	—	96,0
	— пастеризац хийсэн эсэхийг тодорхойлох	—"—	—	130,0
	Хольц тодорхойлох. Үүнд:			
	— усны хольц	нэгж дээж	—	50,0
	— гурил, цардуул	—"—	—	45,0
	— сода	—"—	—	41,0
	— антибиотик, сульфаниламидын үлдэгдэл тодорхойлох	—"—	—	270,0

1	2	3	4
— химийн элемент тодорхойлох	—"—	—	180,0
— пестицид тодорхойлох	—"—	—	360,0
Нян судлалын шинжилгээ хийх. Үүнд:			
— нянгийн бохирдлыг редуктазын аргаар тодорхойлох	нэгж дээж	—	81,0
— нянгийн ерөнхий тоог тодорхойлох	—"—	—	230,0
— стафилококк, сальнеллёз тодорхойлох	—"—	—	356,0
— брүцеллёзыг цагираг урвалаар тодорхойлох	толгой	—	55,0
— дэлэнгийн үрэвслийг тодорхойлох	—"—	—	42,0
14. Мах, махан бүтээгдэхүүнд хийх үзлэг шинжилгээ:			
— «РН»-ийн хэмжээг тодорхойлох	нэгж дээж	—	45,0
— чанарын үнэлгээ өгөх зэсийн цэнхэр, пероксидоз, нессерийн урвалаар тодорхойлох	—"—	—	90,0
— төрлийг тодорхойлох	нэгж дээж	—	30,0
— өвчтэй болон үхсэн малын махыг тодорхойлох	—"—	—	280,0
— амино-шүүлтрийн азот тодорхойлох	—"—	—	100,0
— өөхний дэгдэмхий хүчил тодорхойлох	—"—	—	210,0
— нитрат, нитрит тодорхойлох	—"—	—	174,0
— үхэр, тахайн маханд финноз тодорхойлох	—"—	20,0	70,0
— гахай, бусад амьтны маханд трихинеллёз	—"—	—	120,0

1	2	3	4
тодорхойлох			
— бруцеллёз, сүрьеэгийн шинжилгээ хийх	—"—	—	197,0
— антибиотик, сульфаниламидын үлдэгдэл тодорхойлох	—"—	—	215,0
— химийн элемент (хүнд металл) тодорхойлох	—"—	—	210,0
Нян судлалын шинжилгээ хийх Үүнд:			
— бактериоскопын шинжилгээ хийх	нэгж дээж	—	63,0
— бактерийн ерөнхий тоог тодорхойлох	—"—	—	255,0
— хоолны хордлого үүсгэх бактеруудыг тодорхойлох (стафилококк, сальмонеллёз, ботулизм)	—"—	—	650,0
Өндөг шинжлэх:			
— дурангаар шинжлэх	ширхэг	—	6,0
— нян судлалын шинжилгээ (сальмонеллёз) хийх	—"—	—	45,0
15. Мал, амьтны гаралтай түүхий эд, малын тэжээлд үзлэг, шинжилгээ, арчутгал, халдваргүйжүүлэлт хийх.			
Үүнд:			
а) мал, амьтны гаралтай түүхий эдэд:			
— арьс, шир, бүх төрлийн ангийн үсэнд мэдрэхүйн эрхтний үзлэг хийх	ширхэг тутамд	5,0—9,0	—

1	2	3	4
— яс, эвэр, туурай, бүх төрлийн ноос, ноолууранд хийх мэдрэхүйн эрхтний үзлэг (ан олзворын зүйлс)	кг тутамд	3,0—6,0	—
— арьс, шир, эвэр, бүх төрлийн ноос, ноолууранд асколын шинжилгээ хийх	нэгж дээж	—	63,0
— паразитологийн шинжилгээ хийх	—"—	10,0	45,0
— радиологийн шинжилгээ хийх	—"—	—	480,0
б) малын тэжээлд шинжилгээ хийх:			
— бүх төрлийн тэжээлд мэдрэхүйн эрхтний үзлэг хийх	100 кг тутамд	6,0	—
Мөөгөнцрийн шинжилгээ хийх:			
— бүдүүн тэжээлд	нэгж дээж	—	2530,0
— хүчит тэжээлд	—"—	—	2010,0
— амьтны гаралтай тэжээлд	—"—	—	1790,0
— бүдүүн, хүчит тэжээлд нитрат, нитритийн хэмжээг тодорхойлох	—"—	—	896,0
— амьтны гаралтай тэжээлд хэт исэл тодорхойлох	—"—	—	1199,0
— амьтны гаралтай тэжээлд хлорид тодорхойлох	—"—	—	816,0
— амьтны гаралтай тэжээлд хүчлийн тоог тодорхойлох	—"—	—	1065,0
— малын тэжээлд хлор органик, фосфор			

1	2	3	4
органик нэгдэл тодорхойлох	—"—	—	1120,0
— гарнизон тодорхойлох	—"—	—	1250,0
— малын тэжээл, эмгэгт эрхтэнд пестицидийг шингэн давхраат хроматографын аргаар тодорхойлох	—"—	—	1390,0
— малын тэжээлд цацрагийн нийлбэр «бетта» идэвхийг радиометрээр тодорхойлох	—"—	—	580,0
— мал, амьтны ясанд стронци-90 тодорхойлох	—"—	—	1795,0
16. Ариутгал халдваргүйжүүлэлт хийх:			
— түүхий эд, тэжээлд	$м^2$	—	4,0
— байр, талбайд	—"—	—	60,0
— автомашин (чиргүүлтэй)-д	ширхэг	—	200,0 (350)
— тракторт	—"—	—	150,0
— суудлын автомашинд	—"—	—	100,0
— нисэх онгоцонд	—"—	—	1500,0
— чингэлэг (контейнер)-т	$м^3$	—	10,0

Гурав. **Мал эмнэлгийн эм бэлдмэл шалгах улсын нэгдсэн лабораторийн үйлчилгээ**

№	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	Төлбөрийн хэмжээ (төгрөгөөр)
17.	Хатаасан биобэлдмэл	1000 тун	269,0
18.	Шингэн бэлдмэл	литр	154,0
19.	Хуурай эм, бэлдмэл	кг	7,0

Дөрөв. **Үржлийн албадаас үзүүлэх ажил, үйлчилгээ**

№	Үйлчилгээний төрөл	Хэмжих нэгж	Төлбөрийн хэмжээ (төгрөгөөр)
	1	2	3
20.	Мал ангилах, чанарын үнэлгээ өгөх;		
а)	ангийн ангилалт		
	— бод	толгой тутам	10,0
	— бог	—"—	5,0
б)	хувьсийн ангилалт:		
	— буур, азарга	—"—	40,0
	— инээ, гүү	—"—	30,0
	— махны чиглэлийн үнээ	—"—	60,0
	бух	—"—	80,0
	— сүү, сүү-махны чиглэлийн малд:		
	— үнээ	толгой тутам	100,0
	— бух	—"—	120,0
	— хуц, ухна	—"—	30,0
	— эм хонь, ямаа	—"—	15,0
	— бодон	—"—	30,0
	— мэгж	—"—	20,0
21.	Малд хээлтүүлэг хийх:		
а)	гүн хөлдөөсөн үрээр		
	— үнээ	1 удаа үрлэх	250,0
	— эм хонь, ямаа	—"—	60,0

1	2	3
— мэгж	—"—	30,0
б) гардан хээлтүүлэг		
— үнээ	1 удаа	450,0
— ингэ	—"—	300,0
— гүү	1 удаа	350,0
— эм хонь, ямаа	—"—	60,0
— мэгж	—"—	160,0
в) эцэг малаас үр авч чанарын үнэлгээ тогтоох:		
— бод	1 удаа	3000,0
— бог	—"—	1500,0
— бодон	—"—	1500,0
22. Малын хээл тодорхойлох:		
а) шулуун гэдсээр суйлах (бодонд) аргаар	толгой тутам	150,0
б) тэмтрэх (богт) аргаар	—"—	20,0
23. Хяналтын судалгаа хийх		
а) хяргалт, самналт:		
— тэмээний ноос	толгой тутам	10,0
— хонины ноос	—"—	5,0
— ямааны ноолуур	—"—	5,0
— хурганы ноос	—"—	5,0
б) хяналтын саам		
бод	—"—	5,0
бог	—"—	3,0
24. Малд үржлийн үзлэг заазлалт хийх:		
— бод	—"—	20,0
— бог	—"—	5,0
25. Өсвөр хээлтүүлэгч шилэн сонгох (1 удаагийн үзлэгээр):		
— бод	—"—	300,0
— бог	—"—	60,0
Мах, сүү, ноос, ноолуур, гэжээлд лабораторийн иж бүрэн шинжилгээ хийх үнэлгээ		

1	2	3
26. Төрөл бүрийн тэжээлд зоотехникийн задлан шинжилгээ хийх	нэгж дээж	2500,0
27. Маханд ерөнхий химийн шинжилгээ хийх	—"—	900,0
28. Сүүнд химийн шинжилгээ хийх	—"—	400,0
29. Ноос, ноолуурын дээжинд лабораторийн задлан шинжилгээ хийх	—"—	5000,0

Тайлбар: Энд ороогүй ажил, үйлчилгээг адил төстэй үзүүлэлтүүдтэй дүйцүүлж тооцож болно.

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

1994 оны 12 дугаар сарын 31-ний өдөр | Улаанбаатар хот

Дугаар 206

ТОГТООЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан «их хэмжээ»-г нэг мөр ойлгон зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Дээд шүүхийн 1993 оны 12-р сарын 9-ний өдрийн 49 дүгээр тогтоолын хоёр дахь хэсгийн 11 дүгээр зүйлд заасан «100000» гэснийг «1500000» болгон өөрчилсүгэй.

Ерөнхий шүүгч Д. ДЭМБЭРЭЛЦЭРЭН

Шүүгч А. ДОРЖГОТОВ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

1994 оны 12 дугаар сарын 31-ний өдөр | Улаанбаатар хот

Дугаар 207

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

Нэг. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай Монгол Улсын хууль (цаашид «хууль» гэх) зарим зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар тайлбарласугай:

1. Хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь заалтын «үл хөдлөх хөрөнгө»-д гадаадын хөрөнгө оруулагчийн хувь хөрөнгө

болгон оруулж байгаа газраас салган хэрэглэж болохгүй. Барилга байгууламж, түүний дотор геологи хайгуул, судалгааны үйлдвэрлэлийн бэлтгэл ажлын хүрээнд бий болгосон байгууламж, бусад зүйл, хөдлөх хөрөнгөд технологийн тоног төхөөрөмж, машин механизм, багаж хэрэгсэл, эд анги сэлбэг, түүнчлэн зураг төсөл, геологи хайгуул судалгааны ажлын санхүүжилтэд оруулсан хөрөнгө, үйлдвэрлэл явуулах, удирдахад шаардагдах түүхий эд материалыг ойлгоно.

2. Хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн «... нийтэд мэдэгдэх үеийн үнэлгээ ...»-д хөрөнгө оруулагчид хөрөнгөө дайчлан гаргуулсан буюу дайчлан гаргуулах тухай нийтэд мэдэгдэх үед Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу гаргасан тайлан тэнцэлд тусгагдсан үнэлгээг ойлговол зохино.

3. Хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дугаар хэсгийн «... бүртгүүлсэн өдөр ...»-т гадаадын хөрөнгө оруулалттай тухайн аж ахуйн нэгж нь хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Улсын татварын ерөнхий газарт бүртгүүлсэн өдрийг ойлгоно.

4. Хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 7-д заасан «тусгай зөвшөөрөл»-д Монгол Улсын хууль тогтоомжид зааснаар тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлбэл зохих үйл ажиллагаа эрхлэх буюу ийм ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж байгуулах тохиолдолд эрх бүхий байгууллагаас урьдчилан авсан зөвшөөрлийг ойлгоно.

5. Хуулийн 12 дугаар зүйлийн 10 дахь хэсгийн «... дүрмийн сан, гэрээ дүрэмдээ оруулах нэмэлт, өөрчлөлт ...» гэдэгт хамтран хөрөнгө оруулагчид тохиролцож, эсхүл гадаадын хөрөнгө оруулагч дангаараа аж ахуйн нэгжийн дүрмийн сан, гэрээ, дүрмэндээ Худалдаа, Үйлдвэрийн яамны зөвшөөрснөөр оруулсан нэмэлт, өөрчлөлтийг ойлгоно.

6. Хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн «... дүгнэлтийн аль нэгийг зөрчиж байгаа нь нотлогдвол ...» гэснийг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа бүхэлдээ буюу зарим хэсэг нь анх бүртгүүлэхдээ буюу дүрмийн сан, гэрээ, дүрмэндээ нэмэлт, өөрчлөлт оруулахдаа гаргасан өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг, тэдгээрт тусгасан үзүүлэлт, заалт, тооцоо, бусад бүрдэлбэрийн талаарх эрх бүхий байгууллагаас 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан чиглэлээр гаргасан дүгнэлтээс зөрсөн бөгөөд энэ нь эрх бүхий байгууллагын үзлэг шал-

лт (дүгнэлт)-ээр илэрч нотлогдсон байхыг хамааруулна. ıэ зүйл, хэсгийн «үйл ажиллагааг түр буюу бүрмөсөн зогсоож болно» гэдэг дээр дурдсанаар нотлогдсон зөрчлийг инж байдал, хор уршгийг харгалзан Худалдаа үйлдвэйн яамны шийдвэрээр тухайн аж ахуйн нэгжийн үйл киллагааны аль нэг хэсгийн зөрчлийг арилгах хүртэл торхой хугацаагаар түр, эсхүл бүрмөсөн зогсоохыг хамаауулна. Үүнээс бусад тохиолдолд гадаадын хөрөнгө оруулттай аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг Монгол Улсын : ахуйн нэгжийн тухай хуульд заасан үндэслэл, журмын гуу зогсоож болно.

7. Хуулийн 17 дугаар зүйлийн 5 хэсэгт заасан «гуйвуулж лох орлого, ашиг»-т аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг рмөсөн зогсоож эцсийн тооцоо хийсний дараа үлдсэн ашиг хуваарилахад гадаадын хөрөнгө оруулагчид ногдох зь хүртэгчийн орлого, хувьцааны ногдол ашиг, мөн эд өнгө, үнэт цаас борлуулсан болон эд хөрөнгийн эрхээ лжүүлсэн, аж ахуйн нэгжээс гарч ногдох ашгаа авсан, ан буулгаснаас өөртөө ногдох орлогоо авсан зэргээс он орлогын хэсэг хамаарна.

8. Хуулийн 19 дүгээр зүйлийн 1 хэсэгт «... аж ахуйн ж байгуулахыг зөвшөөрсөн өдөр»-ийг гадаадын хөрөнгө улалттай аж ахуйн нэгж байгуулахыг зөвшөөрсөн Худал-, үйлдвэрийн сайдын тушаал гарсан өдөр гэж ойлгоно.

9. Хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн «дүрмийн д оруулах технологийн тоног төхөөрөмж» гэдэгт гадаа- хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн эрхлэхээр зөвэрөгдсөн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад технологийн ьд шаардагдах, хөрөнгө оруулагчаас дүрмийн санд хувь өнгө болгон оруулахаар гэрээндээ тусган гадаадаас улж буй тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, үйлдвэрлэл, чилгээний зориулалтын тоноглол хамаарна.

10. Хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан далдаа, нийтийн хоолны ... аж ахуйн нэгж» гэдэгт ний болон жижиглэнгийн худалдаа, нийтийн хоолны чилгээ эрхэлдэг бүх төрлийн аж ахуйн нэгжийг, мөн ийн «үйлдвэрлэлийн зориулалттай оруулах эд материал, анги, сэлбэг хэрэгсэл» гэдэгт гадаадын хөрөнгө оруттай тухайн аж ахуйн нэгж, байгуулах зөвшөөрөлд сны дагуу эрхэлбэл зохих өөрийн үйлдвэрлэл явуулахад нологийн хувьд шаардагдах (бусдад дамжуулан худал-

дах, ажиллагчдын болон аж ахуйн хэрэгцээнд зориулснаас бусад) түүхий эд, материал, эд анги, сэлбэг хэрэгслийг хамруулан ойлгоно.

11. Хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан «үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж эхэлсэн өдрөөс» гэдгийг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж эрхлэхээр зөвшөөрөгдсөн үйлдвэрлэл, үйлчилгээгээ явуулж анхны бүтээгдэхүүн гаргаж, үйлчилгээ үзүүлж эхэлсэн өдрийг хэлнэ. Хэрэв хэд хэдэн төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх бол тэдгээрийн аль нэгийг явуулж буюу үзүүлж эхэлсэн өдрөөр тооцно.

12. Хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн «үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 50-иас дээш хувийг экспортолж байвал» гэдэгт тухайн аж ахуйн нэгж Худалдаа үйлдвэрийн яамнаас зөвшөөрсөн үйлдвэрлэлийн салбарт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний жил бүрийн борлуулалтын орлогын 50-иас дээш хувийг гадаадад гаргасан бүтээгдэхүүний орлогоос олсон байхыг ойлгох бөгөөд гадаадад гаргасан бүтээгдэхүүний орлого уул аж ахуйн нэгжийн Монгол Улс дахь банкны дансанд орсноор тодорхойлно. Хэрэв хэд хэдэн төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бол тэдгээрийн нийлбэрээр авч үзнэ.

13. Хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн «өөрт ногдох орлого» гэдгийг хоёр талын оролцогчдоос тухайн аж ахуйн нэгжийн дүрмийн сан бүрдүүлэхэд оруулсан хөрөнгийн хэмжээг харгалзан хамтарсан аж ахуйн нэгжийн жилийн ашиг хуваарилалтаар гадаадын хөрөнгө оруулагчид үлдсэн ногдол ашиг (дивиденд)-г хэлнэ.

14. Мөн зүйлийн тухайн аж ахуйн нэгжид дахин хөрөнгө оруулалт хийвэл оруулсан хөрөнгийн хэмжээгээр» гэдэгт хамтарсан аж ахуйн нэгжээс Монгол Улсын хууль, гэрээ, дүрмэнд заасан журмын дагуу баталсан зураг төсвийн (төслийн) дагуу тухайн үйлдвэрлэлийг өргөтгөх, шинэчлэх, хүч чадлыг нэмэгдүүлэх, шинэ техник технологи нэвтрүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлыг гадаадын оролцогчийн ногдол ашгаас санхүүжүүлсэн хэмжээг (гүйцэтгэлийг) хамааруулна.

15. Хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт «... үйл ажиллагааны үндсэн салбар» гэдэгт хэрэв аж ахуйн нэгж хэд хэдэн салбарын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа

бол тэдгээрийн дотроос хамгийн их хэмжээний хөрөнгө оруу-
талт хийсэн салбарыг ойлгоно.

16. Хуулийн 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 1, 4 «Мон-
голын талын өмчлөгч» гэдэг нь төрийн өмчийн газрын өмч-
лөгч болох тухайн аймаг, нийслэлийн засаг дарга гэж
ойлгоно.

Хоёр. Хуулийн 20 дугаар зүйлд заасан үйлдвэрлэлийн
салбарыг «эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны
олон улсын салбарын стандарт ангилалд тулгуурласан
индэсний ангиллыг батлагдан гартал доор дурдсанаар ойл-
ож байхаар тогтоосугай:

1. «Цахилгаан дулааны станц гэдэгт гадагш худалдан
орлуулах зорилгоор төрөл бүрийн эх үүсвэрээс цахилгаан
а дулааны эрчим хүчийг дагнан үйлдвэрлэх, хослон үйлд-
эрлэх чиглэлтэй усан, салхин, нарны дизелийн, дулааны
олон атомын цахилгаан дулааны станц барих, ашиглах
албар.

2. «Цахилгаан, дулаан дамжуулах шугам сүлжээ»-ний
албар гэдэгт, цахилгаан, дулааны эрчим хүчийг нэгдсэн
үлжээ болон хэрэглэгчид хүргэх шугамыг барих, ашиглах
албар.

3. «Авто замын барилга, байгууламж»-ийн салбарт ...
сфальт буюу бетонон хучилттай зам, гүүр, туннель, хоолой
эрэг замын барилга байгууламж барих ашиглах салбар.

4. «Төмөр замын барилга байгууламж»-ийн салбар гэ-
эгт агаарын хөлөг үйлдвэрлэх, засварлах, агаарын хөл-
ийн удирдлагын албаны байгууламж, нисэх буудал, нисэх,
үух талбайн зурвас барих, ашиглах салбар.

5. «Агаарын тээврийн барилга байгууламж»-ийн салбар
эдэгт агаарын хөлөг үйлдвэрлэх, засварлах, агаарын хөл-
ийн удирдлагын албаны байгууламж нисэх буудал, нисэх,
үух талбайн зурвас барих, ашиглах салбар.

6. «Инженерийн барилга, байгууламж»-ийн салбар гэ-
эгт инженерийн хийцтэй услалтын систем, хөргөлттэй
юрь болон төвлөрсөн хот, суурин газрын инженерийн шу-
м сүлжээ байгуулах салбар.

7. «Телекомуникацийн үндсэн сүлжээ»-ний салбар гэдэгт
аарын шугам, радиорелейны болон сансрын хиймэл да-
ул, кабелийн холбоо, мэдээллийн барилга байгууламж
ийгуулах ашиглах салбар.

8. «Үнэт металлаас бусад эрдсийн түүхий эд» гэдэгт алт,

мөнгө, платина, родий, рутений, ридий, осмий, палладиг
саас (эдгээр нь дагалдах байдалтай бол хамаарахгүй) б
сад бүх төрлийн эрдсийн түүхий эд олборлох, боловсру
лах салбар.

9. «Нефть, хатуу түлш олборлох, боловсруулах» салбар
газрын тос, бүх төрлийн нүүрс, занар олборлох, боловсру
лах, газрын тос түүнээс гаргаж авсан бүтээгдэхүүнийг да
жуулах хоолой барьж байгуулах салбар.

10. «Металлургийн үйлдвэрлэл»-ийн салбарт өнгөт б
лон хар металлын хүдэр боловсруулах баяжмал гаргах, м
талл үйлдвэрлэх салбар.

11. «Химийн үйлдвэрлэл»-ийн салбарт эрдсийн бордо
данс, сод, хүчил, эм эмчилгээний зориулалттай химийн б
дис, үнэртэн, гоо сайхан, угаах, өнгөлөх, уул уурхайн тэ
рэх бодис, микробиологийн бүтээгдэхүүн, фермент, це
люлоз, цаас, хуванцар, будаг, лак, каучук, резин үйлдвэ
лэх болон бусад химийн үйлдвэрлэл эрхлэх салбар.

12. «Төмөрлөгийн үйлдвэрлэл»-ийн салбарт ахуйн болс
үйлдвэрлэлийн зориулалттай бүх төрлийн металл эдлэ
хийц, эд анги сэлбэг үйлдвэрлэх салбар.

13. «Машины үйлдвэрлэл»-ийн салбарт бүх төрлийн м
шин, механизм, тэдгээрийн түгээмэл зориулалттай хийц, и
бүрдэл үйлдвэрлэх үгсрах салбар.

14. «Электроникийн салбар»-т аж ахуйн болон үйлдвэ
лэл, технологийн зориулалтай төрөл бүрийн электрон бага
хэрэгсэл, тоног төхөөрөмж, тэдгээрийн эд ангийг үйлдвэ
лэх үгсрах салбар.

Гурав. Энэ тогтоолын «хоёрт» заасан үйлдвэрлэлий
салбарт тухайн салбарын үндсэн үйлдвэрлэлээс гадна тэ
гээрийн хэвийн ашиглалтыг хангах засвар, үйлчилгээ хий
зориулалттай үндсэн үйлдвэрлэлийн барилга байгуула
жийн нэгж зэрэг буюу нэгдсэн зураг төсөв, хөрөнгө оруула
таар баригдаж байгаа үйлдвэрлэлийн туслах салбарыг х
мааруулан ойлгоно.

Ерөнхий шүүгч **Д. ДЭМБЭРЭЛЦЭРЭ**

Шүүгч **Д. ДАНЗАНДОРЖ**

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч **Н. Ринчиндорж**

Нарийн бичгийн дарга **Сан. Жаргалсайхан**

Гишүүд **Т. Баасансүрэн**
Ч. Бавуу
Б. Ганбат
Б. Янжинлхам

Техник редактор **Т. Сарантуяа**

Уншиж хянасан **Сан. Жаргалсайхан**
Б. Янжинлхам

Үйлдвэрт шилжүүлсэн 1995 оны 3-р сарын 6-нд. Өрөлтөд 1995 оны 3-р сарын 6-нд. Хэвлэлтэд 1995 оны 3-р сарын 31-нд. Хэвлэлийн хуудас 8,75. Хэвлэсэн тоо 4800 ширхэг.

Засгийн газрын хэвлэх үйлдвэр